

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

**ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЭТГҮҮЛ**

**2022 №2 (81)
20 дахь жилдээ**

СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Пүрэвдорж БАТБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жигжидсүрэн БОЛДБААТАР
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Галбат ГАНТӨМӨР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Очирхуяг ЗОРИГТ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Чойжил НЯМСҮРЭН
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Тамжид ОЮУНЧИМЭГ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Заяатхүү ТӨРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХВАН И ГАБ
ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕСС

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Улсын бүртгэлийн дугаар 237

ISSN 2957-4285

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батсүх АЛТАНСҮХ
ДОКТОР (Ph.D)

Шаравдорж АРИУНБИЛЭГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Лувсан БАТ-ОЧИР
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Нямдорж БАТСАЙХАН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жаргалсайхан МӨНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Намжилдорж МӨНХЗУЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Думбурай МЯГМАРЦЭРЭН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бадарч НАРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жутьяа НЯМДУЛАМ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батхишиг ЛХАГВАСҮРЭН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Буриад ЛХАГВАРАГЧАА
ДОКТОР (Ph.D)

Шархүү ЧУЛУУНБАТ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батзэвэг ЭНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Магмадорж ЭРДЭНЭБАЯР
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН:

Хаянхярваа БАТБАЯР
МАГИСТР

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

Бэгзсүрэн ЖАМСРАН

ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Интернэтийн хэрэглээ ба дэлхийн зарим улсын эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээ	<i>Т.Туяа</i>	5
Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарах асуудал /Баян-Өлгий аймгийн жишээн дээр/	<i>Ш.Ержан</i>	10

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид залилах гэмт хэргийг хуульчилж ирсэн уламжлал, онцлог	<i>Ж.Мөнхболд Г.Ууганболор Я.Батханд</i>	18
--	--	-----------

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Дундад зууны Монгол Улс ба мөрдөн шалгах ажиллагаанд хамаарах эх сурвалжийн судалгаа /Түүхийн философийн зарим ухагдахуун/	<i>Н.Манлайбаатар</i>	27
--	-----------------------	-----------

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал	<i>Д.Булган Г.Ариунгэрэл</i>	35
Цагдаагийн алба хаагчийн ажлын гүйцэтгэлийг урамшуулж буй нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ	<i>Ц.Чингүнжав</i>	44
Албаны нохой ашиглах сургалтын өнөөгийн байдал, анхаарах асуудал	<i>Д.Батдаваа</i>	55
Зориулалтын ачигч, чирэгч авто машинаар тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлдэг компаниудын үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ	<i>М.Бат-Эрдэнэ</i>	61
Зөрчил гаргасан согтуурсан этгээдийг эрүүлжүүлэх нь хүний эрхийн зөрчил болох нь	<i>Н.Сайнбаяр</i>	72

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ БА ДЭЛХИЙН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Т.Туяа

*Цагдаагийн сургуулийн сургалтын
арга зүйч, цагдаагийн дэд хурандаа*

Монгол Улсад и-мэйлийн үйлчилгээг нэвтрүүлж, Датаком ХХК сүлжээний холболтыг 1994 оноос эхлүүлсэн бөгөөд улмаар 1996 оны 1 дүгээр сарын 17-ны өдрөөс Монгол Улс 24 цагийн интернэтийн сүлжээнд холбогдсон.¹

Мэдээллийн технологийн салбарт гарч буй мэдээлэлжүүлэлтийн хүрээн дэх шинэчлэл, хувьсалын үр дүнд интернэт нь дэлхийн хүн амын өдөр тутмын хэрэглээ болж, интернэт сургалт, хурал, хэлэлцүүлэг, худалдаа, электрон шууданг ашиглаж байна.

"Мэдээллийн технологи" гэж компьютер, харилцаа холбооны сүлжээ ашиглан цахим өгөгдлийг үүсгэх, боловсруулах, хадгалах, дамжуулах, солилцох, үйлчилгээ үзүүлэх, бусад тоног төхөөрөмжтэй холбогдох бүхий л үйл ажиллагаа юм.

Интернэт нэвтэрснээр HTML (Hyper Text Markup Language), Web, Server, Router, Host, Client, Cloud, Connection зэрэг ойлголт гарч ирснээр хэрэглэгчдийн хоорондын утастай болон утасгүй интернэтийг байнгын цахим орчин дахь харилцаа өргөжин тэлэхийн хэрээр эрх зүйн орчин бий болсон. Иймд интернэтийн мэдээлэл нь эрх зүйн салбарын дараах орчин хүрээнд нэвтэрч эхлээд байна.

- Электрон шуудангаар харилцах;
- Цахим болон тоон гарын үсэг;
- Хууль тогтоомжийн системчлэн төрөлжүүлэх, хууль, хуульчилсан акт, олон улсын гэрээг ашиглах, хэрэглэх нөхцөлийг хангах;
- Интернэт номын санг ажиллуулах.

Интернэт нь нэг талаас хэрэглэгч, үйлчлүүлэгч нарт мэдээлэлтэй харилцах өргөн боломжийг олгож, хуулиар зөвшөөрөгдсөн эрх зүйн харилцааг бий болгодог.

Нөгөө төлөөс интернэтийн сүлжээнд байгаа мэдээллийн технологид нэвтрэх, хэрэглэх улмаар түүнийг ашиглах нөхцөл нь технологийн болоод хууль зүйн зарим хязгаарлалтаар зохицуулагдахаас аргагүй байдалд хүрч байна.

Мэдээллийн харилцаанд оролцогчид нь мэдээллийн шийдэл гаргахад ямар нэгэн үйл ажиллагаа явуулахдаа эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон эрхийг эдэлж үүргээ хүлээхээс гадна хуулиар зохицуулагдсан дүрмийг заавал дагаж мөрдөх шаардлагатай юм.

Интернэт мэдээллийг хүлээж авах, ашиглах, хэрэглэхтэй холбогдсон эрх зүйн харилцааг зөвхөн үндэсний хууль, хуульчилсан актуудаар зохицуулах төдийгөөр явцуу ойлгож болохгүй бөгөөд стандарт-техникийн нөхцөл, технологийн дэвшилтэт горим, зарчмуудыг эрх зүйн зохицуулалттай болгох, олон улсын эрх зүйн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн жишиг, хэм хэмжээнүүдийг тогтоох явдал онцгой ач холбогдолтой.

Интернэт хэрэглээний орчинд мэдээллийг хууран мэхлэх, оруулах, устгах, хаах, өөрчлөх эсхүл компьютерийн мэдээлэл хадгалах хэрэгслийн үйл ажиллагаанд

¹ mn.m.wikipedia.org

оролцох, компьютерийн болон мэдээлэл харилцааны сүлжээг дамжуулалт хийх замаар бусдын эд хөрөнгийг шамшигдуулах гэсэн хуулиар зөвшөөрөгдөөгүй хэмжээг зохицуулах эрх зүйн орчин шаардлага бий болсон.

Дэлхийн зарим улсад интернэт хэрэглээг зохицуулсан хууль тогтоомжид орон энэхүү шинэ мэдээлжсэн харилцааг хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтаар бүрдүүлсэн.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 159.3 дугаар зүйл.Цахим хэрэгсэл ашиглаж залилах гэмт хэрэг

1.Цахим төлбөрийн хэрэгсэл ашиглаж залилан хийсэн бол 120 мянга хүртэл рубль эсхүл ялтны хоёр жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогын хэмжээгээр торгох эсхүл 360 цаг хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр эрхлэх, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлах, эсхүл 4 сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл нэг гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ хэргийг урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг үйлдсэн, их хэмжээний хохирол учруулсан бол хариуцлагыг хүндрүүлнэ.

3.Энэ зүйлийн нэг болон хоёр дахь хэсэгт заасан хэргийг албан тушаалын байдлаа ашиглан, мөн их хэмжээгээр үйлдсэн бол таван зуун мянган хүртэл рубль эсхүл ялтны нэгээс гурван жил хүртэл хугацааны цалин хөлс, бусад орлогны хэмжээгээр торгох, хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлаж таван жил хүртэл хугацаагаар албадан хөдөлмөр хийлгэх эсхүл, хоёр жил хүртэл хугацаагаар эрх чөлөөг хязгаарлаж, наян мянга хүртэл рубль эсхүл ялтны 6 сар хүртэл хугацааны цалин хөлс бусад орлогын хэмжээгээр торгож зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн нэг болон гурав дахь хэсэгт заасан хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл онц их хэмжээгээр хохироож үйлдсэн бол хариуцлагыг хүндрүүлнэ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн 159.6 дугаар зүйл.Компьютерийн мэдээллийн салбарт залилан хийх гэмт хэрэг

1.Компьютерийн мэдээллийн салбарт хууран мэхлэх буюу компьютерийн мэдээллийг оруулах, устгах, хаах, өөрчлөх эсхүл компьютерийн мэдээлэл хадгалах хэрэгслийн үйл ажиллагаанд оролцох, компьютерийн болон мэдээлэл харилцааны сүлжээг дамжуулалт хийх замаар бусдын эд хөрөнгийг шамшигдуулсан ...

2.Энэ хэргийг урьдчилан үгсэн тохиролцсон бүлэг үйлдсэн, их хэмжээний хохирол учруулсан бол хариуцлагыг хүндрүүлнэ.

3.Энэ зүйлийн нэг болон хоёр дахь хэсэгт заасан хэргийг албан тушаалын байдлаа ашиглан, мөн их хэмжээгээр үйлдсэн, банкны данс, цахим мөнгөний хувьд үйлдсэн бол

4.Энэ зүйлд заасан гэмт хэргийг зохион байгуулалттай бүлэг, эсхүл онц их хэмжээгээр хохироож үйлдсэн бол 10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 263а-д Компьютерийн залилан²

1.Өөртөө болон гуравдагч этгээдэд эд хөрөнгийн давуу байдал үүсгэхийн тулд буруу зохион бүтээсэн программаар, худал эсвэл бүрэн бус мэдээллээр, зөвшөөрөлгүй мэдээлэл ашиглан эсвэл үйл явцад зөвшөөрөлгүйгээр нөлөөлөх зэргээр мэдээлэл боловсруулах ажиллагааны үр дүнд нөлөөлж бусдад хохирол учруулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих буюу торгох ялаар шийтгэнэ.

2.Ийм төрлийн гэмт хэрэг үйлдэх зорилгоор компьютерийн программ үйлдвэрлэх, өөртөө олж авах буюу бусад этгээдэд олж өгөх, зарах, хадгалах эсвэл

² Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн Хууль. УБ., 2021.

бусдад үлдээх зэргээр энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт бэлтгэсэн бол гурван жил хүртэл хорих буюу торгох ялаар шийтгэнэ.³

БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 6 дугаар бүлгийн Нийгмийн хамааралтын эмх журмыг харшилсан ял. Нэгдүгээр хэсэг. Олон нийтийн эмх журмыг самууруулсан ял⁴

285 дугаар зүйл. Улсын тогтоолыг зөрчин улсын хэрэг явдал, улсын батлан хамгаалалтын бүтээн байгуулалт, оройлсон шинжлэх ухаан техник мэргэжлийн хүрээн дэх компьютерийн мэдээ сангийн системд халдан орсон байвал гурван жилээс доош хугацаатай хорих буюу хорьж хөдөлмөрлүүлэх шийтгэнэ.

Улсын тогтоолыг зөрчин өмнөх бадагт тогтоосноос гаднах компьютерийн мэдээ сангийн системд халдан орсон буюу бусад мэргэжлийн арга барилыг хэрэглэж байгаад тус компьютерийн мэдээ сангийн системд хадгалж, шийдвэрлэж байгаа буюу дамжуулж байгаа дайд-ыг олсон, эсхүл тус компьютерийн мэдээ сангийн системийг хуул бусаар эзэмдээд, үйл байдөл хүнд ноцтой байвал 3 жилээс доош хунацаатай хорих буюу хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгэж зоосоор торгохоор нийлүүлэн шийтгэх буюу дангаар шийтгэнэ. Үйл байдал нь онцгой хүнд ноцтой байвал гурван жилээс дээш долоон жилээс доош хугацаатай хорихоор шийтгэж, зоосоор торгохоор нийлүүлэн шийтгэнэ.

Компьютерийн мэдээ зангийн системд халдан орох, түүнийг хууль бусаар эзэмдэхэд тусгайлан хэрэглэх программ, багажийг хангасан, эсхүл бусад хүний компьютерийн мэдээ зангийн системд халдан орох түүнийг хууль бусаар эзэмдэх хуулийг зөрчсөн ялт ажиллагаа хийж байхыг мэдэж байгаад түүнд программ, багаж хангаад, үйл байдал нь хүнд ноцтой байвал өмнөх бадгийн тогтоол ёсоор шийтгэнэ.

286 дугаар зүйл. Улсын тогтоолыг зөрчин компьютерийн мэдээ зангийн системийн хүчин чадлыг хасаж хаясан, засаж өөрчилсөн, нэмсэн, харшилнаас болж компьютерийн мэдээ зангийн системийг хэвийн байдлаар ажиллаж чадахгүй болгоод хүнд ноцтой уршиг татсан байвал таван жилээс доош хугацаатай хорих буюу хорьж хөдөлмөрлүүлэхээр шийтгэнэ. Улсын тогтоолыг зөрчин компьютерийн мэдээ зангийн системийн хадгалсан шийдвэрлэсэн буюу дамжуулсан дайд ба хэрэглээний программыг хасаж хаях, засаж өөрчлөх, нэмэх жолоодлогоо хийгээд хүнд ноцтой уршиг татсан байвал өмнөх бадгийг тогтоол ёсоор шийтгэнэ. Компьютерийн вирус зэрэг эвдлэгийн чанартай программыг зориуд үйлдэж, дэлгэрүүлээд компьютерийн системийг хэвийн ажиллагааг нөлөөлж, хүнд ноцтой уршиг татсан байвал нэгдүгээр бадгийн тогтоол ёсоор шийтгэнэ.

287 дугаар зүйл. Компьютерийг ашиглан мөнгөн гүйлгээний мэхлэлийн ажиллагаа хийсэн, хулгайлсан, шамшсан, албаны зоосыг нүүлгэн хэрэглэсэн улсын нууцыг хулгайлан авсан буюу бусад ялт ажиллагааг хийсэн байвал тус хуулийн холбогдол бүхий тогтоол ёсоор ял тогтоож шийтгэнэ.

Монгол Улсын хувьд мэдээллийн эрх чөлөөний хуулийг гаргах, компьютерийн сүлжээний орчин дахь интернэт-хэрэглээний эрх зүйн зохицуулалтыг бий болгох, мэдээллийн сүлжээ, мэдээллийн систем, мэдээлэлжүүлэлтийн багц хуулиудыг гаргах замаар эрх зүйн шинэчлэлийн реформыг үе шаттайгаар хэрэгжүүлэх явдал хойшлуулшгүй зорилт болж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлэг. Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг. 26.1.Кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэрэг⁵

³ Ц.Цэлмэг, Д.Майцэцэг. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2021.

⁴ Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн Хууль. УБ., 2021.

⁵ www.legalinfo.mn

1.Кибер орчинд зөвшөөрөлгүйгээр хандаж мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд нэвтэрсэн, танилцсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Кибер орчинд хууль бусаар халдаж мэдээллийг устгасан, гэмтээсэн, өөрчилсөн, засварласан, нуусан, нэмж оруулсан, хуулбарлаж авсан, ашиглах боломжгүй болгосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Кибер орчинд хууль бусаар халдаж мэдээллийн систем, мэдээллийн сүлжээг ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан, хандалтад хязгаарлалт тогтоосон, ноцтой саад учруулсан бол хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэх зорилгоор мэдээлэл хадгалагдаж байгаа төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн бол хоёр жилээс арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5.Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийн улмаас төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

6.Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг:

6.1.Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн;

6.2.Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулж байгаа мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд; төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний албан болон тусгай хэрэглээний сүлжээнд; онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд халдсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

26.2.Кибер орчинд хууль бусаар халдах, программ хангамж, техник хэрэгсэл бүтээх, бэлтгэх, борлуулах, ашиглах, тараах

1.Энэ хуулийн 26.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийг үйлдэх зорилгоор мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай программ, техник хэрэгслийг бэлтгэсэн, борлуулсан; программ хангамжийг тусгайлан зохиосон, зориудаар ашигласан, санаатай тараасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг:

2.1.Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн;

2.2.Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулж байгаа мэдээллийн системд; төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний албан болон тусгай хэрэглээний сүлжээнд; онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд халдсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Монгол Улсын Хүний хувийн мэдээлэл хадгалах тухай хуулийн 6 дугаар бүлэг. Мэдээлэл хамгаалах эрх бүхий байгууллага⁶

⁶ www.legalinfo.mn

25 дугаар зүйл.Цахим орчинд мэдээлэл хамгаалах талаарх цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

25.1.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цахим орчинд мэдээлэл хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.1.1.Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, олон нийтэд сурталчлан таниулах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

25.1.2.Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журмыг батлах;

25.1.3.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зориулалттай мэдээллийн системийн аюулгүй байдал алдагдсан, кибер халдлагад өртсөн талаар мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн мэдэгдлийг хүлээн авч бүртгэн, шаардлагатай арга хэмжээг даруй авах.

Санал

Судалгааны үр дүнд үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зохих чанарын харилцаа холбооны үйлчилгээг авах баталгааг хангах;

2.Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зориулалттай мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах;

3.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг идэвхжүүлэхэд цахим засаглалыг хөгжүүлэх хууль тогтоомжид үнэлгээ, дүн шинжилгээ хийх, сайжруулах, шинээр боловсруулах;

4.Цахим орчинд хүүхдийг аливаа зохисгүй агуулга бүхий мэдээ, мэдээлэл, контентоос хамгаалах арга хэмжээ авах;

5.Цахим орчинд хувийн мэдээллийг хамгаалах, цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төр болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах-зэрэг болно.

Ашигласан материал

- Монгол Улсын Эрүүгийн хууль УБ., 2017 он
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль. УБ., 2021 он
- Ж.Эрдэнэбулган нар. Монгол, Орос, Хятад, Герман Улсын Эрүүгийн хууль. УБ., 2021 он
- Ц.Цэлмэг, Д.Майцэцэг. Харьцуулсан эрүүгийн эрх зүй. УБ., 2021 он
- Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2018 он
- Д.Баярсайхан. Эрүүгийн процессын эрх зүй. УБ., 2020 он
- www.Legalinfo.mn
- www.wikipedia.org
- www.crc.gov.mn

**МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ АЖЛЫН ҮР НӨЛӨӨГ
ДЭЭШЛҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ
/Баян-Өлгий аймгийн жишээн дээр/**

*Ш.Ержан
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн хошууч*

Товч агуулга. Монгол Улсын хэмжээний статистик мэдээллээс үзэхэд, мал хулгайлах гэмт хэргийн гаралт тогтмол өссөн үзүүлэлттэй байх бөгөөд цаашид өсөх хандлагатай байна. Энэхүү өгүүлэлд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байдал, Баян-Өлгий аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх арга замын талаар авч үзсэн.

Түлхүүр үг. Мал, мал хулгайлах гэмт хэрэг, ял, малчдын бүлгэм, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, хяналтын цэг.

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуульд “Мал сүрэг бол үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна”⁷ гэж заасан бөгөөд УИХ-аас 2004 онд Мал хулгайлахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийг баталсан.

Монгол Улсын хэмжээнд үйлдэгдэж буй хулгайлах гэмт хэргийн дийлэнх хувийг мал хулгайлах гэмт хэрэг эзэлж байна. Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд ихэвчлэн эрхэлсэн тодорхой ажилгүй, амар хялбар аргаар мөнгө олох сонирхолтой, шунахайн сэдэлтэй үйлдэж байгаа бөгөөд энэ төрлийн гэмт хэргийг сүүлийн жилүүдэд зохион байгуулалттайгаар тээврийн хэрэгсэл, галт зэвсэг ашиглах, бүлэглэн үйлдэх явдал нэмэгдэх хандлагатай байна.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогыг оновчтой болгох, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутагт малчдын оролцоотойгоор оновчтой зохион байгуулах шаардлага үүсэж байна.

Мал хулгайлах гэмт хэргийн гаралт тогтвортой буурахгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө хангалтгүй байгаатай холбоотой.

Үндсэн хэсэг

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг гэдэг нь өмчлөх эрхийг зөрчсөн буюу бусад аргаар өмчлөгчид эд хөрөнгийн хохирол учруулсан эсхүл тийм хохирол учруулахаар заналхийлсэн, Эрүүгийн хуульд заасан, санаатай буюу болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүй юм.⁸

Өнөөгийн нөхцөлд өмчийн хэлбэрээр /төрийн, нийтийн, хувийн/ үл хамааруулан хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг хүчтэй болгоход ихээхэн анхаарч байна.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн ихэнх нь материаллаг бүрэлдэхүүнтэй, өөрөөр хэлбэл, объектив тал нь нийгэмд аюултай үйлдэл /эс үйлдэхүй/ болон эд хөрөнгийн хохирол, тэдгээрийн хоорондын шалтгаант холбоо гэсэн заавал байх гурван шинжээс бүрдэнэ.

⁷ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

⁸ Болдбаатар Ж. Эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/. УБ. 2016. 112 дахь тал

2015 оны Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлд мал хулгайлах үйлдлийг бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргээс тусад нь бие даасан байдлаар хуульчилж, оногдуулах ялын бодлогыг тодорхойлсон нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын илэрхийлэл юм.⁹

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 2.1-д “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ”¹⁰ гэж заасан.

Монгол Улсад бүртгэгдсэн нийт мал хулгайлах гэмт хэргийн 67.2%-ийг бүлэглэн үйлдсэн байдаг бол энэ төрлийн гэмт хэргийг ихэвчлэн эрхэлсэн тодорхой ажилгүй, бүрэн бус дунд боловсролтой 26-40 насны иргэд үйлдсэн байна. Гэмт этгээдүүдийн 50 орчим хувь нь давтан гэмт хэрэг үйлдсэн байдаг.¹¹

Орон нутгийн мал бүхий иргэд нь өөрийн өмчлөлийн мал сүргийг бэлчээрт олон хоногоор хариулгагүй орхидог нь гэмт этгээдүүдэд гэмт хэрэг үйлдэх нөхцөл боломжийг бүрдүүлж байна. Нөгөөтэйгүүр аймаг орон нутаг, сумдын төр захиргааны байгууллагууд малчдад холбогдох хууль тогтоомжийг мэдээлэх, сурталчлан таниулах, мал хулгайлах гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ажлыг хангалтгүй зохион байгуулж байна гэж үзэж болно.¹²

Монгол Улсад хамгийн ихээр бүртгэгдэж буй гэмт хэрэг бол хулгайлах гэдэгтэй судалгаанд оролцогчид (43.3%) санал нэгдсэн бөгөөд хулгайлах гэмт хэргийн төрлүүдээс орон байрны (54.4%), малын (54.1%), халаасны (42.3%) хулгайлах гэмт хэрэг маш их бүртгэгдэж байна.¹³

Мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулах, гэмт халдлагаас мал сүргийг хамгаалах, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг өргөн хүрээнд зохион байгуулах, сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлага өнөөдөр тулгарч байна.

Монгол Улсад мал хулгайлах болон алдуул мал завших гэмт хэргийг сүүлийн 4 жилийн байдлаар авч үзвэл, Эрүүгийн хуулийн 17.5 дугаар зүйлд заасан “Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших” гэмт хэрэг 2018 оноос хойш 3 жил дараалан буурсан боловч 2021 онд 598 гарч, 94 нэгж буюу 17.4%-аар өссөн байна.

Харин мал хулгайлах гэмт хэргийг сүүлийн 4 жилийн байдлаар авч үзвэл, Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлд заасан “Мал хулгайлах” гэмт хэрэг 2018 онд 1096 бүртгэгдэж байсан бол 2019 онд 1809 бүртгэгдэж, 713 нэгж буюу 65.1%-иар өсөж, 2020 онд 768 нэгж буюу 42.5%-иар, 2021 онд 736 бүртгэгдэж, 305 нэгж буюу 29.3%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.¹⁴ Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт №1

⁹ Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2018. №3. Б.Баяндүүрэн. “Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого: өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх асуудал”

¹⁰ Төрийн мэдээлэл. 2004. №23. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль

¹¹ Police.gov.mn

¹² <https://www.presscenter.mn/Niigem/niigmiin-medee/engiin-medleg-8>

¹³ Г.Оюунболд. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. УБ.2018. 11 дэх тал

¹⁴ <https://police.gov.mn>. ЦЕГ-ын статистик тоо мэдээнээс хэсэгчилэн авав.

№	Гэмт хэрэг	2018	2019	Нэгж	Өсөлт, бууралт	2019	2020	Нэгж	Өсөлт, бууралт	2020	2021	Нэгж	Өсөлт, бууралт
1.	Алдаатай гүйгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших 17.5	1160	978	182	-15.7	978	504	-474	-33.8	504	598	+ 94	+ 17.4
2.	Мал хулгайлах 17.12	1096	1809	713	+65.1	1809	1041	-768	-42.5	1041	736	-305	- 29.3

Дээрх статистик тоон мэдээнээс үзэхэд, мал хулгайлах гэмт хэрэг буурсан үзүүлэлттэй байгаа боловч таслан зогсоогдохгүй байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Малын тоо толгой өсөж, бэлчээрийн болон цаг агаарын байдлаас шалтгаалсан малчдын шилжилт хөдөлгөөн, отор нүүдэл ихэссэн, мах, малын гаралтай түүхий эдийн зах зээл өргөжиж, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах аж ахуйн нэгж, байгууллагын тоо олширч, гэмт хэргийн гаралт өмнөх жилүүдээс нэмэгдэх, эрүүгийн нөхцөл байдал хүндэрч болзошгүй байна.

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад Хууль зүй, дотоод хэргийн яамны ажлын хэсэг дараах концепцийг баримталжээ. Тухайлбал,

- Шийдвэрлэхэд байнга бэрхшээл учруулж байдаг хулгайлах, дээрэмдэх, булаах зэрэг өдөр тутам гарч буй, хуулийн байгууллагын үйл ажиллагаа, ажлын ачаалалд нөлөөлж байдаг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хоёрдмол утгагүй, нарийвчлан, илүү тодорхой байдлаар хуулийн төсөлд тусгана.
- Хуулийн төсөл боловсруулахдаа гэмт хэргийг зүйлчлэхэд хүндрэл учрахгүй байхад анхаарч ижил төрлийн харилцааг хамгаалсан, гэмт хэрэгт тооцож, ял оногдуулахаар заасан хэм хэмжээний давхардлыг арилгана.¹⁵

Дээрх үзэл баримтлалын дагуу 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар мал хулгайлах гэмт хэрэгтэй холбоотой зарчмын шинжтэй дараах өөрчлөлт оржээ. Үүнд:

- Хулгайлах гэмт хэргийг шинээр томъёолохдоо хохирлын хэмжээ шаардаагүй;
- Мал хулгайлах гэмт хэргийг бусдын /өмч/ эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргээс тусгай зүйлд хуульчлан заан тусгаарлаж өгсөн.¹⁶

2002 оны Эрүүгийн хуульд мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ял нь сонгох шийтгэлүүдтэй байсан ба 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Эрүүгийн хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр “Бусдын малыг хулгайлсан бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл

¹⁵ Хууль зүйн яам. Эрүүгийн хуулийн төсөл. УБ., 2015., 12 дахь тал

¹⁶ Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2018. №3. Б.Баяндүүрэн. Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого: өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх асуудал

зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Мөн хүндрүүлэх нөхцөл байдлуудыг зааж өгсөн ба уг гэмт хэргийг олон тооны мал хулгайлж, бүлэглэж, улсын хилээр нэвтрүүлж, машин механизм ашиглаж, ноцтой хохирол, хор уршиг учруулж, гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар, байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар тус тус хорих ял шийтгэхээр хуульчилж өгчээ.

Мал хулгайлсан бол тоо харгалзахгүйгээр хорих ял эдлүүлэх, зохион байгуулалттай бүлэглэн болон давтан үйлдвэл 5-12 жилийн хорих ял ногдуулах, мал хулгайлах гэмт хэрэгт ашигласан техник, тоног төхөөрөмжийг улсын орлого болгон хурааж авах¹⁷-аар шинэ хуульд заажээ. Түүнчлэн, малаа хулгайд алдсан малчин хуучин эрүүгийн хуулиар эдийн засгийн хохирол буюу хулгайд алдсан малаа мэргэшсэн аж ахуйн нэгж (үнэлгээний компани)-ээр үнэлүүлж байсан бол шинэ хуулиар малчин өөрөө малаа үнэлэх боломжтой болжээ. Мөн Эрүүгийн хуулиар одоо малын хулгайн хөнгөн нөхцөл гэж байгаа бөгөөд энэ нь хорих ялаас чөлөөлөхгүй. Мөн малчин бусдын малыг хулгайч нарын гарт хүргэж өгвөл малын хулгайн зохион байгуулалттай гэмт хэргийн оролцогч болж хувирах бөгөөд энэ гэмт хэргийн оролцогч хорих ялаас гадуур үлдэх боломжгүй байх зохицуулалтыг тусгажээ.

Эрүүгийн хууль 2017 оны 7 дугаар сарын 1-нээс мөрдөж эхэлснээс хойш авч үзэхэд, малын хулгайч нарын малчдад учруулсан хохирол тогтмол өссөн байна.

Эрүүгийн болон Зөрчлийн хуулиас гадна Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль зэрэг хуулиар малын шилжилт хөдөлгөөний хяналт, малын бүртгэл, им тамга, малын индексжүүлсэн бүртгэл, мал, махны гарал үүслийн гэрчилгээ зэрэг захиргааны хяналт, зохицуулалтын шинжтэй хуулийн зохицуулалтууд хэрэгжиж байна. Гэсэн ч мал хулгайлах гэмт хэргийн гаралтыг бууруулахад дорвитой нөлөө үзүүлэхгүй байна. Энэ төрлийн гэмт хэргийн гаралт жил бүр тасралтгүй өссөөр байна.¹⁸

Монгол Улс нийт малын тоо 2021 оны байдлаар 67.343.759 мал тоологдсон бөгөөд үүнээс адуу 432.444, үхэр 5.022.225, тэмээ 454.038, хонь 31.086.963, ямаа 26.456.089¹⁹ байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн мал хулгайлах гэмт хэргийн 90 гаруй хувь нь хөдөө орон нутагт, 10 орчим хувь нь нийслэлд бүртгэгдсэн бөгөөд мал, мах, малын гаралтай түүхий эдийн үйлдвэрлэл, худалдаа хяналтгүй болсон нь мал хулгайлах гэмт хэрэг өсөхөд нөлөөлж байгаа²⁰ талаар иргэд ярьж байна.

Мал хулгайлах гэмт хэргийн 89.1 хувь нь орон нутагт үйлдэгдсэн бөгөөд орон нутагт үйлдэгдсэн хулгайлах гэмт хэргийн 24.3 хувийг мал хулгайлах гэмт хэрэг эзэлж байна.

Энэ төрлийн гэмт хэрэг ажлын өдрүүдэд, хөдөө хээр, малын бэлчээрт голдуу шөнийн цагаар үйлдэгдсэн нь малчдын малаа хараа хяналтгүй, хариулгагүй олон хоногоор орхиж байгаа нь гэмт хэргийн шалтгаан болж байна.

Мал хулгайлах гэмт хэрэгт хамгийн их нөлөөлж байгаа үзүүлэлт нь экспортын махны хэмжээ маш хүчтэй шууд хамааралтай байсан бол дотоодын мал аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлтэй урвуу хамааралтай байна.

2018 онд мах экспортлох тусгай зөвшөөрөлтэй 34 аж ахуйн нэгж, нийт 357.3 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 145.106 тонн махыг экспортолсон дүн мэдээ гаргасан

¹⁷ Төрийн мэдээлэл. 2016. №07. Монгол Улсын Эрүүгийн хууль

¹⁸ <https://vip76.mn/content/65745>

¹⁹ https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L10_1

²⁰ <http://urgudul.parliament.mn/content?id=334#.Yqigil3ZBy1s>

байна.²¹ Нийслэл хотын хэмжээнд их хэмжээгээр мах бэлтгэн хадгалж байгаа Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Налайх дүүргийн нутаг дэвсгэрт байрлах агуулах, зоорь объектуудыг шалгахад нийт 14 аж ахуйн нэгжийн агуулахад 19 компани, БНХАУ-ын 10 иргэний нийт 2.300.3 тонн мах байгаагаас адуу 819 тн, үхэр 746.1 тн, хонь 257 тн, ямаа 389.3 тн, боловсруулсан бүтээгдэхүүн 9.2 тонн, дайвар бүтээгдэхүүн 83.2 тонн байна.²²

Хадгалсан махны 80 орчим хувь нь БНХАУ-ын иргэдийн худалдан авсан мах эзэлж байна. Дээрх шалгалтын дүнгээс харахад бэлтгэн нийлүүлэгдэж байгаа махны 60-80 орчим хувийг БНХАУ-ын иргэд бэлэн мөнгөөр худалдан авч тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн нэрээр экспортод гаргаж байгаа тогтоогдсон байна.

Махны үйлдвэрлэл, худалдаанд тавих хяналт сул байгаа, нөгөө талаараа экспортод малын мах их хэмжээгээр бэлтгэн нийлүүлж байгаа нь мал хулгайлах гэмт хэргийн өсөлтөд нөлөөлж байна. Түүнчлэн, нийгэм, эдийн засгийн бодлого шийдвэр, ажилгүйдэл, ядуурал ихсэж, иргэдийн амьжиргааны түвшин доогуур байгаатай холбоотойгоор иргэд мал хулгайлах явдал буурахгүй байх нэг шалтгаан болж байна.

Баян-Өлгий аймгийн хэмжээнд бүртгэгдсэн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болон мал хулгайлах гэмт хэргийг сүүлийн 5 жилийн байдлаар хэсэгчилсэн судалгаагаар хэргийн гаралтыг судалж үзэхэд, 2017 өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 101 бүртгэгдсэн бөгөөд үүний 17 буюу 16.8 хувь нь мал хулгайлах гэмт хэрэг, 2018 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 131 бүртгэгдсэн бөгөөд үүний 23 буюу 17.5 хувь нь мал хулгайлах гэмт хэрэг, 2019 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 139 бүртгэгдсэн бөгөөд үүний 13 буюу 9.3 хувь нь мал хулгайлах гэмт хэрэг, 2020 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 135 бүртгэгдсэн бөгөөд үүний 27 буюу 20 хувь нь мал хулгайлах гэмт хэрэг, 2021 онд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 93 бүртгэгдсэн бөгөөд үүний 21 буюу 22.5 хувийг нь мал хулгайлах төрлийн гэмт хэрэг тус тус эзэлж байна.²³ Үүнийг графикаар үзүүлбэл:

График №1



Тус аймагт бүртгэгдсэн мал хулгайлах гэмт хэргийн өсөлтийн динамикийг авч үзвэл, 2018 онд 6 нэгжээр өссөн боловч 2019 онд 10 нэгжээр буурсан боловч 2020 онд 6 нэгжээр буцаад өссөн. Харин 2021 онд 6 нэгжээр буурсан байна. Гэвч мал хулгайлах гэмт хэргийн өсөлт, бууралт тухайн онд гарсан өмчлөх эрхийн гэмт хэрэгт эзлэх хувь хэмжээнээс үзэхэд, 2021 онд хамгийн өндөр хувийг эзэлж байна.

²¹ Цагдаагийн байгууллагаас 2019 оны 01 дүгээр сард зохион байгуулсан хэсэгчилсэн арга хэмжээний тайлангаас хэсэгчилэн авав.

²² <https://information.police.gov.mn>.

²³ Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газрын 2018-2021 оны статистик тоо мэдээнээс хэсэгчилэн авав.

Дээрх тоо мэдээнээс үзэхэд, аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа мал хулгайлах гэмт хэрэг тогтвортой буурахгүй байгаа бөгөөд аймгийн хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэж буй ажлын арга барил хуучирсан, зохион байгуулж буй ажил, арга хэмжээ оновчгүй байна гэж дүгнэхэд хүрч байна.

Энэ нь талаараа мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын хүч хэрэгсэл дутмаг, шаардлагатай төсөв хөрөнгө хүрэлцэхгүй байгаатай салшгүй холбоотой болж байна. Нөгөө талаараа иргэдийн хараа хяналт сул, малаа хариулгагүй орхих явдал түгээмэл байгаатай шууд холбоотой.

Орон нутагт мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж байгаа алба хаагчдад учирдаг хамгийн хүндрэлтэй зүйл нь машин техник, бензин тосны асуудал байдаг байна.

Цагдаагийн алба хаагч мал хулгайлах гэмт хэргийг илрүүлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тогтоож, прокурор, шүүхийн байгууллагад шилжүүлдэг ч тус байгууллагаас гэмт этгээдийг баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авдаггүй, хангалттай нотлох баримт, үндэслэл байсан гадуур шалгаж, улмаар гэмт этгээдэд шүүхээс хөнгөн ял оногдуулж байгаа нь малын хулгайч нарт ял завших, цаашлаад дахин гэмт хэрэг үйлдэх бололцоог олгож байна.²⁴

Хүн ам ихтэй, зам дагасан, зах зээлд ойрхон, отор нүүдэл ихтэй аймгуудад энэ төрлийн гэмт хэрэг илүүтэй бүртгэгдэхийн зэрэгцээ тухайн орон нутгийн удирдлагаас мал хулгайлах гэмт хэрэгтэй чиглэлээр бодлого боловсруулж, санаачлагатай ажилладаггүй, цагдаагийн байгууллагатай хамтрах, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх ажил хангалтгүй, нэгдсэн арга хэмжээ, аяны үеэр бага хэмжээний бензин өгсөн төдийгөөр өнгөрөөдөг, бод малын үнэлгээг тогтоох шаардлагатай үед /хурдан морьт гм/ үнэлгээ хийх эрхтэй компани аймаг бүрт байхгүй, 1 бод малын үнэлгээ гаргахад 35.000-50.000 төгрөгийн зардал гардаг зэрэг хүндрэл алба хаагчдад учирдаг байна.

Мөн орон нутгийн цагдаагийн байгууллагын хөдөө сумдад ажиллаж байгаа алба хаагчдад уналга, тээврийн хэрэгсэл дутагдалтай байна. Аймгийн хэмжээнд 2-3 сумын цагдаагийн хэсэгт хуучин авто машинтай, 4-5 сумын цагдаагийн алба хаагч автомашин, мотоцикл байхгүй байгаа нь хурдан унаатай, зэвсэглэсэн, бүлэг зохион байгуулалттай хулгайч нарыг цаг алдалгүй илрүүлэх, баривчилахад хүндрэл учруулж байна. Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгчид 2-3 автомашинтай, жижиг тэргээр түрүүлэн явж цагдаагийн болон бусад хяналтын постын байршлыг урьдчилан тогтоож, хулгайн мал тээвэрлэн яваа авто машиныг хяналтын цэгийг тойруулан алсуур нэвтрүүлдэг, зарим газруудад зоорь ухаж нуун далдалдаг байна.²⁵

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд дараах хүчин зүйл сөргөөр нөлөөлж байна. Үүнд:

- Мал хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо ямар журмаар нэхэмжлэхээ мэддэггүй;
- Санхүүгийн боломж муугаас тэмдэгтийн хураамж төлж чадахгүй учир нэхэмжлэл гаргаж чаддаггүй;
- Хохирсон боловч хохирол учруулсан этгээдийг танихгүй, мэдэхгүйн улмаас хохирлоо нэхэмжилж чаддаггүй;
- Малч иргэд өөрсдийн хайхрамжгүй, хэнэггүй зангаасаа болж цагдаагийн байгууллагад мэдэгдэлгүй орхих зэрэг болно.

²⁴ <https://information.police.gov.mn>

²⁵ <https://information.police.gov.mn>

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх ажлын хүрээнд дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохих үр дүнгээ өгнө гэж үзэж байна. Тухайлбал,

- Төв сууринд чиглэсэн замд цагдаагийн пост шинээр бий болгож хяналтыг чангатгах;
- Хөдөлгөөнт, хүч нэмэгдүүлсэн постыг ажиллуулах;
- Мал махны бөөний худалдааны газруудад цагдаагийн хэсэг, төлөөлөгчийг ажиллуулах;
- “Хүчит шонхор”, “Эмээлт”, “Хархорин”, “Цайз” зэрэг махны худалдааны томоохон цэгүүдийг камержуулан цагдаагийн давхар хяналт тогтоох;
- Мал махны худалдаа эрхлэгчдийг бүртгэлжүүлэн нүдэнд ил харагдахуйц таних тэмдэгтэй болгох;²⁶
- Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж хорих ялыг тэнссэн, хорих ялаас хугацааны өмнө суллагдаж хяналт тогтоосон этгээдүүдэд тавих цагдаагийн байгууллагын хяналтыг чангатгах, ажлыг тогтмолжуулах;
- Тээврийн хэрэгслээр болон малыг хөлөөр нь оруулж ирж байгаа нөхцөлд хийх үзлэг шалгалтыг сайжруулах;
- Гэмт хэрэг үйлдэгчдийн талаар шуурхай мэдээлэл солилцдог болох;
- Хулгайлах гэмт хэргийн зохион байгуулалттай бүлэглэл, сүлжээг илрүүлэхэд цагдаагийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах;
- Мал хулгайлах гэмт хэргийн талаарх мэдээллийн нууцыг хадгалж, үнэн бодитой мэдээллийг үнэлгээтэй болгох, мэдээлэгчтэй харилцан тохиролцох талаар хуулийн заалтыг хэрэгжүүлэн, түүнд зарцуулагдах мөнгөн хөрөнгийн санг бүрдүүлэх ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сантай уялдуулан зохион байгуулах хэрэгтэй байна.

Ялангуяа аймаг, сумдаас төв рүү чиглэсэн зам дагуух цагдаагийн хяналтын цэгүүдийг байгуулж, түүнд шаардлагатай төсөв, санхүүгийн асуудлыг тухайн орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сангаас гаргаж, ажлыг нь тогтмолжуулах нь үр дүнтэй гарна гэж үзэж байна. Түүнчлэн, цагдаагийн байгууллагаас малчин иргэдтэй хамтран ажиллах ажлынхаа арга барилыг сайжруулж, тэдний үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр дараах чиглэлээр ажил, зохион байгуулбал зохих үр дүн гарна гэж үзэж байна. Тухайлбал,

- Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг малчдаас өөрөөс нь эхлэх, сонор сэрэмжийг дээшлүүлэх талаар яриа, таниулга эрчимтэй явуулах;
- Малаа байнгын хариулга, маллагаа, шөнийн манаатай болгох бүлэг, нөхөрлөл байгуулах, сайн дурын хөдөлгөөнийг өрнүүлэх ажлыг дэмжих;
- Малын урамшуулалтай эргүүл, харуул ажиллуулж, шаардагдах хөрөнгийг малчдын бүлгэмээс гаргах;
- Шилмэл омгийн, хурдан удмын, гойд ашиг шимтэй малаа зурагжуулах, бүртгэлийн карттай болгох;
- Малд GPS системийг суулгах ажлыг эрчимжүүлбэл үр дүн гарна гэж үзэж байна.

Дүгнэлт

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг Баян-Өлгий аймгийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа боловч төсөв санхүүгийн хүндрэлтэй байдал, иргэдийн идэвхи санаачлага сул байгаагаас үүдэлтэйгээр хүссэн үр дүнд хүрэхгүй байна.

²⁶ <http://103.17.108.224/blog/ME/2426>

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар үр дүнтэй ажиллаж байгаа малчид, мал бүхий иргэдийн бүлгийг холбооны болон бусад техник хэрэгслээр хангахад төрөөс дэмжлэг үзүүлнэ”²⁷ гэж заасан бөгөөд шаардлагатай зардлыг мал бүхий иргэдээс, орон нутгийн хөгжлийн сан болон төрийн бус байгууллагаас төсөл, санхүүжилт хэлбэрээр гаргуулж дээр дурдсан ажлыг санхүүжүүлэх замаар хэрэгжүүлбэл мал хулгайлах гэмт хэрэг буурч, гэмт хэргийн илрүүлэлтэд эерэгээр нөлөөлнө гэж үзэж байна.

Санал

Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс судалгааны үр дүнд үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

- Малыг бүртгэлжүүлэх нэгдсэн системтэй болох;
- Малын гарал үүслийн гэрчилгээг QR кодтой болгох замаар хяналтын механизмыг боловсронгуй болгох ажлыг эхлүүлэх;
- Шилмэл омгийн, хурдан удмын, гойд ашиг шимтэй малаа зурагжуулах, бүртгэлжүүлэх;
- Мал махны бөөний худалдааны газруудад цагдаагийн хэсэг, төлөөлөгчийг ажиллуулах;
- “Хүчит шонхор”, “Эмээлт”, “Хархорин”, “Цайз” зэрэг махны худалдааны томоохон цэгийг камержуулан цагдаагийн давхар хяналт тогтоох-зэрэг болно.

Ашигласан материал

Монгол Улсын хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Эрүүгийн хууль.
- Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль.

Ном, сурах бичиг, гарын авлага:

- Ж.Болдбаатар. Эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/. УБ. 2016.
- С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2018
- Г.Оюунболд. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. УБ.2018.
- С.Нарангэрэл. Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг. УБ. 2021.

Тайлан мэдээ:

- ЦЕГ-ын 2018-2021 оны статистик мэдээ
- Баян-Өлгий аймгийн 2018-2021 оны тайлан мэдээ

Цахим эх сурвалж

- <https://www.google.mn>
- <http://legalinfo.mn/>
- <https://system.police.gov>
- <https://police.gov.mn>
- <http://criminology.mn>
- <https://www.1212.mn>
- <http://urgudul.parliament.mn>
- <https://information.police.gov.mn>

²⁷ Төрийн мэдээлэл. 2004. №23. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ХУУЛЬЧИЛЖ ИРСЭН УЛАМЖЛАЛ, ОНЦЛОГ

*Ж.Мөнхболд-Доктор (Ph.D), дэд профессор
Г.Ууганболор-Доктор (Ph.D), дэд профессор
Я.Батханд-ИЗОУИС-ийн докторант*

Товч агуулга. Энэхүү өгүүлэлд Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид залилах гэмт хэргийг хуульчилж ирсэн байдал, түүний онцлогийг төр, хууль цаазын түүхэн уг сурвалжид тулгуурлан түүхчлэн судлах судалгааны аргаар авч үзсэн болно.

Түлхүүр үг. Залилах гэмт хэрэг, эрүүгийн хариуцлага, хууль тогтоомж, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх.

Монголчуудын түүхэн эх сурвалжид хадгалагдан үлдсэн өв соёл, баримт, бичгүүдээс “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэгдсэн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон шинжтэй зүйл заалтууд нь эрх зүйн эх сурвалжийн түүхэн хөгжлийг тодорхойлох судалгаанд үнэтэй хэрэглэгдэхүүн болдог.

Төрийн хэрэг, хүн амын дунд итгэл найдвар, үнэнч шударга байдлыг маш өндөр хэмжээнд үнэлдэг байсан нь харагддаг талаар судлаачид бичсэн нь бий.

Тухайн цаг үед Монголд аялсан Макриди, Магакя, Вартанг, Плано-Карпини, Рубрук, Марко Поло, Ибн-Батута, Мирховенд нар бүтээлдээ Их засагт холбогдох чухал мэдээллийг тэмдэглэжээ. Тухайлбал, Жиованни Дель Плано Карпини “Дорно этгээдэд зорчсон минь” бүтээлд: “...элч төлөөлөгч биш атлаа өөрийг элч төлөөлөгч гэж худал хэлсэн хүнийг алж шийтгэнэ...”²⁸, “...Монголчуудын зан үйл, хууль цааз, гэмт хэрэг тэр дундаа өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болох хулгай, худал хуурмаг, заль мэхийн талаар тодорхой баримттайгаар тэмдэглэн үлдээжээ”²⁹.

Эрүүгийн эрх зүйн өнөөгийн сэтгэлгээний үүднээс авч үзвэл, Их Засаг хуулийн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхээр заасан хэм хэмжээний дотор “**залилах**” гэмт хэрэгт эрүүгийн ял шийтгэх тусгайлсан заалт байхгүй байна. Гэхдээ эх сурвалжуудад тэмдэглэгдсэнээр, Чингис хааны төрийн үзэлд “ итгэл даах, үнэнч шударга байх, хулгай худлыг үл тэвчих” ёс хүчтэй байснаас дүгнэхэд тэр үед **залилах гэмт хэргийг, хулгайлах гэмт хэрэгтэй** хамтатган үзэж, гэмтэнг цаазаар авах хүртэл хүнд ял оноож байсан ажээ. Энэ нь залилан мэхлэх гэмт хэргийн хуурч мэхлэх буюу итгэл эвдэх үйлдэл нь тухайн төрийн ёсонд туйлын харш явдал байсантай холбоотой байж болох юм.

Их Засаг хуулийн дараа залган үйлчилж байсан хууль цаазын дорвитой дурсгалт бичиг бол Их Юань гүрний нэвтэрхий толь³⁰ хууль юм.

Профессор Г.Совд энэ хуулийг тухайлан судалж, Юань улсын хуульд гэмт хэргийн тухай ерөнхий заалтыг “Их муу”³¹ гэж нэрлэж байсан бөгөөд тэдгээрийн тоонд ... хулгай худал, хуурмаг худал, зарга зальхай, эд хөрөнгө идэх явдлуудыг ... онцгойлон заасан байдаг³². Энэ хуульд их хэмжээтэй хулгайлсан гэмтнүүдийн нүүр,

²⁸ Жиованни Дель Плано Карпини “Дорно этгээдэд зорчсон минь”.УБ.,1988 18-25 дах тал

²⁹ Дурьдсан зохиол, 116 дах тал

³⁰ Э.Авирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд “Монгол хууль”.УБ.,1997. 19 дэх тал

³¹ Г.Совд “Юань улсын засаг хууль. Ардын төр, сэтгүүл”.УБ.,1991 №1

³² Э.Авирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд “Монгол хууль”.УБ.,1997 33 дах тал

хүзүү хавьд бэхээр бичиг шивэхийг зааж харин монгол хүн болон эмэгтэйчүүдэд бичиг шивэхийг хориглосон байжээ. Эцгийн хийсэн ялыг хүүд, ахын хийсэн ялыг дүүд халдаах, ялтан хүнд хуульд зааснаас гадуур харгис эрүү хэрэглэх, ялтныг байцаах ажиллагааг шөнийн цагт үргэлжлүүлэхийг хориглосон заалт байдаг тухай сонирхолтой дүгнэлт хийсэн байдаг.

Юан гүрний нэвтэрхий хуульд орчин үеийн эрүүгийн эрх зүйн сэтгэлгээний үүднээс авч үзвээс залилан мэхлэх гэмт хэрэг болон өмч хөрөнгөтэй холбоотой гэмт хэрэг, түүнд хүлээлгэх хариуцлагын талаар цөөнгүй заалт агуулагдаж байна. Тодруулбал;

... луйвар гэсэн XII хэсэгт: ... эзэн хааны тамгыг хуурамчаар үйлдвэл цаазаар авах, эрх баригчдын тамгыг хуурамчаар үйлдвэл 107 удаа саваадах, татварын товчооны тамгыг дуурайн үйлдвэл 87 удаа занчина. Эрх бүхий бус этгээд өөрийгөө түшмэл хэмээвэл 87 удаа саваадан шийтгэнэ;

... хорио цээр гэсэн XVI хэсэгт: ... хэмжээ, жин зэргийг хуурамчаар үйлдэх, түшмэл бус атлаа дүрэмт хувцас өмсөхийг хоригложээ.

Эдгээр заалтууд хулгайлах, луйвардах тухай хэм хэмжээ байсан нь тогтоогдож байна. Тухайлбал, луйварын хэсэгт: Ямар ч эрхгүйгээр өөрийгөө түшмэл хэмээн нэрийдвэл 2 жил хүчир ажил хийлгэж, 77 удаа саваадан занчина. Цай, давч тээвэрлэн зөөх бичиг баримт хуурамчаар үйлдвэл цаазаар авч өмч хөрөнгийг хураана ...³³ гэж ял тогтоожээ.

Монголын түүхэнд XVI-XVII зууны үе³⁴ нь Монголын Их гүрэн саланги, тусгаар байдалтай, олон хан толгойлсон засаг захиргааны хувьд бие даасан байдалтай жижиг нэгжүүдэд хуваагдан бутарсан үе байлаа. Тухайлбал, Түмэдийн Алтан хан /1507-1582/, Ордосын Хутагтай Цэцэн хунтайж /1540-1586/, Халхын Автай сайн хан /1554-1588/ нар өөрсдийн харьяалсан түмнийг бие даан захирч их хаанд төдий л харъяалагдахгүй байжээ. Улмаар 1604 онд Монголын их хаан ширээнд Лигдэн /1592-1634/ суухад түүний захиргаанд зөвхөн Цахар түмэн л харъяалагдах болсон байна.³⁵

Түмэдийн Алтан хаан /1507-1582/ Монголд төр, шашны хэргийг сэргээн бэхжүүлэхийн төлөө ихээхэн хүчин зүтгэж явсан³⁶ түүхэн хүний нэг бөгөөд XVI зуунаас манай үед бүрэн бүтэн уламжлагдан ирсэн **Алтан хааны цаазын бичиг** нь нийт 115 зүйлтэй, оршил төгсгөлийн хэсэгтэй хууль цаазын бичиг гэж үздэг.

Доктор Т.Алтангэрэл Алтан хааны цаазад агуулагдаж буй эрүүгийн хэргүүдээс нийт 30 заалт³⁷ залилан мэхлэх гэмт хэрэгтэй холбоотой байна гэж тэмдэглэн үлдээсэн байна.

Монгол-Ойрадын хууль.³⁸ Ойрад буюу Баруун монгол нь дөрвөн түмэн, Дорнод Монгол нь дөчин түмнээс бүрэлдэж байгаа тул "Дөчин, дөрвөн хоёр"³⁹ гэж Монгол Ойрадыг энэ үеийн түүхэн сурвалжуудад бичжээ. Монгол-Ойрадын хуулинд агуулагдаж буй эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнд холбогдох заалтуудаас нийт 18

³³ В.А.Рязановский "Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм".Их засаг хууль.УБ.,2000 126-129, 135 дах тал

³⁴ 1616 онд Нурхачи баатрын /1575-1626/ үндэслэсэн Зүрчид угсааны Умард Алтан улс шинээр байгуулагдсан нь зэргэлдээх улс түмнүүдэд эзлэн түрэмгийлэх аюул заналхийлэх болсон.

³⁵ Т.Алтангэрэл "Монгол-Ойрадын их цааз төр, эрх зүйн түүхэн эх сурвалж болох нь".УБ. 2001. ХЗУ-ны докторын /Ph.D/ зэрэг горилсон диссертацийн ажил. 14 дэх тал

³⁶ Э.Авирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд "Монгол хууль".УБ.,1997 47 дах тал

³⁷ Т.Алтангэрэл "XVI-XVII зууны монгол цаазын бичгүүд".УБ.,1999 34-37 дах тал

³⁸ Х.Доржпалам. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй./Ерөнхий анги/. УБ., 2019. 37 дахь тал

³⁹ Лувсанданзан "Монгол хаадын төр ёсыг үндэслэсэн Алтан товч хэмээх судар оршивой".УБ.,1937 134 дэх тал

заалтад⁴⁰ тухайн түүхэн цаг үед залилан мэхлэх гэмт хэрэгтэй тэмцэж басян агуулга хадгалагдан үлджээ.

Монголын түүхэнд тус улс бусдын эрхшээлд орж олон жилийн хэцүү бэрх түүхийг туулах болсон цаг үе нь XVIII-XIX зуунаар тэмдэглэгдэн үлджээ.

Манж Чин Улсын төрөөс Монголд явуулах бодлогыг хэрэгжүүлэх гол үүрэгтэй нэгж болох Гадаад Монголын төрийг засах явдлын яаманд⁴¹ Монголын улс төр, хууль цаазын бүх эрх мэдэл төвлөрөхийн зэрэгцээ Монголын дотоод улс төрийн байдалд хяналт тогтоож, Монголд мөрдөх цааз хууль боловсруулах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг өргөн эрх эдэлж байв”.⁴²

Манжийн үед Гадаад Монголд зориулан тогтоосон хууль цаазын сурвалж дотроос “Зарлигаар тогтоосон гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг” зарлигийг нэгтгэн дэвтэрлэж 152 зүйл болгосон байна. Үүнээс хойш олон жилийн туршид нэмэн засварлаж, дэвтэрлэснээр 1850 он гэхэд Манж, Монгол, Хятад үсгээр хэвлэсэн тус бүр 70 боть, 1554 зүйл бүхий⁴³ олон дэвтэр цаазын бичиг болсон юм.

Хууль зүйлийн бичгийг 1789 онд зохион мөрдүүлсэн гэж доктор Г.Совд, профессор Ц.Дамдинсүрэн, ХБНГУ-ын судлаач Алинге Курт, Дорчеа Хойшерт, Оросын нэрт судлаач В.А.Рязановский, БНХАУ-ын судлаач Найралт, Алтан-Оргил нарын бүтээлүүдэд⁴⁴ тэмдэглэжээ.

“Монгол цаазын бичиг”-ийн зургадугаар дэвтэрт хулгай худлын зүйлд: нийт 35 зүйл заалт хамаарч байна. Тухайн Цаазад эд зүйлийг **холгох** гэсэн нэр томъёонд залилан мэхлэх гэмт хэрэг, хулгайлах, завших, булаах, дээрэмдэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжүүд хамаарч байсан нь урьдын цааз хуулиудтай адил байна.

Халх журам хууль Манж Чин улсын эрхшээлд байх үеийн Монгол хууль цаазын тулгар хамгийн дорвитой хэрэглэгдэхүүний тоонд “Халх журам” хууль хамаардаг.

Уг цаазад агуулагдаж буй эрүүгийн эрх зүйн шинжтэй хэм хэмжээг авч үзэхэд өмнөх хууль цаазуудын адил залилан мэхлэх гэмт хэрэг гэсэн бие даасан ойлголт буй болоогүй байсан бөгөөд хулгайн гэмт хэрэгтэй хамт “Хулгай худлын хэрэг” гэдэг байдлаар нийтлэг хууль цаазын учир холбогдолтой байжээ.

Богд хаант Монгол улсын үе. Үндэсний тусгаар тогтнолоо сэргээж, төрийн бие даасан байдлаа хадгалах гэсэн монголчуудын олон жилийн хүсэл мөрөөдөл цаг үе, түүхэн тохироо бүрэлдснээр манжийн төрийн захиргааг халж, феодалын хаант улсыг тунхагласнаар тус улсын түүхэнд нэгэн шинэ үе эхэлжээ. 1914 онд байгуулагдсан⁴⁵ улсын дээд, доод хурлаар Монголын хаант улсын хууль тогтоох үйл ажиллагааны үр дүнд зохиосон хуулийн төслийг хэлэлцдэг болсон ба тухайн үедээ шинэлэг үйл явдал байлаа. Тухайлбал, 1915-1918 онд зохиосон “Зарлигаар

⁴⁰ Т.Алтангэрэл дурдсан зохиол.УБ.,1998 54-69 дэх тал

⁴¹ Жургаан гэдэг нь яам гэсэн утгатай манж үг бөгөөд Гадаад монголын төрийг засах явдлын яамыг товчлон нэрлэж байжээ.

⁴² Б.Содовсүрэн “Хувьсгалын өмнөх монголын төр ба хууль цааз /1911-1920/.УБ.,1989 7 дах тал”

⁴³ Б.Баярсайхан “Монгол цаазын бичиг” /харьцуулсан судалгаа/.УБ.,2001 11 дэх тал

⁴⁴ Г.Совд. БНМАУ-ын эрүүгийн эрхийн курс.УБ., 1973. 38 дах тал;

Ц.Дамдинсүрэн. 2000 жилийн харьцуулсан хүснэгт. УБ., 1995, 55 дах тал; Dorothea Heushert Die Gesetzgebung der Qing fuer die Mongolen 17. Jahrhundert, anhand des Mongolischen Gesetzbuches and der Kanki, Zeit /1662-1722/, Harrassowitz Verlag, 1998; В.А.Рязановский. Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм. Их засаг. 2000.УБ., 28 дах тал; Найралт, Алтан-Оргил нарын хөрвүүлэг. Зарлигаар тогтоосон гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг. ӨМӨЗО. 1998. 2 дах тал

⁴⁵ Ц.Пунсагноров “Монголын автономит үеийн түүх”.УБ.,1955 108 дах тал

тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг"-ийн зарим дэвтрийг дээд, доод хурлаар хэлэлцүүлэх үед гарсан саналыг хуулийн төсөл зохиох комисс харгалзан үзэхэд хүрч⁴⁶ байжээ. "Хууль зүйлийн бичиг"-т залилан мэхлэх гэмт хэргийг урьдын адил хулгайн гэмт хэргийн нэг хэлбэр гэж үзэж **хулгай, худлын хэрэг** гэж томъёолон шийтгэж байсан гэж дүгнэж болно.

Ардын хувьсгал ба түүний дараа үе:

1926.1.15-нд Монгол улсын анхны Эрүүгийн хууль буюу Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг, мөн оны 11 сарын 11-нд тусгай ангийг батлан⁴⁷ гаргажээ.

БНМАУ-ын 1926 оны Шүүх цаазын бичигт⁴⁸. Түүхэн энэ цаг мөчөөс эхлэн Монгол улсын нийгэм дэх эрүүгийн эрх зүйн харилцааг бие даасан салбар хууль буюу Эрүүгийн хуулиар зохицуулж ирсэн юм. Анхны Эрүүгийн хууль ерөнхий ба тусгай анги гэсэн 2 том хэсэгтэй, нийт 31 бүлэг, 227 зүйлтэйгээр батлагдсан байна.

БНМАУ-ын 1926 оны Шүүх цаазын бичгийн тусгай ангийн 214 дүгээр зүйлд залилан мэхлэх гэмт хэргийг дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

- "214 дүгээр зүйл: Ашгийг хичээж залилан мэхэлж бусдын эрхийг эдлэх буюу эсхүл эд юмыг ашиглан явдлын улмаас сүйтгэл шингээвээс 6 сараас 5 жил хүртэл гянданд хорино.
- 215 дугаар зүйл: Дээрхи зүйлд дурьдсан гэмт улсын ба ард олноор байгуулсан газруудын хөрөнгөнд гаргаваас 1-7 жил хүртэл гяндан хорихоос гадна хөрөнгийг нь бүрэн буюу заримыг нь албан хурааж болно.
- 216 дугаар зүйл: Энэхүү цааз бичгийн 214 дүгээр зүйлд дурьдсан гэмт явдлыг үйлдэхэд айлган доромжлох зэрэг хэрэглэвээс 1-6 жил хүртэл гяндан хорино"⁴⁹ гэсэн болно.

Дээрхи заалтуудаас үзэхэд тухайн үед залилан мэхлэх гэмт хэргийн шинжийг а/ ашгийг хичээж; б/ залилан мэхэлж; в/ бусдын эрхийг эдлэх буюу эсхүл эд юмыг; г/ ашиглан шингээх байдлаар тогтоож өгсөн байна.

БНМАУ-ын 1929 оны Шүүх цаазын бичиг. 1926 оны "БНМАУ-ын "Шүүх цаазын бичиг"-ийг Засгийн газрын 1929 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 30 дугаар хурал, Улсын 14 дүгээр Бага хурлаар шинэчлэн найруулсан "Шүүх цаазын бичиг"-ийг /1929 оны/ батлан мөрдүүлснээр хүчингүй болгожээ.

Шүүх цаазын бичгийн тусгай ангийн 29 дүгээр бүлэгт залилан мэхлэх гэмт хэргийг дараах байдлаар хуульчилсан байна. Үүнд:

- "216 дугаар зүйл. Ашгийг хичээж залилан мэхэлж бусдын эрхийг эдлэх буюу эсхүл эд юмыг ашиглан шингээвээс 5 жил хүртэл хоримой,
- 217 дугаар зүйл. Дээрх зүйлүүд дор дурьдсан явдлын улмаас ард олноор байгуулсан газрын хөрөнгөн дор сүйтгэл гарваас 1-7 жил хүртэл хорихоос гадна хөрөнгийг бүрэн буюу заримыг албан хурааж болмой.
- 218 дугаар зүйл. Энэхүү цаазын бичгийн 216 дугаар зүйл дор дурьдсан гэмт явдлыг үйлдэхүй дор дарлан доромжлох зэрэг арга хэрэглэвээс 1-6 жил хүртэл хоримой"⁵⁰. Залилан мэхлэх гэмт хэргийн шинжийг ийнхүү хуульчилсан нь өмнөх хуулийн заалтаас онцын өөрчлөлт хийгдсэнгүй болохыг харуулж байна.

⁴⁶ Б.Содовсүрэн "Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз /1911-1920/. УБ., 1989, 29 дэх тал

⁴⁷ Б.Содовсүрэн. "БНМАУ - ын Эрүүгийн хууль , тогтоомжийн хөгжилт". УБ. 1971. 42 дахь тал

⁴⁸ Х.Доржпалам. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. УБ., 2019. 45 дахь тал

⁴⁹ И.Дашням, Д.Далайбаяр нарын эмхтгэсэн "БНМАУ-ын шүүх цаазын бичгүүдийн эмхтгэл /1926/. УБ. 2002. 14 дэх тал

⁵⁰ Монгол Улсын Үндэсний төв архив. Ф-284 . Т-1. х/н-610. 81 дэх тал

БНМАУ-ын 1934 оны Шүүх цаазын бичиг. Шүүх цаазын бичгийн /1934 оны/ "Эд хөрөнгийн гэмт хэргүүд" хэмээх 7 дугаар бүлгийн 143 дугаар зүйлд залилан мэхлэх гэмт хэргийг "... Бусдын мөнгө буюу эд хөрөнгийг ба эзэмшиж эдлэх эрхийг залилан мэхлэх аргаар шилжүүлэн авсан бол 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино. Тийнхүү бусдын эд хөрөнгийг эзэмшиж эдлэх эрхийг залилан мэхлэх аргаар шилжүүлэн авах явдал үйлдснээс улсын ба олон нийтийн газруудад үлэмжхэн хохирол учруулсан бол 1-5 жил хүртэлх хугацаагаар хорих, хөрөнгийг бүрэн буюу заримыг нь хураах ял шийтгэвэл зохино ..." ⁵¹ гэж нэг заалтад /143 дугаар зүйлд/ үг гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх шинжийг цуг хуульчилсан боловч, ялыг өөр өөрөөр тогтоосноор бүрэлдэхүүнүүдийг ялгах боломж бүрдэж өгсөн.

Залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд а/ хорих, б/ эд хөрөнгийг бүрэн буюу заримыг хураах ялыг шийтгэхээр заасан. Өөрөөр хэлбэл, хүндрүүлэх байдалтайгаар буюу залилан мэхлэх гэмт хэргийн улмаас улс, олон нийтийн газруудад үлэмжхэн хохирол учруулбал эд хөрөнгө хураах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэхээр хуульчилжээ.

БНМАУ-ын 1942 оны Эрүүгийн хууль. БНМАУ-ын 25 дугаар Бага хурлаас 1942.01.17-ны гаргасан тогтоолоор "БНМАУ-ын Эрүүгийн хууль"-ийг баталсан нь шинэ Үндсэн хуулийн агуулгад бусад тогтоомжуудыг нийцүүлэх ажлын хүрээнд урьд хэрэглэж байсан Шүүх цаазын бичгийн (1934 оны) хүчин чадлыг дуусгавар болгож, Монгол улсын Эрүүгийн эрх зүйн түүхэнд анх удаа "Эрүүгийн хууль" нэртэйгээр крилл үсгээр хэвлэгдэж ⁵², хэрэглэгдэх үндэс болжээ. Энэ хуулийн "Эд хөрөнгөний гэмт хэргүүд" хэмээх 8 дугаар бүлгийн 178 дугаар зүйлд "Итгэснийг тэсрүүлэн бусдын мөнгө хөрөнгө буюу эрхийг авахын тулд санаатайгаар залилан мэхлэх аргыг хэрэглэвэл жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ."

БНМАУ-ын 1961 оны Эрүүгийн хуульд. 1961 оны Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйлд:

Залилан мэхлэх.

а) Залилан мэхлэж итгэлийг эвдэх, замаар иргэдийн хөрөнгө буюу түүнийг эзэмших эрхийг авч ашиглавал 3 хүртэл хугацаагаар хорих эсхүл 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэнэ.

б) Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай буюу бүлэглэж буюу давтан үйлдсэн, эсхүл хохирогч этгээдэд их хэмжээний хохирол учруулсан бол хөрөнгийн заримыг буюу бүгдийг хураах эсхүл хураахгүйгээр 7 жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ хэмээн тусгасан байна.

1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль. Эрүүгийн хуулийн тусгай ангийн хэм хэмжээнд өмчийн эсрэг гэмт хэргийг хоёр ангилсан байдал хэвээр хадгалагдан үлдсэн байна. Тусгай ангийн 3 дугаар бүлэгт социалист өмчийн эсрэг гэмт хэрэг хуульчлагдсаны 127 дугаар зүйлд "Улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг залилан шамшигдуулах" гэмт хэргийг тусад нь хуульчилж өгснөөрөө 1961 оны Эрүүгийн хуулиас дэвшилттэй болсон байна. Тухайлбал,

- 127 дугаар зүйлд Улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг залилан мэхэлж ашиглан шамшигдуулах;

1.Улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар авсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл дөрвөн зуугаас хоёр мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

⁵¹ БНМАУ-ын "Шүүх цаазын бичиг".УБ.,1934 он 34 дэх тал

⁵² "Соёл гэгээрлийн байгууллагуудын ажлын талаар холбогдолтой зарлиг, тогтоол заавруудын системчилсэн эмхэтгэл. УБ.1962. 6 дахь тал, ШУА-ийн мэдээ. УБ.1963.№3.66 дахь тал, МАХН-ын тогтоол шийдвэр баримт бичгүүд.,УБ.1985.боть-3.46 дахь тал

2.Энэ үйлдлийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жилээс нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

3.Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсэгт заасан үйлдлийн улмаас улс, хоршоолол, олон нийтийн байгууллагад их хэмжээтэй хохирол учирсан буюу уг үйлдлийг онц аюултай рецидив гэмт хэрэгтэн хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр таваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ⁵³ гэж заасан.

Түүнчлэн 131 дүгээр зүйлд **Улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг бага хэмжээтэй ашиглан шамшигдуулах** гэмт хэргийн бүрэлдэхүүний үйлдэлд дээрх 127 дугаар зүйлд заасан залилан мэхлэх гэмт хэргийн "хөнгөрүүлэх" бүрэлдэхүүний шинж хамаарахаар хуульчилсан юм.

Тус хуулийн 5 дугаар бүлэгт **Иргэдийн амины өмчийн эсрэг гэмт хэргийг** системчилж, 157 дугаар зүйлд дараах байдлаар залилан мэхлэх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчилсан. Үүнд:

157 дугаар зүйл. Залилан мэхлэх

1. Хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар иргэдийн амины эд авсан бол хөрөнгийг авсан буюу түүнийг эзэмших эрхийг олж хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг мянга таван зуу хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2.Энэ үйлдлийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсэгт заасан үйлдлийн улмаас хохирогчид үлэмж хэмжээтэй хохирол учирсан уг үйлдлийг онц аюултай рецидив гэмт хэрэгтэн хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ⁵⁴.

Эрүүгийн хуулийн 127 дугаар зүйлд заасан социалист өмчийг залилан мэхлэх гэмт хэргийг 157 дугаар зүйлд заасан залилан мэхлэх гэмт хэрэгтэй харьцуулахад гэмт хэргийн бүрэлдэхүүн зөвхөн объектоороо л ялгагдан зүйлчлэгдэх бөгөөд, залилан мэхлэх гэмт хэргийн халдлагад социалист өмч өртвөл 127 дугаар зүйлээр зүйлчилж, ялын бодлого нь бүх заалтаар 157 дугаар зүйлээс хүндрүүлэхээр заажээ.

1993 оны Эрүүгийн хууль. Монгол Улсад 1990-ээд оноос нийгэм, эдийн засгийг бүхэлд нь хамарсан шинэчлэлт, өөрчлөлтийн уур амьсгал эрчимжиж, чөлөөт эдийн засгийг хүлээн зөвшөөрсөн билээ.

Энэхүү өөрчлөлтийн хүрээнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн "Өмчийн эсрэг гэмт хэрэг" хэмээх 3 дугаар бүлгийн 127 дугаар зүйлд "Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж ашиглан шамшигдуулах" гэмт хэргийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар хуульчлав. Үүнд:

-127 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэг: Хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар бусдын эд хөрөнгийг авсан буюу түүнийг эзэмших эрхийг олж авсан бол 3 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил эсхүл 25 000-200 000 хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

-2 дугаар хэсэг: Энэ үйлдлийг давтан буюу урьдчилсан тохиролцсон бүлэг этгээд хийсэн бол 5 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жилээс 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл 50000-500000 төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

⁵³ БНМАУ-ын Эрүүгийн хууль.УБ.,1987. 66 дах тал

⁵⁴ БНМАУ-ын Эрүүгийн хууль.УБ.,1987. 76 дах тал

-3 дугаар хэсэг: Энэ зүйлийн 1, 2 дах хэсэгт үйлдлийн улмаас бусдад их хэмжээтэй хохирол учирсан буюу уг үйлдлийг онц аюултай гэмт хэрэгтэн хийсэн бол 5-15 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэснээс үзэхэд, өмнөх хуулиас оногдуулах ял нь иргэдийн амины өмчийг залилан мэхлэх гэмт хэрэг /157 дугаар зүйл/-ээс харьцангуй хүндэрч, социалист өмчийг залилан мэхлэх гэмт хэрэг /127, 128 дугаар зүйл/-ээс хөнгөрсөн байна.

Тус хуулийн тусгай ангийн хэм хэмжээнд залилан мэхлэх гэмт хэргээс ялган зүйлчилбэл зохих ижил төстэй үйлдлүүдийг бие даасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан өмнөх хуулийн агуулга хэвээр хадгалагдсан байна. 1993 оны Эрүүгийн хуулийг практикт хэрэглэх явцад нэг мөр ойлголт өгөх үүднээс "Өмчийн эсрэг гэмт хурлын тогтоолууд 1991⁵⁵, 1997⁵⁶ онуудад гарч байсны дотор залилан мэхлэх гэмт хэргийн шинжийг хэрхэн ойлгох талаар өгсөн албан ёсны тайлбарууд өнөөдөр ч эрүүгийн эрх зүйн онол практикт үнэ цэнээ алдаагүй байна.

2002 оны Эрүүгийн хууль. 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр шинээр батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтоосон билээ. Энэхүү шинэ хуулиар урьд нь гэмт хэрэгт тооцож байсан зарим хэргийг гэмт хэрэгт тооцохгүй байх, зарим үйлдлийг шинээр гэмт хэрэгт тооцох болон зарим төрлийн ялыг хүчингүй болгох буюу хугацаа, хэмжээг нь өөрчлөх, зарим ялыг шинээр буй болгож ялын төрөлд үндсэн өөрчлөлт оруулсны дээр зарим зүйлд заасан хорих ялын доод хэмжээг өсгөх буюу дээд хэмжээг багасгах зэрэг үндсэн өөрчлөлтүүдийг оруулсан байна.

Шинэ эрүүгийн хуулийн хүрээнд тусгай ангийн "Өмчийн эсрэг гэмт хэрэг" хэмээх XIX бүлгийн 148 дугаар зүйлд "Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах" гэмт хэргийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

148.1. Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

148.2. Энэ гэмт хэргийг давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

148.3. Энэ гэмт хэргийг урьд нь энэ хэрэгт болон хулгайлах, булаах, завших, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

148.4. Энэ гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан нь өмнөх хуулиас оногдуулах ял нь

⁵⁵ БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 1991.04.19-ний өдрийн 13 дугаар тогтоол

⁵⁶ БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 1997.06.23-ны өдрийн 25 дугаар тогтоол

хүндэрч, “зохион байгуулалттай бүлэг”, “гэмт бүлэглэл”, “албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн” зэрэг нэмэлт шинжүүдийг тодорхойлсон байна.

Дүгнэлт

Эрх зүйн түүхэнд хамаарах эх сурвалжийг судлан үзэхэд, залилах гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжийн хөгжлийг түүхийн дараах үечлэлд ангилан үзэх боломжтой байна. Үүнд:

Эртний үе. “Их засаг”, “Алтан хааны цаазын бичиг”, “Монгол-Ойрадын хууль”, “Зарлигаар тогтоосон гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг”, “Халх журам”

Богд хаант Монгол Улсын үе.

Ардын хувьсгал ба түүний дараа үе.

- БНМАУ-ын 1926 оны шүүх цаазын бичиг
- БНМАУ-ын 1929 оны Шүүх цаазын бичиг
- БНМАУ-ын 1934 оны Шүүх цаазын бичиг

Социалист үзэл баримтлалын үе

- БНМАУ-ын 1942 оны Эрүүгийн хууль
- БНМАУ-ын 1961 оны Эрүүгийн хууль
- 1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль.

Чөлөөт эдийн засагт үзэл баримтлалын үе

- 1993 оны нэмэлт өөрчлөлт оруулсан Эрүүгийн хууль
- 2002 оны Эрүүгийн хууль.

Дээрх түүхэн сурвалжийн залгамж шинж, чанарыг дүгнэн үзвэл,

- Их Засаг хуульд залилан мэхлэх гэмт хэрэгт эрүүгийн ял шийтгэх тусгайлсан заалт байхгүй бөгөөд харин залилан мэхлэх гэмт хэргийг хулгайлах гэмт хэрэгтэй хамтатган үзсэн;
- Юан гүрний нэвтэрхий хуульд луйврын хэсэгт ямар ч эрхгүйгээр өөрийгөө түшмэл хэмээн нэрийдсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцсон;
- Алтан хааны цаазын бичигт хулгай худал гэдэг утгаар хулгай гэсэн заалтад залилан мэхлэх гэмт хэргийг хамтатган авч үзсэн;
- Монгол Ойрадын хуульд Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнд холбогдох заалтуудаас нийт 18 заалтыг залилах гэмт хэрэгт тооцохоор авч үзсэн;
- Халх журам хуулинд аливаа илт хулгай /дэрэмдэх, булаах/, Засаг захиргааны журам ба хэв ёс зөрчсөн, өөрийгөө элч гэж бусдыг хуурч мэхлэн залилж төлбөр хийлгүйгээр унаа унаж, хоол хүнс хэрэглэж буй үйлдлийг залилан мэхлэх гэмт хэрэгт тооцсон;
- Хууль зүйлийн бичигт аливаа залилан хуурмаглах нь аливаа зарлигийн бичгийг хуурмаглан бичих, нэмэх, хорогдуулах, зарим хэмээн хуурмаглан буулгах, зарлигт өчих бичиг айлтгахад үнэнгүй хуурмаглахыг гэмт хэрэг гэж үзсэн;
- БНМАУ-ын 1926 оны Шүүх цаазын бичигт ашгийг хичээж залилан мэхэлж бусдын эрхийг эдлэх буюу эсхүл эд юмыг ашиглан явдлын улмаас сүйтгэл шингээх үйлдэл;
- БНМАУ-ын 1934 оны Шүүх цаазын бичигт Бусдын мөнгө буюу эд хөрөнгийг ба эзэмшиж эдлэх эрхийг залилан мэхлэх, хэн хүн алив хутагт хувилгаан хэмээх нэрийг хэрэглэх буюу олгох зэргээр олныг мэхлэх, цэргийн гавьяаны одон тэмдэг болон үйлдвэрийн гавьяаны одон тэмдгийг зүүх эрхгүй этгээд нараас зүүх үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцсон.

БНМАУ-ын 1942 оны Эрүүгийн хуульд залилан мэхлэх гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн бодлогын хүрээнд уг хуулийн ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцлийг тусгаж өгсөн бол 1961 оны Эрүүгийн хуульд залилан мэхлэж итгэлийг эвдэх, шунахайн замаар иргэдийн хөрөнгө буюу түүнийг эзэмшихээр далайлган сүрдүүлэх үйлдлийг гэмт хэрэгт тооцсон байна.

1986 оны Эрүүгийн хуульд залилан мэхлэх гэмт хэргийн халдлагад социалист өмч өртвөл ялын бодлогын хувьд хүндрүүлж үзэхээр заасан бол Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжснээр мөнгөний /төгрөг/ ханш буурч, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тариф ихээхэн өссөнтэй холбоотойгоор 1993 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар залилах гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээг нэмэгдүүлж, нарийвчлан зохицуулсанаараа онцлогтой.

Энэхүү түүхэн цаг үеийн уламжлал нь төрт ёс, эрх зүйн хөгжлийн үнэт сурвалж мөн бөгөөд залилах гэмт хэргийн мөн чанар, онцлог, үйлдлийн шинж, арга хэлбэрийг судлахад тус дөхөм болох юм.

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ДУНДАД ЗУУНЫ МОНГОЛ УЛС БА МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНД
ХАМААРАХ ЭХ СУРВАЛЖИЙН СУДАЛГАА
/Түүхийн философийн зарим ухагдахуун/

*Н.Манлайбаатар
Докторант*

Товч агуулга. Монголчуудын түүхийн эх сурвалжуудаас аливаа гэмт үйлдлийг мөрдөх, шалгах, илрүүлэх хийгээд шийдвэрлэхүйн талаарх үнэ цэнэтэй мэдээ, баримтыг нээн илрүүлэх нь цаашид судлаачдад багагүй учир холбогдолтой тул бид уг илтгэлээр түүхийн тодорхой баримтуудыг философийн эмпиризм, рационализмын агуулгаар баяжуулан дүгнэхийг оролдлоо. Өөрөөр хэлбэл, түүхийн үнэ цэнэтэй эх сурвалжуудад агуулагдаж буй баримтыг дахин авч үзэх замаар шинэчлэх, орчин цагийн үзэл санааны үндэс хэрхэн бүрэлдэн төлөвшсөн болохыг тодотгохыг хичээсэн болно.

Түлхүүр үг. Эрүүгийн процессын эрх зүй, эрүүгийн процессын түүх, мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөн байцаалт, мөрдөн мөшгих, мөрдөн нотлох.

Их Монгол улсын төр, эрх зүйн түүхийн хувьд шүүх эрх мэдлийн талаар тун тодорхой зохицуулжээ. Тухайлбал, шүүн таслах дээд эрхийг хаан эдлэх бөгөөд улсын дээд заргач буюу шүүгчийг хаан өөрөө томилж байсан нь эртний монголчуудын тотсон хэв, заншлыг хадгалсан нь илэрхий байдаг.

Чингис хаан Их Монгол улсыг байгуулаад, төр засаг, захиргаа, цэрэг, хууль цааз, газар хамжлага хуваах зэргээр нийгэм, эдийн засгийн иж бүрэн шинэчлэл хийсэн билээ. Их засаг хууль⁵⁷-ийг Их Монгол улс даяар мөрдүүлж, хуулийн заалтыг нарийн чанд хэрэгжүүлэхээр улс орон даяар шударга ёс тогтоох, амар амгалан байдал тогтоох, хууль цаазын шинэтгэлийг хэрэгжүүлсэн нь чухал ач холбогдолтой болсон⁵⁸ гэж үздэг.

⁵⁷ Их засаг хуулийн талаар өрнө, дорнын сурвалжуудад олонтоо тэмдэглэж, зарим нь засаг хуульд ийм заалт байсан хэмээн бичиж тэмдэглэсэн нэлээд буй. Гэвч эдүүгээ хүртэл Их засаг хуулийн эх хараахан олдоогүй байна. Иймээс Их засаг гэж ямар хууль байсан талаар судлаачдын дунд маргаан, мэтгэлцээн өрнөсөөр ирсэн билээ. Судлаачдын байр суурийг нэгтгэн үзвэл, 1-рт: Их засаг нь нийгмийн бүх л харилцааг зохицуулсан нэгдэл хууль, эсвэл хуулиудын эмхэтгэл байсан гэдэг үзэл баримтлал, 2-рт: Их засаг нь төрөөс тогтоосон хууль болон ард түмний дунд дэлгэрсэн билэг сургаал хоёроос бүрдэж байсан гэдэг, 3-рт: Их засаг нь хууль биш, заншлын хэм хэмжээ, зарлиг, билэг сургаал, хорио цээр, захиасын цуглуулга гэсэн нийтлэг байр суурь, үзэл санаа бий. Энэ тухай Ц.Минжин. Их засаг. Түүх, эрх зүйн шинжилгээ. Уб., 2009 он. 77-79 дэх талд үзнэ үү.

⁵⁸ Б.Батсүрэн, П.Дэлгэржаргал, У.Эрдэнэбат нар. Их Монгол улс. Монголын эзэнт гүрний түүх. Тэргүүн боть. Уб., 2019 он. 579 дэх тал. Монголын нууц товчоонд тэмдэглэснээр, Чингис хаан: “Гүр улсын хулгайг гэгсгээж, худлыг мохоож, үхүүлэгдэхүүн ёстныг үхүүл, алагдахуун ёстныг алдуул” хэмээн гүр дээрийн зарга түшив. Улмаар Чингис хаан: Гүр иргэний хувь хувилсныг, зарга заргалсныг, хөх дэвтэрт бичиж, дэвтэрлэж, ургийн ургаа хүртэл Шихихутагийн надад зөтгөж, ёсолж, хөх бичиг цагаан цаасанд дэвтэрлэснийг бүү егүүтгэтүгэй. Егүүтгэхүн аран (хүмүүс) алдалтан болтугай хэмээн зарлиг буулгажээ. МНТ. 203, Баабар. Монгол түүх. Уб., 2020 он. 78 дахь талд “Чингис хаан хойч үедээ Их засаг хуулийн тогтоц үлдээсэн. Их засаг

Хааны айлдвар хууль цаазыг эрхэмлэх явдал байжээ. Зарлигаас дурьдвал: “...Хожим таван зуун жил, мянган он, түмэн оныг хүртэл намайг залгамжлах миний хойч удам төрөн гараад хаан төрийг барихдаа яаж том болох нь хамаагүй, гагцхүү Чингисийн төр ёс (yosun), засаг (yasaq) хуулийг үл өөрчилж, хадгалан баримтлах аваас Мөнх тэнгэр хишгээ хүртээж, тэд маань ашид мөнхөд хотлоороо энх амар, төрлөөрөө түвшин жаргалтай байх болмуй заа” гээд мөн “Үүний хойно миний үр садын дотор олон хаад төрөн гарах болмуй. Тэднийг түших баатар, ноёд хууль цаазыг хатуу сахихгүй болвоос төрийн хэрэг доргиж тасалдаад ирмүй. Тэр цагт Чингис хаанаа хичнээн хүсэвч байхгүй байх юм⁵⁹” гэх зэргээр хууль цаазыг эрхэмлэх, бат сахих талаар зарлигдажээ.

Чингис хааны хувьд Их засаг хуулийг зарлиглан тогтоосон. Түүний ажигч гярхай мөрч, нягтлан шалгагч, хүний хэлснийг газар дээр нь шалгаж үздэг байсан нь хожим “Шихихутуг Хорезмын султан Желаладдинтай тулгарч цохигдон буцаж, их хаанд энэ тухайгаа сонордуулсан бөгөөд хаантан тэдний тулалдсан газарт ирж –Чи яаж байрлаад султан яаж байрласан буй? гэвэл Шихихутуг хариулсанд, Шихихутуг хийгээд Султан хоёрын аргыг шоолж өгүүлсэн нь: Чи байлдах газраа сонгож мэддэггүй юм байна, хоёул хоёулаа алдсан байна⁶⁰” гэсэн байна. Энэ нь хааны бусдад итгэхийн хамт, өгүүснийг бататгах талаар тодорхой ажиллагаа явуулж байсны илрэл гэлтэй. Өөрөөр хэлбэл, өнөөгийн мөрдөн байцаалтын тодорхой ажиллагааны нэг болох мэдүүлгийг газар дээр нь шалгаж буйтай төстэй үйлдэл болжээ. Үүнийг бататгах мөн нэгэн баримт бий. Тайчуудад Тэмүжин баригдаад удалгүй зугатсны дараа мөрдөж, эрсэн /бэдрэх⁶¹/ нь нэгэнт тодорхой байдаг. Түүнчлэн, Тэмүжинийг эрж олохоор нөхөр зуураа “нэгжье⁶²” хэмээгээд Сорхон шарын гэр, тэрэг, исэри /ор/-ийн дор хүртэл нэгжээд эс олж, хар тэргэнд очиж амсарт бүхий унгасыг татлаж үзсэн ба Сорхон шар “Энэ бас ийм халуунаа унгасан дор хэр дуусах⁶³” гэсэн дор нэгжүүл /нэгжигч/ больсон байдаг тухай бид мэдэх билээ. Мөрдөн байцаалтын тактикийн шинжтэй алдаа гарсан түүхийн анхдагч тохиолдол Нууц товчоо, Алтан товчид тэмдэглэгджээ. Мөн найман шаргыг алдаад мөрөөр нь мөшгөсөн тухайг бид анхаарах ёстой. Өөрөөр хэлбэл, нэгдсэн төрт улс бүрэлдээгүй, тархай бутархай овог,

хууль нь Жүвэйни, Рашид ад-Дин нарын зохиолоор дамжин утга санаа нь эдүүгээ хүртэл үлдэж хоцорсон байна” гэжээ.

⁵⁹ Рашидаддин Фазлуллах. Шашдирын чуулган. Дэд боть. Орч. Проф. Хатагин Го.Аким. Уб., 2020 он. 361 дэх талд үзнэ үү. Их хааны хууль цаазын хийгээд цэрэг, иргэн, зохион байгуулалтын шинтэй олон зарлиг энд байгаа юм. Хууль дээдлэх үлзэл санааны хувьд монголчууд нэн эртний улбаатай үзэл санаа бүхий үндэстэн билээ.

⁶⁰ Рашидаддин Фазлуллах. Дурдсан бүтээл. 316-317 дахь талд үзнэ үү.

⁶¹ Алтан товч. Хэвлэлд бэлтгэсэн Ц.Шагдар. Уб., 1957 он. 28 дахь тал. “Бэдрэх” үйл үгээс “бэдрэв” гэж тухайлан хэрэглэсэн нь уг эх сурвалжид үлдсэн бөгөөд – утга нь “эрэх”, “хайх”, “мөшгөх”, “мөрдөх” гэсэн утга илэрхийлж байгаа нь энд илтэд байдаг. Бидний үзэж байгаагаар 12-13 дугаар зууны монголчуудын аман болоод бичгийн хэлэнд мөрдөх гэсэн үеийн оронд хэрэглэж байсан үгийн онцлог байдлыг анхаарч үзэх шаардлагатай.

⁶² Дурьдсан бүтээл. 29 дэх талд ийнхүү бичжээ, Монголын нууц товчоог 365 хоногт. Монголын нууц товчоо сан. Уб., 2015 он. 47 дахь талд “нэгжлэлдье” хэмээлдэж “нэгжлэлдэв” гэж бичжээ, А.Амар. Монголын товч түүх. Уб., 1989 он. 105 дахь талд нэгжив гэжээ, Нийтлүүлэгч Ш.Гаадамба. Монголын нууц товчоо. Зарим үгийн тайлбар толь. УБ., 1990 он. 277 дахь талд “нэгжилдүй-е” /нэгжилдье/ гэж галиглаад “өвөр зуураа нэвт шувт эрье” гэж утгачилсан байна, Э.Авирмэд нар. Монгол хууль. Уб., 1997 он. 10 дахь талд “ялтан баригдагсдыг эрж олохын тулд айлын бараанд нэгжлэг хийж ялтан хүнийг нуусан хэнийг боловч хатуу шийтгэдэг байжээ” гэжээ. Үүнээс үзвэл, хэрэг заргад холбогдох аливаа хүн, эд зүйлийг эрж олохоор нэгжлэг хийх ажиллагаа явагдаж байсны илрэл, мөрдөн байцаалтын тодорхой ажиллагааны нэг хэлбэр түүхэн эх сурвалжид ийнхүү тэмдэглэгдсэн байна.

⁶³ Монголын нууц товчоог 356 хоногт. Монголын нууц товчоо сан. Уб., 2015 он.

аймгаараа амьдарч байгаа нөхцөлд аливаа хэрэг, заргыг тогтоох явдал нь хохирогчийн хүсэл эрмэлзэлд үндэслэж байсан явдал юм.

Чингис хаан айлдсан нь: “Хэрэв миний ургийнхаас хэн нэг нь нэгэнт тогтсон Их засаг /Yasaq/ хуулийг зөрчвөл амаар сургамжилтугай, хэрэв түүнийг дахин зөрчвөл донгодтугай, харин гурав дахиа зөрчвөл алс холын Дөрвөлжин Хулчунд нутаг заатугай. Тийшээ яваад засраагүй бол дөнгөлөөд хар гэрт хорьтугай. Тэндээс гараахдаа төрх төлөв нь засарсан, ухаалаг болсон байвал тэр чинээ сайн хэрэг, чингээгүй байвал түүний ойр, холын бүх төрөлүүд нь хуран цуглаж, зетэлдэн зөвлөлдөж түүнийг яахыг шийдэгтүн⁶⁴” гэсэн нь алтан ургийнханд онцгой эрх дарх, илтгэл хүлээлгэж байсны илрэл юм. Ер нь Алтан ургийнхан Их засгийг зөрчвөл гяндлах, цөлөх⁶⁵ нь хамгийн хүнд шийтгэл байсан нь илэрхий.

ХБНГУ-ын хуульч, эрдэмтэн Х.Шоллер “Чингис хааны үеийн эрх зүй нь үүсэл гарлаараа иргэний эрх зүйт /Civil law/ улсуудын эрх зүйн бүлд багтах бөгөөд өөрөөр хэлбэл, Ромын эрх зүйгээс үүсэлтэй эх газрын буюу Европын эрх зүйн тогтолцоонд хамаарагдана⁶⁶” гэсэн нь үндэстэй бөгөөд хааны тогтоосон айлдвар, зарлиг нь тухай үеийн нийгмийн харилцаан зохицуулж, улмаар Их засаг хууль бүтсэн нь гэдэгтэй эрдэмтэд⁶⁷ санал нэгдэж байна.

Их хааныг бие барсны дараа хаан сууринд Өгэдэй заларч хамгийн түрүүнд айлдсан нь: “Чингис хааны өмнө буулгаж байсан зарлиг хүчин төгөлдөр бөгөөд түүнийг хэрхэвч өөрчлөн хувиргаж үл болмжуй. Бидний хаан ор суух өдрийг хүртэл үйлдэгдсэн гэмт хэрэг, алдаа эндэгдлийг бид өршөөн хэлтрүүлэх боловч үүнээс хойш хуучин, шинэ зарлигийг зөрчсөн үйлдэл хийж зүрхэлсэн хэнийг боловч гэсгэсэн цээрлүүлж, гэмд нь таарсан шийтгэлийг хүлээлгэх болмуй⁶⁸” гэсэн нь монгол төрийн хууль цаазын тогтвортой байдал, дараагийн үедээ ийнхүү уламжлагдан өвлөгдөж байсны улбаа гэлтэй. Ийнхүү үзэх нь үндэстэй бөгөөд бидний авч үзэж буй мөрдөн шалгах /мөрдөн байцаалт/ ажиллагаа ч уламжлан үе улирч өвлөгдсөн утга буйг энд цохон тэмдэглэх нь зүйтэй.

Гэтэл зарим судаалчид, тухайлбал, В.А.Рязановский бүтээлдээ “тухайн үед хэрэг маргааныг шүүн таслаж байсан зарим баримтыг дурьдсан атлаа, мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагаа нь дур зоргын шинжтэй байсан гээд, шүүхийн тогтолцоо, шүүхээс мөрдөн шалгах ажиллагааны талаар шийдвэр гаргадаггүй байсан нь шүүхийн байгууллага, мөрдөн байцаалтын тухай ямар нэгэн ойлголт байхгүй, хөгжлийн эхэн үедээ байсныг илтгэнэ⁶⁹” гэсэн илэрхий логик зөрчилтэй дүгнэлт хийсэн нь сонирхол татаж байна. Бидний судалгааны ажлаар хэрэг маргааныг шийдвэрлэх зорилгоор тодорхой шалгах ажиллагаа явуулж байсныг хойшид бататгах болно.

Их Монгол улсын залгамж Юань гүрний хувьд хууль шүүхийн тогтолцооны хувьд бие даасан тогтолцоо байгаагүй ба харин төрийн захиргааны байгууллагын харьяанд шүүхийн үүргийг хэрэгжүүлдэг байгууллага, шүүгчдийн бүхэл бүтэн тогтолцоо бүрэлдэн бий болжээ. Үүний хүрээнд эрдэмтэн, судлаачдын үзэж байгаагаар Юань улсын шүүгч /заргач/ бүгд 96 түшмэл байсан бөгөөд тэдний 42 нь удирдах үүрэгтэй төрийн нэгдүгээр зэрэг дэвийн монгол заргач нар байжээ. Тэдний

⁶⁴ Рашидаддин Фазлуллах. Дурдсан бүтээл. 365 дахь тал.

⁶⁵ И.Дашням. Дурдсан бүтээл. 357 дахь тал.

⁶⁶ Х.Шоллер. Эрх зүйн ангилал ба соёлын тухай. Эрх зүй сэтгүүл. УБ., 2001. 27 дахь тал.

⁶⁷ Ж.Болдбаатар, Д.Лендээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. УБ., 1995. 20-21 дүгээр тал.

⁶⁸ Рашидаддин Фазлуллах. Дурдсан бүтээл. 379 дэх тал.

⁶⁹ В.А.Рязановский. Монголын эрх зүй түүхэн судалгаа. Харбин /Хятад/ 1931 он. Орчуулсан Г.Мөнхтулга. УБ., 2021 он. 40-41 дүгээр тал.

цалин пүнлүү бусдаас дээгүүр, эрх мэдэл ч илүү өргөн байсан ба уг шүүх нь гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн байцаалт явуулж хэрэг үйлдсэнийг нь тогтоох, хэрэгтэнд ял оногдуулах, улмаар ял эдлүүлэх үндсэн үүрэгтэй байсан⁷⁰ гэж үзсэнтэй бид санал нэг байна. Үүнийг бататгах баримтыг Юань улсын судрын зургаадугаар дэвтэрт “Зургаадугаар он (1269 он)-ы хаврын цагаан сарын харагчин үхэр өдөр (Корйө) Гаоли улсын ван Ванжи элч зарж эрх барьсан түшмэл Жин Жяожунь (jin jiao jun)-ийг цаазаар аваачсаныг хэлэхээр ирэхэд цаг улирлыг тооны бичиг ба Сичуань хязгаарт хэмэрлэг хүртээв. Дөрвөн замын байцаан шийтгэх хэлтэс байгуулав. Хоёр сарын шар морин өдөр дөрвөн замын эрхийг баригч байцаан шүүх хэлтэс байгуулаад зарлиг олон замд ухуулав⁷¹” гэж тэмдэглэгджээ. Мөн Юань гүрний үед Давааны арын орон⁷² хэмээх нутаг дэвсгэрт Их засаг хууль үйлчилж байсан⁷³ гэж үзсэнтэй санал нэг байна.

Их засаг хууль хийгээд хэрэг зарга шийдэж, мөрдөн байцааж байсан талаар гэрч баримт татах нь. Тухайлбал,

Хүлэгү хааны хөвүүн Аргун хаан:

Ил хаант улсын хаан Аргуны биеийн байдал муудаж /1290-1291 он/ түүний эмчилгээ удал үргэлжилжээ. Нэгэн өдөр түүний багш орж ирэн, гурван хундага дарсыг Аргунд өгчүхүй. Тэр нь түүний биед ороход өвчин дахиж, бүүр архагшиж ирэвэй. Гэтэл бөө нар хонины далаар мэргэлээд өвчнийг хараал жатгаас үүссэн байна гэхүйд хардлага Тогачаг /Тугчаг гэсэн буй/ хатан дээр бууж, түүнийг эрүүдэн, тамлан байцааж байгаад олон эмэгтэйн хамт голд живүүлсэн ажгуу. Энэ явдал 690 оны мухаррам сарын 16-нд (1291 оны нэгдүгээр сарын 19) болжухуй⁷⁴ гэжээ.

Хэрэг хүлээлгэхээр ийнхүү эрүүдэн шүүж, тамлаж байцаасан гэрч баримт нь мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаа бөөгийн нөлөөнд автаж, баримтлаж байсныг илтгэж байна. Түүнчлэн, Ил хаант улсын хаадын ихэнх нь мэргэ, төлгө хийлгэх, өөрсдөө ч мөн мэргэлдэг байсан⁷⁵ бөгөөд энэ нь гэмт үйлдлийг нотлох, шүүн шийдвэрлэхэд огт нөлөөгүй байсан гэж үзэх нь үндэслэлгүй⁷⁶ билээ.

⁷⁰ И.Дашням. Монголын Юань гүрний төр эрх зүйн түүх. (1260-1368) Уб., 2017 он. 112-113 дах тал. Юань гүрэнд хүний амь нас хохирсон тохиолдолд түүний шалтнааныг тогтоох зорилготой 1304 онд баталсан “Хүүрийг шалгах хуулийн ёс” хэмээх хууль байсан бөгөөд цогцосыг шалгах 70 гаруй оношлогоог заасан байдаг тухай мөн тэнд үзнэ үү.

⁷¹ Монгол Улсын Боловсролын их сургууль, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Түүхийн тэнхим. Юань улсын судар. Хураангуй дээд, доод дэвтэр, 1-15 дугаар дэвтэр. Уб., 2021 он. 164 дэх тал.

⁷² И.Дашням. Монгол Улсын төр, эрх зүйн түүх. Дэд боть. (Дэлхийн дорно, өрнө дахинд байгуулагдсан монголын хаант улсуудын төр, эрх зүйн түүх) Уб., 2011 он. 179 дэх тал. Юань гүрний үед Их Монгол улсын цөм болсон монгол газар нутаг тус Давааны арын хэмээх нэгэн муж болжээ гэж бичсэн байна.

⁷³ И.Дашням. Монгол Улсын төр, эрх зүйн түүх. Дэд боть. (Дэлхийн дорно, өрнө дахинд байгуулагдсан монголын хаант улсуудын төр, эрх зүйн түүх) Уб., 2011 он. 183 дахь тал.

⁷⁴ Рашидаддин Фазлуллах. Шашдирын чуулган. Гутгаар боть. Орч. Проф. Хатагин Го.Аким. Уб., 2020 он. 700-701 дэх тал, Д.Анхбаяр. Ил хаант улс. Монголын эзэнт гүрний түүх. Тавдугаар боть. Уб., 2019 он. 259 дэх тал.

⁷⁵ Тухайлбал, Хүлэгү хаан, Хасан хаан нар дайн байлдаанд явах, бусад зүйлсийн талаар урьдчилан мэдэх зорилгоор мэргэ тавиулах, өөрсдөө мэргэлж байсан байна. Д.Анхбаяр. Ил хаант улс. Монголын эзэнт гүрний түүх. Тавдугаар боть. Уб., 2019 он. 259 дэх талд үзнэ үү. Мөн өнөө үед ч мэргэ хийх, түүний ёс уламжлал монголчуудад өвлөгдөн ирсэн бөгөөд энэ тухай Монголын Үндэсний телевизийн эфирээр 2021 оны 07 дугаар сарын 09-нд 08:00-08:30 цагт нэвтрүүлсэн “Нүүдэлчдийн өв соёл: Дал” нэвтрүүлгээс үзнэ үү. Доктор (Ph.D) С.Бадрал “Хонь гаргахад түүний бүхий л эд эрхтэн мэргэ буулгах, түүний үр дүн нь үндсэндээ амьдралд батлагдах нь надад түгээмэл үзэгдсэн билээ”, мөн “Рубрук Монголын эзэнт гүрэнд ирэхэд

Дээрх хэргийн дараахан 690 оны мухаррам сарын 24-нд (1291 оны нэгдүгээр сарын 27) Аргун хаан Кура голыг гатлан, Арран дах Багча орддоо буужээ. Түүний бие улам муудаж, хүний гарт оров. Харин хатан Тогачаг алсан хэргийн талаар Султан Идээчийг шүүх ажиллагаа, мөрдөн шалгах ажиллагаатай хамт явагдаж мэдүүлэг авч, зөрүүтэй байсан мэдүүлгийг шалгаж, улмаар хатанг алсан хэсэг ноёдыг бүгдийг нь цаазаар авсан⁷⁷ билээ. Уг хэргийн гэрч баримтыг шалгасан нь өнөөгийн мөрдөн байцаалтын ажиллагааны тактик, арга зүйн шинжтэй өгүүлэмж илэрч байгаа нь бидний анхаарлыг татаж байна. Уг хэргийн дараа лал, хобрай нарын гэрийг нэгжин тэмээ туйлсан мэт урвуулж, булсан эрдэнэс хайн гэрийн шалыг хүртэл ухаж үзсэн⁷⁸ байна. Өөрөөр хэлбэл, аливаа гэмт хэргийг нотлохын тулд баримт цуглуулах зорилгоор мөрдөн байцаалтыг явуулахдаа мэдүүлэг авах, мэдүүлгийг шалгах, нүүрэлдүүлэх, нэгжих, үзлэг хийх зэрэг тодорхой мөрдөн шалгах ажиллагаа явуулж байжээ.

Монгол, түрэг аймгийн тэргүүнүүд, дээд албан тушаалтнууд, түмт, мянгат, аравтын захирагч хийгээд нүүдэлчин ардуудын тухай юм уу хүмүүс хоорондын маргааныг Их засаг хуулийн дагуу шийдвэрлэх үйл явцыг *яреу* буюу *заргалан шүүх* хэмээнэ. Заргалан шүүх ажиллагаа нь хэн нэгний зараг мэдүүлэх, шалгалтын явцад алдаа эндэгдэл илэрснээс үүдэн тухайн хэргийн талаар сэжиг таамаг, баримт нотолгоо бүхий этгээд мэдээлэл өгснөөр хэрэг үүснэ⁷⁹ гэж түүхч Д.Анхбаяр хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт хийсэн байна.

Түүнчлэн Ил хаант улсад хэрэг зарга шийдвэрлэх ажиллагаа нь мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явагддаг байсан баримт байгаа нь шүүхийн өмнөх шатны мөрдөн шалгах ажиллагааны баримтанд тулгуурлан явагдаж байсан гэж үзэж болхоор байна.

Авага хааны хөвүүн Гайхату⁸⁰ хаан:

Булха⁸¹ болсон ноёдыг барьж гэсгээсэн инү: Ёспол, найр өндөрлөхөд шабан сарын шинэдээр (1291 оны наймдугаар сарын эх) ноёдыг баривчлан шүүж эхэлбэй. Гайхатугийн хувьд гэвэл тэрбээр ах Аргун хааны үхсэн, ноёд, шадар сайд нарыг алсан шалтгааны тодруулахыг хүсэж байлаа. Эхэн үед Гайхатуг шүүх хурал дээр биеэр суувай⁸² гэжээ.

Хэдийгээр Гайтаху хаан өөрийн ах Аргуны үхэлийг тодруулахаар шүүх хэлэлцэж байгаа хэдий ч нэлээд олон гэрч, хэрэгт сэжиглэгдэж буй ноёдоос мэдүүлэг авах, хэрэг хүлээхийг нь анхаарч, ял оногдуулахдаа хөнгөрүүлэх, хүндрүүлэх

хонины шатаансан дал барьсан нэгэнтэй таарсан” гэх баримт буй. Тийм ч учраас бид сэдэвтэй хамаарах мэргэ, төлгө буулгаж байсан болохыг бататгаж байна.

⁷⁶ Эдүүгээ илрээгүй хэргийн талаар зөнчдийн тулаанаар, мөн зарим тохиолдолд хэрэг нь илрэх, алдсан гэсэн зүйлээ олох, эрж хайвал олдох эсэхийг мэргэлүүлдэг нь түгээмэл буй.

⁷⁷ Рашидаддин Фазлуллах. Дурдсан бүтээл. Гутгаар боть. 701-702 дахь тал.

⁷⁸ Рашидаддин Фазлуллах. Дурдсан бүтээл. Гутгаар боть. 702 дахь тал.

⁷⁹ Д.Анхбаяр. Ил хаант улс. Монголын эзэнт гүрний түүх. Тавдугаар боть. Уб., 2019 он. 177 дахь тал.

⁸⁰ Б.Чадраа. Монголын үндэсний нэвтэрхий толь. Уб., 2009 он. 348 дахь тал. Гайхату /Гехату/ Иран дахь Монголын Ил хаант улсын 5 дахь хаан. Тэрээр авилга авч, түүнийх нь хэмжээгээр перс ноёдыг төрийн чухал албанд томилох зэрэг зүй бус алхмууд хийсний гайгаар амьдаараа булуулжээ. Энэ нь төрийн тэргүүний үйлдсэн хэрэгт цаазын ял оногдуулсан нийт ард түмний хүсэл эрмэлзлийн үр дүн байсан ажээ.

⁸¹ Дайн самуун, дайсан гэсэн утгачилжээ. Проф. Го.Аким.

⁸² Рашидаддин Фазлуллах. Дурьдсан бүтээл. Гутгаар боть. 706-707 дахь тал. Энд шүүх хуралдааны үеэр шүүхийн мөрдөн шалгах ажиллагаа явагдаж буй нь илэрхий байдаг. Тухайлбал, хаан Гайхатуг Ноёдыг ахлаж байсан Шигтүр ноёноос мэдүүлэг авч, улмаар мэдүүлгийн зөрүүтэй байдлыг нүүрэлдүүлэх замаар гаргаж, хэрэг хүлээлгэж байжээ.

байдлыг харгалзсан байна. Мөрдөн шалгах ажиллагааг /мөрдөн байцаалт/ шүүх хуралдааны хамт явуулж буй нь процессын бас нэгэн онцлог ажээ.

Аргун хааны хөвүүн Хасан хаан:

Сирээс буцаж ирсэн ноёд, цэргийг шүүсэн инү: Дулахада сарын 12-ноо (1303 оны зургаадугаар сарын 28) хаан туг Ужанд залагдсны маргааш нь шүүх хуралдаан эхэлбэй. (Тэднийг) их л нарийн байцаан шалгасан боловч байцаасан тэмдэглэлийг танилцуулбал хаантан хэд хэдэн зүйлийг онцолж, шүүх ажиллагааг бүр шинээр эхлүүлж, тэдгээр зүйлсийг тодруулан, дулхижжа сарын нэгнээ (долдугаар сарын 17) шүүх ажиллагааг дуусгаж, _____⁸³, Дарханы хөвүүн Агутай Дархан, Мангут аймгийн Тогтоон Төмөр нарыг цаазалбай. Тэр бүхнийг Их засаг хуулийн дагуу гүйцэтгэсэн болмуй⁸⁴ хэмээн тэмдэглэсэн байх нь бидний анхаарлыг татлаа.

Эндээс хэд хэдэн зүйл тухайн үед цэгцлэгдсэн, тодорхой үе шаттай байсан нь илэрхий байна. Үүнд: 1. Шүүх хуралдаан явагдахтай холбоотой бэлтгэл хангах, 2. Шүүх хуралдаан явагдахаас өмнө хэргийн талаар тодруулж байцаан шалгадаг байсан /мөрдөн байцаалт/, 3. Шүүхээр хэлэлцүүлэн шийдвэрлэх, шүүхийн өмнөх шатанд гүйцэт нотлогдоогүй үйл баримтыг шүүхээр тогтоох тодорхой ажиллагааг явуулж байсан, 4. Шүүн таслах ажиллагаа нь хэргийн ээдрээтэй байдлаас шалтгаалж нэлээд хэдэн өдрөөр хэлэлцдэг байсан /хугацаа тоолох, хууль зүйн талын нарийн зүйл өдгөө хүртэл мэдэгдээгүй байна/, 5. Оногдуулсан ялыг гүйцэтгэх гэсэн үе шатууд тодорхой байна.

Ил хаант улсын Хасан хааны зарим зарлиг нь шүүх эрх мэдлийг бэхжүүлэх, хэрэг, зарга шийдвэрлэх талаар онцгой анхаарч байсан. Тухайлбал, “Басхаг, малиг нар, бидний өмнөөс мунжид эрхийг барьж байгаа хүмүүс мэдтүгэй. Мэдүүлэх ину, ямар ч хэрэг, тохиол таарлаа гэсэн, цаазын заалтанд холбогдолтой бол ямар ч ажил тулгарлаа гэсэн тэр муж хийгээд түүний харьяа газарт шүүн таслах албанаа бидний томилсон хүнд мэдэгдэж, түүгээр эцэслэн шийдвэрлүүлж байгтун..., ...Чингис хааны Их засаг хуулиар шүүгч, эрдэмтэн, Алийн удмынхан⁸⁵ алба гувчуураас чөлөөлөгдөж байсны тул бид ч бас тэднийг чөлөөлмүй..., ...хэрэг заргыг шийдвэрлэхэд нотлох баримттай шийдвэрлэх⁸⁶...” гэх зэргээр зарлиг гаргажээ. Энэ нь шүүхийн өмнөх шатанд нотлох баримт бүрдүүлэх, тодорхой төрлийн мөрдөн шалгах ажиллагааг явуулж, эргэлзээгүйгээр хэргийг шийдвэрлэх тухай асуудлыг мөн анхаарч байжээ.

Аливаа хэрэг заргыг шийдвэрлэхэд аль болох Их засаг хуулийн дагуу үнэн шударга ёсыг баримтлах бөгөөд Шихихутуг “айж цочин хэрэг хүлээх хэрэггүй”, “айлгүй үнэн ээ хэл⁸⁷” хэмээх алдарт эшлэл нь Монголын эзэнт гүрний хэмжээнд

⁸³ Рашидаддин Фазлуллах. Дурдсан бүтээл. “Чинг” үгүй бол “Жибик” гэсэн нэр байсан байж магадгүй. – Такстон. 794 дэх тал.

⁸⁴ Рашидаддин Фазлуллах. Дурдсан бүтээл. Мөн тэнд. Уг хэргийг шийдвэрлэсэн хаан нь Иран дахь Монголын Ил хаант улсын Хүлэгүгийн удмын хаан Газан /Хасан гэж бас бичнэ/ билээ. 100 гаруй жил Иранд оршин тогтносон Монголын Ил хаант улсын хамгийн алдартай хаан бөгөөд Их засаг хуулийг ягштал баримтлагч, улсын шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч дээд хүн.

⁸⁵ Шашны зүтгэлтнүүд, тэднийг татвараас чөлөөлж байсныг тэмдэглэсэн гэжээ. Го.Аким.

⁸⁶ Рашидаддин Фазлуллах. Дурдсан бүтээл.834-835 дахь тал. Хасан /Газан/ хаан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч шүүгчдэд зориулж онцгой зарлиг гаргасан нь хрэд хэдэн шалтгаантайг үзнэ үү.

⁸⁷ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл. Нэгдүгээр боть. (1206-1910 он). Хууль зүйн үндэсний хүрээлэн, Шинжлэх ухааны академийн философи, социологи, эрх зүйн хүрээлэн, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн “Монголын төр, эрх зүйн түүхийн судалгааны төв”, “Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн судалгааны төвийн хамтран хэрэгжүүлсэн төсөл. Төслийн удирдагч Ж.Амарсанаа. УБ., 2010 он. 35 дахь тал.

заргач нарын баримталдаг гол зарчим байсан⁸⁸ нь эрх зүйн соёлын хувьд бид мөрдөн шалгах ажиллагаанд болон шүүн таслах ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хууль ёсны байх зарчмыг хэрэгжүүлэх анхдагч алхамыг дэлхий дахинд түгээжээ. Энэ нь Шихихутуг хуулийг дээдлэн, шадарга, энэрэнгүй зарчим баримталж, шүүн таслах үйл ажиллагаандаа өөрийн гэсэн арга маяг, дэг сургуулийн бий болгож, уг дэг сургуулиар Монгол болон харьяат бүх орны заргач нар ажиллаж байжээ⁸⁹ гэсэнтэй санал нэг байна.

Зүчийн улс⁹⁰, Цагаадайн улс⁹¹-ын хууль цаазын хувьд мөн их засаг хуулийг хэлбэрэлтгүй сахих, хууль зөрчигдсөдтэй хариуцлага тооцох нь өөр хоорондоо төстэй байсан тухай төр, хууль цаазын түүхийн эрдэмтэн, судлаачдын бүтээлд тэмдэглэгдсэн байна. Энэ тухай, их засаг хуульд заасны дагуу сэжигтнийг байцаах, шийтгэл оноох үүргийг яргуч буюу заргач нар гүйцэтгэнэ. Яргуч нар нь ихэвчлэн сурвалжит монгол ноёдоос бүрдэх бөгөөд төрийн чухал албыг гүйцэтгүүлдэг байв⁹². Мөн хуулийн дагуу мөрдөн шалгах, шийтгэх үйл явцыг яргу хийх буюу заргалах хэмээн нэрлэх бөгөөд төрийн өндөр албан тушаалтнуудыг Их засаг хуулиар шүүн шийтгэх боловч мусульман иргэд Их засагт хориглосон зүйлийг зөрчвөөс мөн л Их засаг хуулийн дагуу шүүдэг байв⁹³ гэж тэмдэглсэн байна.

Дүгнэлт

Монголчуудын эрх зүйн түүхэнд оруулсан нэгэн том хувь нэмэр бол Их засаг хуулийг хэрэглэх явцдаа шариатын ёсыг нэвтрүүлэх замаар эрх зүйн холимог тогтолцоог хэрэглэж⁹⁴ байсанд оршино. Өөрөөр хэлбэл, шашны эрх зүйн буюу тэр дундаа шариатын “маханд мах, ясанд яс” хэмээх хохирол нөхөн төлүүлэх зарчим нь Их засаг хуулийн холбогдох зүйлтэй холимог хэлбэрээр хэрэглэгдэж байсныг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай. Бидний үзэж байгаагаар хохирол тогтоох, тогтоосон хохирлын хэр хэмжээнд тохирсон шийтгэл хүлээлгэх үндэслэгээ нь тухайн хэргийн хор уршиг, хохирлын хэр хэмжээнээс шалтгаалж байсныг бататгаж, учруулсан хор уршиг, хохирлын хэмжээг тогтоох талаар тодорхой мөрдөн шалгах ажиллагаа явуулж нотлож байсан болохыг илэрхийлж байна.

Мөрдөн байцаалт /мөрдөн шалгах ажиллагаа/ хэмээх үгийг эрх зүйн бус эрдэмтэн судлаачид хэрэглэж буй нь бидний хувьд дэмжиж байна. Өөрөөр хэлбэл, эрх зүйн хэллэгт суралцаагүй нь амьдралд нийтлэг хэрэглэгддэг уг хууль зүйн томъёололыг хэрэглэх үндэс болжээ. Нэгэнт тогтсон хэллэг хэрэглэгдсэн нь мөрдөн байцаалтын агуулга, үзэл санааг анхаарч, цаашид хэрхэн мөрдөн мөшгөх томъёололтой харгуулан судлах, үзэл санааны хувьд шинээр авч үзэхийг түүхэн сурвалжуудаар няталбал зохино гэсэн бидний санаа буй билээ.

⁸⁸ Рашид-Ад-Дин. Судрын чуулга. I боть. I дэвтэр. (орчуулсан Ц.Сүрэнхорлоо). Уб., 1994 он. 61 дэх тал, Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар. Дурьдсан бүтээл. 63 дахь тал, Д.Анхбаяр. Ил хаант улс. Монголын эзэнт гүрний түүх. Тавдугаар боть. Уб., 2019 он. 174-180 дахь талд үзнэ үү.

⁸⁹ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар. Дурьдсан бүтээл. Мөн тэнд.

⁹⁰ Ж.Гэрэлбадрах, Б.Чинзориг, Д.Өлзийбаатар нар. Зүчийн улс. Монголын эзэнт гүрний түүх. Гутгаар боть. Уб., 2019 он. 196-206 дахь талд үзнэ үү.

⁹¹ Д.Анхбаяр, Р.Мөнхтулга нар. Цагаадайн улс. Монголын эзэнт гүрний түүх. Дөтгөөр боть. Уб., 2019 он. 121-133 дахь талд үзнэ үү.

⁹² Д.Анхбаяр, Р.Мөнхтулга нар. Дурьдсан бүтээл. 122 дахь тал.

⁹³ Плано Карпини. Монголчуудын түүх. Орчуулсан Л.Нямаа. Уб., 2006 он. 21, 45 дахь талд үзнэ үү, Д.Анхбаяр, Р.Мөнхтулга нар. Дурьдсан бүтээл. 123 дахь тал.

⁹⁴ Д.Анхбаяр, Р.Мөнхтулга нар. Дурьдсан бүтээл. 127 дахь тал. Ибн Баттутагийн тэмдэглэснээр, эмируудээс нэг нь сүү зарж байсан эмэгтэйдээс сүүг нь булааж уусан хэргийн талаар гомдол ирснийг хэрхэн шийдсэн болохыг үзнэ үү.

Монголын төр, эрх зүйн хийгээд түүхийн бүтээлүүдээс үзвэл эртний болон дундад үеийн эрх зүйн эх сурвалжид аливаа хэрэг, заргыг мөрдөх, шийтгэх, ял эдлүүлэх ажиллагаа хэрэгжиж байсан нь илэрхий байна.

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Д.Булган
Хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор
цагдаагийн дэд хурандаа

Г.Ариунгэрэл
Магистр, судлаач

Товч агуулга. Өнөөгийн нийгэмд хамгийн их эрсдэл учруулж байгаа зүйл бол автомашины осол бөгөөд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, хамгаалалтын бүс, малгай, аюулгүйн бүс хэрэглэхгүй байх, хурд хэтрүүлэх, гар утсаар ярих, тамхи асаах, хүүхэдтэйгээ зууралдах зэргээр анхаарал сарнихад жолоочийн хөдөлгөөн удаашрах, гэрэл дохио анхаарахгүй, эгнээ байр эзлэхдээ бусдыг анзаарахгүй байх, хажуу хоорондын зайг тохируулахгүй байх нь жолоочийн ур чадварт шууд нөлөөлж, зам тээврийн осол гардаг. Мөн зам тээврийн ослын шалтгаан нь замын нөхцөл байдал, тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтэл, жолоочийн буруугаас, орчны нөлөөлөл гэсэн зүйлүүдээс хамааралтай. Ийнхүү шалтгаан хүчин зүйлийг нь оновчтой тодорхойлсноор энэ төрлийн үзэгдэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг зөв тодорхойлох, зам тээврийн осол, хэргийн гаралтыг тогтоон барих, бууруулах арга хэмжээг төлөвлөн авах боломжтой болох юм.

Энэхүү сэдвийн хүрээнд нэгдүгээрт тээврийн цагдаагийн албаны урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нэгжийн зохион байгуулалтын бүтцийн өнөөгийн байдал, хоёрдугаарт хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээний өнөөгийн байдал, гуравдугаарт урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж буй алба хаагчдын дунд хэлэлцүүлэг хийж, өнөөгийн байдлыг тодорхойлж, үр дүнг тус тус судалж үзлээ.

Түлхүүр үг. Зам тээврийн осол, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил, тээврийн цагдаагийн алба, урьдчилан сэргийлэх хэлтэс.

Удиртгал

Цагдаагийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “цагдаагийн байгууллага нь нийтийн хэв журмыг хамгаалах чиг үүргийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан. Энэ чиг үүргийн хүрээнд тус хуулийн 11.1.3-т “замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах” талаар заасан. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн нэг чиглэл нь зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа юм.


Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн сүүлийн 5 жилийн нөхцөл байдлыг судлахад иргэдийн аюулгүй, амар тайван амьдралын баталгааг хангахын тулд урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэх, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байгаа нь харагдаж байна. Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг зөв тодорхойлж, хэрэгжилтийг амжилттай зохион явуулах нь өнөөгийн тулгамдаж буй асуудлын нэг юм. Тиймээс энэ асуудлыг шийдвэрлэхээр Тээврийн цагдаагийн албаны урьдчилан

сэргийлэх хэлтэс нь зам тээврийн болон төмөр замын аюултай бүс, иргэний агаарын тээврийн аюулгүйн зурваст үйлдэгдэх гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд төлөвлөн зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэгтэйгээр ажилладаг. Орон нутгийн авто замд зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн аймаг, орон нутгийн цагдаагийн байгууллагын замын цагдаагийн нэгжийн алба хаагчдтай хамтран зохион байгуулж байна.

Зам тээврийн осол 2016 онд 46712, 2017 онд 36591, 2018 онд 29474, 2019 онд 25302, 2020 онд 21768, 2021 онд 22482 тус тус бүртгэгдсэн бөгөөд энэ нь өмнөх оноос 3.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Орон нутагт үйлдэгдсэн зам тээврийн ослын 3122 буюу 95.9 хувь нь жолоочийн буруугаас, 115 буюу 3.5 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 18 буюу 0.6 хувь нь замын нөхцөлөөс шалтгаалж бүртгэгджээ. Зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг жолоочийн буруутай үйлдэл, явган зорчигчийн буруутай үйлдэл, замын нөхцөл байдал, техникийн гэмтлийн улмаас гарсан осол хэмээн бүлэглэн авч үзэж байна.

Харин зөрчлийн хувьд улсын хэмжээнд 2016 онд 1328560 зөрчил бүртгэгдсэн бол 2020 онд 2058347, 2021 онд 1921887 зөрчил бүртгэгдсэний 1489089 буюу 77.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн зөрчил өнгөрсөн оны үеийнхээс 136460 нэгж буюу 6.6%-иар буурсан. Үүнээс орон нутагт гарч байгаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийг графикаар авч үзвэл:

Зураг №01. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийн сүүлийн 5 жилийн үзүүлэлт



Графикаас харахад, 2016 онд нийслэлд 1080168 зөрчил бүртгэгдсэн бол 2021 онд 1489089 зөрчил бүртгэгдсэн нь 46 хувиар өссөн үзүүлэлт харагдаж байна. Харин 2020 оноос зөрчлийн үзүүлэлт буурсан нь ковид цар тахлын хорио цээрийн дэглэмтэй холбоотой буурсан байх магадлалтай юм.

Сүүлийн жилүүдэд зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх маш олон арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлсэн нь зөрчийн гаралтад нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй. Тухайлбал, “Дураараа биш дүрмээрээ”, “Яараад яахав дээ” зэрэг зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Эдгээр арга хэмжээ нь орон нутгийн иргэд, жолооч нарт хэр хүртээмжтэй, үр нөлөөлтэй байгааг судлах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Дээрх үндэслэлд тулгуурлан зам тээврийн осол, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, хэрэгжилтийг сайжруулах, оновчтой арга зүйд үндэслэн боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байсаар байна. Тиймээс зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажил, арга хэмжээний өнөөгийн байдал, хэрэгжүүлж буй зохион байгуулалтын бүтэц, алба

хаагчдын чиг үүрэг, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх замаар өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, цаашид сайжруулах арга замыг тодорхойлохоор энэхүү сэдвийг сонгон авч судаллаа.

Нэг.Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээний өнөөгийн байдал. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр дэлхий нийтийн өмнөө тавьсан зорилт, зарим улсын⁹⁵ туршлагаас үзвэл урьдчилан сэргийлэх ажлын үр дүн нь ослын гаралтын өсөлт, бууралтаас илүү ослын шалтгаанаар нас барсан, гэмтсэн хүний тоог бууруулсан байх нь хамгийн гол үзүүлэлт болж байна. Түүнчлэн зам тээврийн осол, зөрчлийг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нь зөвхөн цагдаагийн байгууллагын үүрэг биш бөгөөд авто тээвэр, эрүүл мэнд, хот төлөвлөлт, орон нутгийн захиргаа, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн өргөн оролцоог хангасан хамтын үйл ажиллагааны үр дүн болохыг Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейн 2010 оны 64/255 дугаар тогтоолоор баталсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөр”-т онцолжээ.

“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.1-т “гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн⁹⁶” гэж тодорхойлоод гэмт хэрэг, зөрчлөөс (зам тээврийн осол, зөрчил) урьдчилан сэргийлэх ажлын зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалт, байгууллага, олон нийтийн оролцоог тус тус тодорхойлж, нийгэмд аюултай үзэгдэл болохын хувьд түүний хор аюулаас иргэдийг хамгаалах хууль зүйн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлсэн байна. Мөн хуулийн 6 дугаар зүйлд “гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэл”-ийг ерөнхий, тсгай, нэг бүрчилсэн, соён гэгээрүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэхээр тодорхойлж, зохицуулсан байна.

Зам тээврийн осол, зөрчил гарахад “нэг хүний хүчин зүйлийн нөлөө” онцгой үүрэг гүйцэтгэдэг тул жолоочийн болон тээврийн хэрэгслийн тоон үзүүлэлт нэмэгдэх тусам зам тээврийн осол, зөрчил нэмэгдэх магадлал нэмэгдэнэ. Тухайлбал, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил, хурд хэтрүүлэх, суудлын бүс хэрэглэхгүй замын хөдөлгөөнд оролцох гэх мэт жолоочийн буруутай үйлдлээс үүдэлтэй зам тээврийн осол гарч, түүнээс учрах хохирол нэмэгдсээр байна.

Зам тээврийн осол, зөрчил гарах шалтгааны 95-аас дээш хувь нь жолоочийн буруутай үйлдэл гэж Тээврийн цагдаагийн албанаас эрхлэн гаргаж буй зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэлд дурдсан байна. Энэхүү шалтгааны дийлэнх хувийг согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, анхаарал болгоомжгүй жолоодох, хурд хэтрүүлэх, зогсоох арга хэмжээ авахгүй байх нь зам тээврийн осол гарахад нөлөөлжээ⁹⁷. Эндээс харахад зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ нь шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэгдэж үү, үр нөлөөтэй үзүүлж байна уу гэсэн асуулт гарч ирж байна. Тиймээс одоогийн хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны өнөөгийн байдал, хэрэгжилтийн талаар судлан авч үзье.

⁹⁵ Vision Zero (road traffic safety project) https://en.wikipedia.org/wiki/Vision_Zero

⁹⁶ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. Төрийн мэдээлэл 2019 он, №42.

⁹⁷ Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик, үзүүлэлтийн эмхэтгэл. УБ., 2018, 2019, 2020, 2021 оны эмхэтгэл.

Монгол Улсад 1949 оноос Улсын авто техникийн шалган байцаах газрын дотоод орон тоонд “Ухуулах ажлын байцаагч”-ийн 1 орон тоотой анхны үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд нь 1960.12 сард иргэд, олон нийтэд урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн тайлангаа танилцуулж, санамж бүхий өврийн дэвтэр 10.000 ширхэг, замын хөдөлгөөний дүрэм 100.000 ширхэг, явган зорчигч ба дугуйтай хүнд зориулсан дүрмийн брошюр 50.000 ширхэг, авто хөсгийн жолооч нар ба явган зорчигчдод зориулсан санамж 25.000 ширхэг, хөдөлгөөний дүрмийн зөрчилд аваарын байдлыг харуулсан 3 төрлийн 25.000-30.000 ширхэг, зурагт самбар 50-200 хувь хэвлэн олон нийтэд тарааж байв. Үүнээс хойш 2000 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн №354 дүгээр тушаалаар Замын цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх хэсэг, 2009 онд Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Олон нийттэй харилцах тасаг, 2012 оны 12 дугаар сарын 28-наас Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Шинжилгээ үнэлгээ, захиргааны газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, 2014 оны 06 дугаар сард Цагдаагийн ерөнхий газрын №71 тоот тушаалаар Нийслэлийн Замын цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/159 дүгээр тушаалаар Тээврийн цагдаагийн албыг байгуулсантай холбогдуулан албаны бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр Захиргааны удирдлагын газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс байгуулагдаж байв. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар Тээврийн цагдаагийн албаны бүтэц, орон тоо, цол цалингийн зэрэглэлийг шинэчлэн баталж, Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтэс нэртэйгээр тус тус батлагдаж үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлээ.

Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх хэлтэс нь хэлтсийн дарга 1, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах зохицуулагч 2, Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн 2, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан зохицуулагч 2, цахим хуудас хариуцсан мэргэжилтэн 1, зураглаач цагдаа 1, нийт 9 орон тоотойгоор ажиллаж байна. Энэхүү хэлтэс нь зам тээврийн болон төмөр замын аюултай бүс, иргэний агаарын тээврийн аюулгүйн зурваст үйлдэгдэх гэмт хэрэг, осол, зөрчлийн шалтгааныг судлах, зам тээврийн осол, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажил, арга хэмжээг харьяа нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг хамруулан зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулан, үр дүнг тооцон ажилладаг.

Хэрэгжүүлж буй урьдчилан сэргийлэх арга хэмжээг тоймлон авч үзвэл⁹⁸:

1. Өнөөдрийн байдлаар зам тээврийн осол, хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын сахилга, батыг өндөржүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ая тухтай аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор олон нийтийг хамарсан аян, арга хэмжээг тогтмол зохион байгуулж ирсэн. Тухайлбал, “Дураараа биш дүрмээрээ”, “Яараад яахав дээ”, “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл”, “Ирээдүйгээ хамгаалъя” уриатай арга хэмжээнүүдийг үе шаттай зохион байгуулснаар зам тээврийн осол 12.8, гэмт хэрэг 45.2, гэмтсэн 32.8 хувиар тус тус бууруулсан гэж тус хэлтсийн тайланд дурдагджээ.⁹⁹ Мөн явган зорчигчийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх, явган хүний гарцаар гарах үеийн аюулгүй байдлыг хангах зорилгоор “1 хором хүлээ”, “Гарцаар гарцгаая”, “Бяцхан

⁹⁸ Тээврийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх 2020, 2021 оны үйл ажиллагааны тайлан.

⁹⁹ ТЦА-ны Урьдчилан сэргийлэх хэлтсийн 2021 оны үйл ажиллагааны тайлан.

зорчигч”, Хүүхдэд ээлтэй жолооч“, “Шар дарцаг” зэрэг зорилтот арга хэмжээг зохион байгуулжээ.

2. Хэвлэл мэдээллийн байгууллага, мэдээллийн олон урсгалаар дамжуулан иргэд олон нийтэд нөлөөлөх мэдээлэл сурталчилгааны ажил тул энэ чиглэлд түлхүү үйл ажиллагааг чиглүүлж ирсэн. Энэ ажлын хүрээнд улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осол, хэргийн товч мэдээлэл, шалтгаан, нөхцөл, хор уршгийг таниулах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор долоо хоног, амралтын өдрүүдийн нөхцөл байдлын мэдээ, сэрэмжлүүлэг зэргийг бэлтгэн өргөн нэвтрүүлгийн 28 телевизэд 124 төрлийн мэдээллийг 558 удаа, богино долгионы 4 Fm радиод 70 төрлийн мэдээллийг 242 удаа, албаны болон бусад цахим 56 сайтад 62 төрлийн мэдээллийг 310 удаа, Сонинд 3 төрлийн мэдээллийг 3 удаа тус тус өгч ажиллажээ.

3. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, сургалт зохион байгуулах зэрэг олон төрлийн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, зөвлөмж өгч ажиллаж байна.

4. Цагдаагийн ерөнхий газар болон Тээврийн цагдаагийн албанаас хурдаас шалтгаалсан ослын бууруулах зорилгоор хатуу хучилттай улсын чанартай авто замд байрлах цагдаагийн байнгын хяналтын дундаж хурдыг хэмжих хяналтын камерыг 2019 оны 10 дугаар сард байрлуулан ашиглаж байна.

5. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын 2020 оны 102 тогтоол, Ерөнхий сайдын 2020 оны 99 дүгээр захирамж, Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2020 оны 26/16 зөвлөмж гэх мэт нийт 13 хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт үр дүн, хэрэгжилтийг хариуцан ажиллажээ.

Дээрх арга хэмжээнүүдийг харахад зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч энэ нь зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэсэн, оновчтой, үр дүнтэй байгаа эсэх нь эргэлзээтэй, цаашид энэ талаар судалгаа шинжилгээ хийж, бодиттой үр дүнтэй арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагатай гэж судлаачийн хувьд үзэж байна.

Цагдаагийн байгууллагын урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж буй алба хаагчдаас “зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн байдал”-ыг тодорхойлохоор фокус ярилцлага хийлээ. Энэхүү ярилцлагад Цагдаагийн Ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн алба хаагчид, Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн сургагч багш нар болон бусад төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий хүмүүс хамрагдсан. Энд “зам тээврийн осол, зөрчлийн өнөөгийн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад анхаарах асуудал”, “байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, PR хийх”, “зам тээврийн осолд өртсөн иргэнд үзүүлэх эмнэлгийн анхны тусламж” зэрэг сэдвээр хэлэлцэж, алба хаагчдад хариуцсан нутаг дэвсгэртээ зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах, хамтын ажиллагааг сайжруулах бодлого чиглэлийг тодорхойлох, хил залгаа, оролцогч аймаг, дүүргийнхээ хэрэгжүүлсэн ажлын туршлагыг судалж, сайн туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр харилцан санал бодлоо солилцсон.

Хэлэлцүүлэгт оролцсон алба хаагчдаас дараах саналуудыг гаргасан. Үүнд:

- Албан тушаалын тодорхойлолтыг судалж, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тусгах,

- Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагчдын ажил дүгнэх шалгуур үзүүлэлтэд зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлыг нэмэх,
- “Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагч”-ийн орон тоог албан тушаалын тодорхойлтын чиг үүрэгт тусгуулах
- Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагчдын оролцоог нэмэгдүүлэх;
- Орон нутгийн замд үйлдэгдэж буй зам тээврийн осол, зөрчил, гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хэрэгжүүлэх арга хэмжээг авдаггүй;
- Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг судалгаа, дүн шинжилгээгүйгээр зохион байгуулдаг, гарсан үр дүнг үнэлж тооцдоггүй зэргийг сайжруулах талаар тус тус санал, хүсэлтийг ирүүлсэн.

Хоёр. Зам тээврийн осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг бууруулахад чиглэсэн ажлын үр нөлөөг дээшлүүлэх ажлын хүрээнд. Монгол Улсад зам тээврийн осол гарахад нөлөөлж буй хүчин зүйл¹⁰⁰-д замын хөдөлгөөнд оролцогчдын эрх үүрэг, эрх зүйн ухамсар муу, жолоочийн соёл, ур чадвар дутмаг, жолооч бэлтгэх сургалтын багш, сургалтын хөтөлбөр хэрэгжилт хангалтгүй байгаа нь нөлөөлж байна. Үүнд хяналт тавих, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой зохицуулалтыг нэмж тусгах. Тухайлбал, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд “замын хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх бүх нийтийн тасралтгүй боловсрол олгох” талаар нарийвчлан зааж өгөх;

Монгол Улсад одоогийн байдлаар 367 аж ахуйн нэгж байгууллага жолооч бэлтгэх сургалт явуулж байгаагаас нийслэлд 180 орчим нь үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр жолооны курсийн сургалтад дүрмийн мэдлэг, хотын болон талбайн жолоодлогоор мэдлэг, ур чадварыг олгож байгаа нь өнөөгийн шаардлагыг хангахгүй, хоцрогдсон хөтөлбөр байна.

Жолооч бэлтгэх сургалтын чанарыг сайжруулахад боловсролын онолын үндэслэлтэй цогц чадамж, мэдлэг, ур чадвар, хандлагын суралцахуйн үр дүнг тодорхойлж, түүнд хүрэх сургалтын арга замуудыг боловсруулах нь зүйтэй юм.

Жолооны “В” ангиллын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх модульд суурилсан сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийлээ. Энэхүү хөтөлбөрөөр чадамжийн нэр¹⁰¹, сургалтын төрөл¹⁰², сургалтын цаг¹⁰³, жолоодлогын дадлагын тусгай талбай, сургалтын хэлбэр зэргийг тус тус тусгажээ. Эндээс харахад тус сургалтын хөтөлбөр нь мэдлэг, чадвар олгож байгаа боловч хандлага төлөвшүүлэхээр тусгаагүй байна.

Онолын мэдлэгийн хүрээнд замын хөдөлгөөний дүрэм, тээврийн хэрэгслийг аюулгүй жолоодох онол зүй, техникийн анхны мэдэгдэхүүн, авто техникийн ашиглалт, хууль тогтоомж, эмнэлгийн анхны тусламж зэрэг хичээлийн агуулгыг тусгажээ. Дээрх хөтөлбөрийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийснээр дараах агуулгыг жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөрт тусгах талаар санал болгож байна. Үүнд:

¹⁰⁰ Судалгаагаар 95-аас дээш хувь нь жолоочийн буруутай үйлдэл байгаа талаар бид өмнө дурдсан. Тиймээс жолоочид чиглэсэн арга хэмжээг бодиттой төлөвлөж, хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

¹⁰¹ “Жолоочоос гадна наймаас илүүгүй хүний суудалтай, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин (бүх жин нь 750 кг-аас ихгүй чиргүүлтэй)-ы жолооч” гэж тодорхойлсон.

¹⁰² Мэдлэг, дадлага олгох.

¹⁰³ Онол 76 цаг, дадлага 32 цаг.

Хүснэгт №1. Жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөрт тусгах санал

	Хичээлийн хөтөлбөрийн нэр	Цаг, багтаамж	Хүрэх үр дүн
1	Дүрмийн мэдлэг олгох хөтөлбөр;	60 цаг	Жолоочийн ур чадвар, соёл, сахилга бат дээшилж, жолоочоос шалтгаалах осол буурна.
2	Жолоодох ур чадвар олгох хичээлийн хөтөлбөр;	32 цаг	
3	Жолоочийн соёл хандлагыг төлөвшүүлэх хичээлийн хөтөлбөр;	10 цаг	
4	Жолоочийн эрх зүйн мэдлэг олгох хичээлийн хөтөлбөр	10 цаг	
5	Зам тээврийн осолд өртөгсдөд үзүүлэх анхны тусламж	10 цаг	

Дээрх хичээлүүдийг судалснаар жолооч нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт, дүрмийн мэдлэг эзэмшиж, жолоодох ур чадвартай, хөдөлгөөний соёлтой байх хандлага төлөвшсөн байхаар төлөвлөгдсөн байна. Ийнхүү замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бүх нийтийн боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага, агуулгыг сайжруулснаар зам тээврийн осол, зөрчил буурах нөхцөл бүрдэнэ гэж судлаачийн хувьд үзэж байна.

Мөн зам тээврийн осол, зөрчлийн шалтгаан нөхцөлд “замын нөхцөл” хамгийн бага буюу нийт осолд 0.2 хувийг эзэлж байгаа нь эргэлзээтэй байна. Учир нь Монгол Улсын Авто замын тухай хууль¹⁰⁴-д заасны дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр дэх үндэсний авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замаас бүрдэнэ. Монгол Улс 1990-ээд онд ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжихдээ Монгол Улс үйл ажиллагааны үр ашгийн түвшин доогуур, удирдлага нь шууд удирдан өргөжүүлдэг тун жижиг авто замын сүлжээг хүлээн авсан.¹⁰⁵ Үндэсний авто замын сүлжээний нийт урт 2019 оны жилийн эцсээр 111916,7 км байгаагийн 100323,28 км нь буюу 89,6% нь ердийн хөрсөн, 11593,42 км буюу 10,4% нь сайжруулсан зам байна. Нийт сайжруулсан замын 9781 км буюу 84,4%-ийг хатуу хучилттай, 1207,9 км буюу 10,4%-ийг хайрган хучилттай, 604,9 км буюу 5,2%-ийг сайжруулсан хөрсөн зам эзэлж байна. Цаашид Монгол Улсын Засгийн газар тус салбарыг хөгжүүлэх, замын сүлжээг өргөтгөх стратеги боловсруулан мөрдөж, замын барилгын аж үйлдвэрлэл, үйл ажиллагааг сайжруулах хэрэгцээ шаардлага байгаа нь бидний тулгамдсан асуудал болсоор байна.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хууль”-ийн 19.2-т “Зам, замын байгууламжийг төлөвлөх, барих, өргөтгөх, засварлах, арчлан хамгаалах ажил нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хууль, техникийн норм, дүрэм, стандартад нийцэж байгаа эсэхэд тухайн холбогдох хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина” гэж заасан. Эндээс харахад авто зам, замын байгууламжийг барих, арчлах, засварлах, хамгаалах, ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг төрийн байгууллага, бүх шатны Засаг дарга, холбогдох албан тушаалтан эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлж байна. Гэхдээ замын байгууламжийг барих, арчлах, засварлахад холбогдох байгууллагууд хяналт тавьж байгаа боловч хэрхэн хяналт тавих, засаж сайжруулах шаардлагатай бол хэрхэн ажиллах талаар тусгаагүй буюу хэрэгжүүлэх

¹⁰⁴ “Авто замын тухай хууль”¹⁰⁴-ийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “Монгол Улсын үндэсний авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутгийн чанартай болон тусгай зориулалтын авто замаас бүрдэнэ” гэж заасан.

¹⁰⁵ Монгол Улс Авто замын салбар -2016. Азийн хөгжлийн банк. УБ., 2011.

механизмыг тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн өндөр чадвар бүхий туршлагатай зам тээврийн ослын шинжээч болон замын хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлгөөн зохион байгуулалтын инженерүүдээс бүрдсэн баг замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх талаар тусгаж өгөх нь зүйтэй юм.

Мөн энэхүү аудитын багийн гишүүд нь зам тээврийн ослын шинжээч, замын хөдөлгөөний аюулгүй байдал, хөдөлгөөн зохион байгуулалтын инженерүүд байх бөгөөд авто замын төлөвлөлт болон хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр мэргэжил эзэмшиж, аудитын чиглэлээр суралцаж, мэргэшсэн, энэ чиглэлээр туршлагатай аж ахуйн нэгж байгууллагын зөвшөөрөлтэй хуулийн этгээд байх шаардлагатай юм.

Дүгнэлт

Монгол Улсад зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн зохион байгуулалтын бүтэц 1949 оноос бий болж, өнөөг хүртэл үйл ажиллагаа нь тогтмол хэрэгжсээр байна. Гэхдээ зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтсийн үйл ажиллагаа нь соён гэгээрүүлэх, аян, хэсэгчилсэн арга хэмжээ хэрэгжүүлэх, судалгаа шинжилгээ хийх, хамтын ажиллагааны хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Дээрх хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг харахад замын дэд бүтцийг судалж, замын нөхцөл байдлаас үүдэлтэй шалтгаан нөхцөлийг буурахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлдэггүй, жолоочоос үүдэлтэй зам тээврийн осол, зөрчлийн шалтгаан нөхцөлд чиглэсэн оновчтой арга хэмжээг авч төлөвлөдөггүй болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, замын хөдөлгөөний аюулгүй байдал, шуурхай байх үндсэн нөхцөлийн нэг нь замын дэд бүтэц, жолоочийн хариуцлага байдаг.

Замын эвдрэл, гэмтэл нь хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж, зам тээврийн осол, хэрэг гарах шалтгаан нөхцөлүүдийн нэг болдог байна. Өнөөг хүртэл замын эвдрэл гэмтэл, онгорхой нүх, овоолсон шороо, зузаан мөстсөн замын хэсэг, замын бусад хангалтгүй нөхцөлийг тойрох гэсэн автомашины жолооч хөдөлгөөний чиглэлээ гэнэт өөрчлөх, тойрч эсрэг урсгалд орсноос гарсан тохиолдлыг осол гарсан актад тусгахгүй, ихэнх тохиолдолд бурууг жолооч, бусад хөдөлгөөнд оролцогчдод хариуцуулж байна. Манай орны замын байхад замын нөхцөл гэсэн хүснэгтэд байгаа тоон үзүүлэлт маш бага байгаа нь шалтгаан нөхцөлийг зөв тогтоохгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Замын байгууламж хариуцсан албадад хариуцлага хүлээлгэвэл зам, замын нөхцөл чанарын өндөр түвшинд хүрэх нэг механизм болно гэсэн үг юм. Замын хөдөлгөөнд оролцогчдод сайхан зам, аюулгүй зам хэрэгтэй байдаг учир замын байгууламж хариуцсан албад, гадна талбай, зогсоолын талбай зэрэг нийтэд үйлчлэх эзэмшлийн зам, талбайгаа цэвэрлээгүйгээс уг байгууллагын эзэмшлийн газарт замын нөхцөлөөс үүдэлтэй осолд аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага хүлээлгэвэл зам, замын нөхцөл нь чанарын өндөр түвшинд хүрэх нэг механизм болно гэж үзэж байна.

Санал

- Жолооч бэлтгэх сургалтын чанарыг тодорхойлох судалгаа хийж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэх, сайжруулах;
- Зам тээврийн ослыг бүх талаас нь шинжлэн шалгах, судлах хараат бус албыг байгуулан, зам тээврийн осол ихээр гардаг, гарах өндөр эрсдэлтэй замын хэсэгт аюултай байдлын үнэлгээ, аудит хийлгэн, зам тээврийн ослын шалтгаан нөхцөлийг тогтоолгон, үр дагаврыг бууруулах бодлого чиглэл боловсруулан, үр дүнтэй арга авч хэрэгжүүлэх;

- Жолоочоос үүдэлтэй зам тээврийн осол, зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэсэн “хөтөлбөр, төлөвлөгөө” боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх.
- Улсын чанартай орон нутгийн автозамд байрлах цагдаагийн 12 хяналтын цэгт алба хаагчдыг ажиллуулах.

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ УРАМШУУЛЖ БУЙ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ¹⁰⁶

Ц.Чингүнжав

ЦЕГ-ын Хэвлэл, мэдээллийн төвийн мэргэжилтэн,
цагдаагийн ахлах дэслэгч

Товч агуулга. Төрийн жинхэнэ алба буюу төрийн тусгай албаны албан хаагчид нь тангараг өргөж, төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг онцлогтой бөгөөд тэдэнд ёс зүйтэй, шударга, мэргэшсэн, мэргэжлийн өндөр ур чадвартай байх зэрэг шаардлагууд зүй ёсоор тавигддаг. Тэгвэл тухайн төрийн тусгай албан хаагчид тэр дундаа цагдаагийн алба хаагчдын ажлын гүйцэтгэл, бүтээмж, үр дүнд урамшуулал хэрхэн нөлөөлж байгааг буюу ажлын гүйцэтгэл нь урамшууллын цаад нөхцөл болох хувь хүний хэрэгцээ (хэрэгцээ хангагдсан байдал)-нээс хэрхэн хамаарч байгааг судалж, урамшууллын систем оновчтой, алба хаагчдын хэрэгцээ, хүсэлд нийцэж чадаж байна уу? гэдэг асуултад уг илтгэл хариулт өгөхийг зорьсон болно. Түүнчлэн, уг өгүүллийн хүрээнд хийгдсэн судалгаа нь тоон болон чанарын судалгаанд суурилсан ба анхдагч, хоёрдогч эх сурвалжуудыг тус тус ашигласан.

Цагдаагийн алба хаагчдын тухайд хувийн эрх ашгийг нэгдүгээрт тавихгүй байх нь хамгаас чухал ч бид алба хаагчдынхаа нийгмийн асуудал гэж ерөнхийлөн ярихаас илүүтэй хувь хүний хэрэгцээг нь тодорхой түвшинд хангадаг байх, бодит урамшууллыг олгодог байх чиглэлд байгууллага, салбар, улсын хэмжээнд анхаарах ёстойг уг илтгэлийн хүрээнд хийсэн судалгааны үр дүн харуулсан.

Цагдаагийн байгууллагаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж буй алба хаагчдын мэдээлэл нь нууц хэдий ч дотоод нээлттэй мэдээллээс харвал ажлын ачаалал, удирдлагын арга барил, цалин, санхүүгийн нөхцөл байдал зэрэг олон талт хүчин зүйлээс шалтгаалан алба хаагчид албан тушаалаасаа өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх тоо багагүй байна.

Дээрх асуудлаас гадна цагдаагийн алба хаагчдыг хувийн хэрэгцээгээ хангах замаар хууль бус, дүрмийн бус зөрчил гаргаж, иргэд олон нийттэй харилцдаг гэсэн нийгмийн дундах ил далд, яриа, ойлголт байдаг. Тэгвэл үнэхээр ажлын гүйцэтгэл нь урамшуулал, урамшууллын систем түүний суурь шалтгаан болсон хувь хүний хэрэгцээнээс хамаарч байгаа эсэх асуудлыг судлан тодорхойлж, хамаарлыг шинжилсэн.

Түлхүүр үг: Төрийн тусгай алба, цагдаагийн алба хаагч, хэрэгцээ, идэвхжүүлэлт, ажлын гүйцэтгэл, үр дүн

НЭГ. УДИРТГАЛ

Аливаа байгууллагын ажилчдыг идэвхжүүлэх, урамшуулах нь ажлын гүйцэтгэлийг сайжруулах, үр дүнтэй ажиллуулах, тухайн ажил албан тушаалдаа тогтвор суурьшилтай ажиллах чухал хөшүүрэг болдог. Энэхүү идэвхжүүлэлт, урамшуулал нь тухайн хүний хэрэгцээг хангахад чиглэгдсэнээрээ илүү үр дүнтэй байдаг тухай онолын эх сурвалжуудад дурдсан байдаг. Тухайлбал идэвхжүүлэлт

¹⁰⁶ “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйл, шалтгаан нөхцөл, түүнийг арилгахад анхаарах асуудал-2022” сэдэвт шилдэг илтгэлийн уралдаанд тэргүүн байрт шалгарсан илтгэл

буюу “мотиваци”¹⁰⁷ гэдэг бол өөрийн болон байгууллагын нэгдмэл зорилгод хүрэхийн тулд өөрийгөө болон бусдыг өдөөн түлхэх үйл ажиллагаа юм.”¹⁰⁸

Хүн зорилгодоо хүрэх замаар хэрэгцээгээ хангаж, дараагийн шинэ хэрэгцээгээ илрүүлэн цаашид хүрэх зорилгоо тодорхойлох маягаар тасралтгүй орчилд оршин байдаг. Тодруулбал хүмүүсийн тодорхой үйл хөдлөл, ажиллагааны өдөөн түлхэгч нь хэрэгцээ байдаг онцлогтой. Гагцхүү цагдаагийн алба хаагчдын үйл хөдлөл, ажлын гүйцэтгэл хэрэгцээнээс хамаарч байгаа эсэх нь чухал судлагдахуун болж байна.

Тодруулбал цагдаагийн алба хаагчдыг бодитой идэвхжүүлж, урамшуулж байж бид илүү гүйцэтгэл, өндөр бүтээмж, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх учиртай. Тэрхүү урамшуулал нь тухайн хүний хүсэж байсан, бодитой хэрэгцээг нь хангахуйц байж чадсанаар урамшуулал алба хаагчдыг идэвхжүүлж чадна. Харин тухайн алба хаагчид хэрэгцээгүй, шаардлагагүй урамшууллыг амлаж, олгож байвал урамшуулаагүйтэй адил үр дүнд хүрнэ. Тиймээс өнөөдрийн байгаа урамшууллын систем нь бодитой байж чадаж байгаа эсэх, гадаад орны туршлагатай нийцэж байгаа эсэх, алба хаагчид ажлын гүйцэтгэлийг хэрхэн үнэлээсэй гэж боддог вэ? зэрэг асуултад хариулт олох зорилгоор тодорхой судалгааг хийж гүйцэтгэсэн.

Уг судалгааны үр дүн нь бодитой эх сурвалжид үндэслэсэн ба уг илтгэлийн үндсэн хэсэгт судалгааны үр дүнг оруулж өгсөн.

Энэхүү судалгааны ажил нь менежмент, сэтгэл судлалын шинжлэх ухаан болон хүний нөөцийн удирдлага, гүйцэтгэлийн удирдлага, хууль эрх зүй зэрэг сэдвүүдийн огтлолцол дээр бичигдсэн болно.

ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ БУЮУ СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

2.1. Цагдаагийн алба хаагчийг оновчтой урамшуулах асуудал яагаад чухал вэ?

Хувь хүн, баг, бүлгийг идэвхжүүлэх, урамшуулах зорилготой шагнал нь амжилтад тохирсон байх, эсвэл мөнгөн болон мөнгөн бус хэлбэрийн урамшуулал байх зэргээс шалтгаалан үр дүн өөр байх нь бий. Иймд санал болгож буй шагнал, урамшуулал нь ажлын төрлөөр, албан ёсны хөдөлмөрийн гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөө, хууль тогтоомж, холбогдох дүрэм, журамд туссан тодорхой хүрээнд сонголт хийх боломжтой, удирдлагын зохих түвшинд хэрэгжүүлэхээр байх нь оновчтойг дараах (Хүснэгт 1) харуулж байна. Түүнчлэн сайн гүйцэтгэлийг урамшуулах үндэслэл нь “Зөв зохистой дэмжлэг үзүүлэх замаар тасралтгүй үргэлжлүүлэн сайжруулахад урам өгөх, хүний нөөцийг татах, тогтвор суурьшилтай ажиллуулах” зэрэгт чиглэсэн байдаг.

Хүснэгт 1. Урамшууллын хэлбэрүүд

УРАМШУУЛАЛ			
Материаллаг		Материаллаг бус	
Мөнгөн:	Цалин, шагнал гэх мэт.	Нийгмийн:	Нэр хүнд олох, өсөх боломж
Мөнгөн бус:	Амралтын урилга, эмчилгээ, тээврийн хөлс, цол хэргэм хүртэх гэх мэт.	Сэтгэл санааны:	Найз нөхөд, ойр дотны хүмүүсээрээ хүндлүүлэх
		Бүтээлийн:	Хүн өөрийгөө танин мэдэх

¹⁰⁷ Мотиваци. гэх үгийг сэтгэл судлалын шинжлэх ухаанд “сэдэлжүүлэлт”, менежментийн шинжлэх ухаанд “идэвхжүүлэлт” хэмээн ашиглаж байна. Уг судалгааны ажилд мотиваци гэх үгийг “идэвхжүүлэлт” гэдэг утгаар хэрэглэнэ.

¹⁰⁸ Удирдлагын академи. (2017). *Менежмент*. Улаанбаатар

Тайлбар: Онолын үүднээс авч үзвэл урамшууллыг материаллаг, материаллаг бус гэж 2 ангилдаг ба материаллаг урамшуулалд мөнгөн, мөнгөн бус урамшуулал багтдаг бол материаллаг бус урамшуулалд нийгмийн, сэтгэл санааны, бүтээлийн урамшууллууд багтдаг байна.

Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академиас хийсэн болон төрийн албан хаагчдын гүйцэтгэл, урамшууллыг судалсан судлаачдын хийсэн судалгааны үр дүнгүүдийг харвал “сайн” эсвэл “хангалтгүй” гүйцэтгэлийг удирдахын тулд оновчтой шийдвэр хамгаас чухал бөгөөд үүнийг өмнөх туршлага, байгаа нөөцдөө үндэслэн хийхээс гадна алба хаагч, хамт олны **сэтгэл ханамж, хүлээлт, хэрэгцээнд** тулгуурлан хийх нь илүү оновчтой гэдэг нь харагдаж байна.

Байгууллага нь үйл ажиллагаагаа үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд зорилго, зорилтуудаа оновчтой тодорхойлон төлөвлөж, түүний хэрэгжилт, биелэлтэд хяналт тавих, эцсийн үр дүнг нь үнэлэх замаар гүйцэтгэлийг оновчтой удирдахыг эрмэлздэг.

Алба хаагчдын сэтгэл ханамж, тэдгээрийн юу хүсэж буйг мэдсэнээр байгууллага гүйцэтгэлийг удирдахад илүү хялбар болох нь тодорхой асуудал бөгөөд гагцхүү алба хаагчид юу хүсэж, хүлээж байгааг тодорхойлох нь чухал юм. Өөрөөр хэлбэл гүйцэтгэлийг үнэлсэн бол үнэлгээний мөрөөр авах арга хэмжээгээ тодорхойлохдоо үүнд шинжлэх ухаанчаар хандах хэрэгтэй юм.

Шинжлэх ухаанчаар хандана гэдэг нь Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоол буюу “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, холбогдох код журамд заасныг үндэслэл болгон алба хаагчийг урамшуулахдаа тодорхой түвшинд тухайн алба хаагчид тохирох, үр дүнтэй, үнэхээр идэвхжүүлж чадах урамшууллыг ашигладаг, хэрэглэдэг байх явдал юм.

Зураг 1. Байгууллагын системийн зураглал



Тайлбар: ГАРЦ-д тулгуурлан ХУВИРГАЛТ хэсгийн дотоод орчинд онцгой анхаарах хэрэгтэй нь уг системээс харагдана. Төрийн байгууллагын тухайд алба хаагчдын сургалт хөгжил, нийгмийн хангамж, идэвхжүүлэлтийг үр дүнтэй зохион байгуулж, сайжруулалтыг тогтмол хийснээр ГАРЦ-ыг сайжруулах боломжтой.

Удирдлагын академийн багш, доктор Ц.Дэлгэржаргал нь “Төрийн албан хаагчдын сэдэл ба шинэчлэгч зан үйлийн харилцан нөлөөлөл” сэдэвт судалгааг хийсэн ба сэдэл их төрөх тусам шинэчлэгч зан үйл ихэсдэг болохыг судалгааны үр дүн харуулсан байна. Түүнчлэн төрийн албан хаагчийн сэдлийг бүрэлдүүлэгч хүчин зүйл дотроос **нийтийн төлөө сайн дураараа өөрийгөө зориулна** гэсэн сэтгэл хүчтэй бол шинэчлэгч зан үйл ч ихэсдэг гэсэн үр дүн гарчээ. Өөрөөр хэлбэл төрийн алба хаагчид нийтийн төлөө сайн дураараа өөрийгөө зориулна гэх хандлага, өргөсөн тангарагтаа үндэслэн илүү бүтээлчээр ажилладаг гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Судлаач Б.Одгэрэлийн 2015 онд “Төрийн албан хаагчийн ажлын үр дүнд урамшууллын үзүүлж буй нөлөөлөл” сэдэвт судалгааны ажил нь төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлд урамшуулал, түүний хэлбэрүүд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлон гаргаж иржээ. Уг судалгааны үр дүнгээс харвал төрийн албанд хамгийн сайн хэрэглэдэг урамшуулал нь материаллаг мөнгөн урамшуулал болох үр дүнгийн урамшуулал бөгөөд бусад материаллаг болон материаллаг бус урамшууллыг хангалтгүй түвшинд хэрэглэдэг гэсэн үр дүн гарчээ. “Төрийн албан хаагчид байгууллагын урамшууллын өнөөгийн байдалд бүхэлд нь дунджаас доогуур үнэлгээ өгсөн ба сэтгэл ханамжийн түвшин хангалтгүй байгаа нь харагдаж байна.” гэжээ.

2.2. Эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Төрийн албаны тухай хууль 2017 онд шинэчлэн батлагдсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэн. Тус хуулийн 6 дугаар хэсэгт “Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, нийгмийн баталгаа”-ны тухай зохицуулалт тусгагдсан.

Төрийн албаны тухай хуулийн 55.2-т “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, тэдгээртэй холбогдуулан төрийн албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, урамшуулал олгох, хариуцлага хүлээлгэх журмыг Засгийн газар батална.” гэж заасан бөгөөд уг зохицуулалтын дагуу өнөөдрийн байдлаар Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” үйлчилж байна. Мөн хуулийн 55.3-т зааснаар “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүний дагуу төрийн байгууллагууд хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Төрийн албаны тухай хуулийн 17-р бүлгийн 61 дүгээр зүйлд “Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа”-г, 18-р бүлгийн 62 дугаар зүйлд “Төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгаа”-г тус тус хуульчилж өгсөн.

Төрийн албан хаагч нь дараах нийтлэг баталгаагаар¹⁰⁹ хангагдана. Үүнд:

- Албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж авах;
- Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах;

¹⁰⁹ Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан нийтлэг баталгаа.

- Гүйцэтгэж байгаа албан үүргийн шинж байдлаас хамааран зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах төрийн тээврийн хэрэгслийн зардлын зохих хэсгийг нөхөн авах зэрэг 10 баталгааг зааж өгсөн.

Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг баталгаанаас гадна Засгийн газраас баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-д илүү нарийн зохицуулалтыг хийж өгсөн.

Хүснэгт 2. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ

д/д	Үнэлгээ	Албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ
1	“А” буюу “Маш сайн”	а. төрийн дээд болон салбарын шагналд тодорхойлох; б. мөнгөн болон бусад хэлбэрийн шагнал, урамшуулал олгох; в. цол, зэрэг дэвийг хугацаанаас өмнө ахиулах (2 удаа дараалан “А буюу маш сайн” үнэлэгдвэл); г. цалингийн шатлалыг алгасуулж нэмэгдүүлэх (3 удаа дараалан “А буюу маш сайн” үнэлэгдвэл); д. албан тушаалд дэвшүүлэх зорилгоор мэргэшүүлэх багц сургалтад хамруулах (3 удаа дараалан “А буюу маш сайн” үнэлэгдвэл).
2	“В” буюу “Сайн”	а. цол, зэрэг дэвийг ахиулах; б. мөнгөн болон бусад хэлбэрийн шагнал, урамшуулал олгох.
3	“С” буюу “Хангалттай”	а. цол, зэрэг дэвийг хууль тогтоомжид заасны дагуу олгох.
4	“D” буюу “Сайжруулах”	а. сургалтад хамруулах; б. хугацаатай үүрэг даалгавар өгөх; в. сануулах арга хэмжээ авах.
5	“F” буюу “Хангалтгүй”	а. сануулах арга хэмжээ авах; б. албан тушаалын цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах; в. албан тушаал бууруулах (3 удаа дараалан “F буюу хангалтгүй” үнэлэгдвэл); г. төрийн албанаас халах (удаа дараа 3 ба түүнээс дээш “F буюу хангалтгүй” үнэлэгдвэл).

Тайлбар: Хүснэгтээс харвал “D” үнэлгээтэй алба хаагчийг л сургалтад хамруулах юм байна гэсэн ойлголттой байж болохгүй юм.

Төрийн албаны тухай хууль болон холбогдох журамд төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх зохицуулалтыг дээрх байдлаар хийсэн бол төрийн тусгай албан хаагч буюу цагдаагийн алба хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэхтэй холбоотой харилцааг салбарын хууль буюу Цагдаагийн албаны тухай хууль, холбогдох журам, кодоор мөн зохицуулдаг. Тухайлбал, Цагдаагийн алба хаагч нь цол хэрэглэдэг учир цагдаагийн алба хаагчийн “Цагдаагийн цол” нь ажилласан жил, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинтэй шууд холбогддог.

Цагдаагийн албаны тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-т “Цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааны үр дүнг Төрийн албаны тухай хууль заасны дагуу үнэлж, дүгнэнэ.” гэж заасан. Мөн цагдаагийн алба хаагчийн мэргэшлийн түвшинг үнэлэх журмыг цагдаагийн төв байгууллагын дарга буюу Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч батална гэж зохицуулсан. Түүнчлэн Цагдаагийн байгууллагын дарга нь үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээний үр дүнг

харгалзан цагдаагийн алба хаагчийг зохих шатны сургалтад хамруулах, цалингийн нэмэгдлийг тогтоох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах асуудлыг тухай бүр шийдвэрлэнэ.

Цагдаагийн албаны тухай хуулийн 73 дугаар зүйл (Цагдаагийн цол)-ийн 73.1-т цагдаагийн алба хаагчийн цолыг олгохдоо эрхэлж байгаа албан тушаал, алба хаасан хугацаа, ажлын үр дүнг харгалзан олгоно гэж заасан. Тодруулбал цагдаагийн алба хаагчид албан тушаал, ажилласан хугацааны дагуу цол олгогдохоос гадна ажлын үр дүн, байгуулсан хичээл зүтгэлийг үнэлэн хугацааны өмнө цолоор шагнах (цол олгох) журам, тохиолдол цөөнгүй байдаг.

2.3. Олон улсын туршлага

Төрийн албан хаагчдын ажлыг хэрхэн үнэлж, үнэлгээний мөрөөр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэн, идэвхжүүлж, урамшуулдаг талаар зарим улсын жишээг харвал:

АНУ-ын төрийн салбар дахь гүйцэтгэлийн үнэлгээ, үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу урамшуулал:



Холбооны ТАХ-чдын хувьд үнэлгээний аргачлалд “360 хэмийн үнэлгээ, Ололт амжилт болон бүтэлгүйтэл гэж хоёр хэсэгт хувааж үнэлэх, Тэнцвэржүүлсэн онооны картын үнэлгээ” зэргийг өргөн ашигладаг байна.

Холбооны ТАХ-ийн хувьд тухайн байгууллага бие даан үнэлэх “ажлын гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоо”-г хөгжүүлж, ТАХ-ийн ажлын гүйцэтгэлийг тогтмол үнэлдэг ба үнэлгээний үр дүнг тухайн ТАХ-ийн **сургалт хөгжлийн болон албан тушаалыг өөрчлөх** суурь мэдээлэл болгон ашигладаг. Тухайлбал: Гүйцэтгэлд суурилсан цалин, хөлс олгох, Мөнгөн, мөнгөн бус урамшуулал¹¹⁰ олгох, Сургалт хөгжил, Албан тушаал дэвшүүлэхэд харгалзах байдлаар тус тус ашигладаг байна.

Шинэ Зеланд улсын төрийн салбар дахь гүйцэтгэлийн үнэлгээ, үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу урамшуулал:



Тус улс “гүйцэтгэлийг сайжруулах тогтолцоо”-г 2009 оноос нийт төрийн байгууллагуудад хэсэгчлэн үе шаттай нэвтрүүлсэн байна. Энэхүү тогтолцоо нь төрийн өндөр албан тушаалтнуудын гүйцэтгэлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх хүрээнд Засгийн газраас хэрэгжүүлж буй үүрэг даалгаврын гүйцэтгэл, чадавхыг нь нягталдаг нэгдмэл загвар юм. Гүйцэтгэлийг сайжруулах тогтолцоо нь яам болон харьяа агентлагууд Засгийн газрын тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх чадавхаа бие даасан үнэлгээ (self-review)-ний аргачлал ашиглан өөрийн байгууллагын гүйцэтгэлийн түвшинд гэрлэн дохионы өнгөөр зэрэглэл тогтоон ялгаж илэрхийлдэг байна. Тухайлбал хүчтэй, сайн хэрэгжиж буй хэсэгт ногоон өнгө, хөгжүүлэх шаардлагатай, сул хэсэгт нь улаан өнгөөр ялгаж илэрхийлэх, хэрэв гүйцэтгэл хангалтгүй, зэрэглэл онооход хүндрэлтэй гэж үзвэл асуултын тэмдэг тавьж илэрхийлдэг байна.

Бүгд Найрамдах Солонгос Улсын цагдаагийн алба хаагчдын цалин, урамшууллын тухайд:

АНУ болон Шинэ Зеланд улсын тухайд нийтлэг байдлаар төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх ажил арга хэмжээний талаар авч үзсэн бол энэ хэсэгт Солонгос улсын цагдаагийн алба хаагчдын цалингийн системийг авч үзлээ.

¹¹⁰ Холбооны Засгийн газар болон нэр хүндтэй төрийн байгууллагуудын нэрэмжит шагналууд, тухайн чиг үүрэг болон салбарын түвшинд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг Холбоо, Нийгэмлэгүүдээс олгогдох 50-70 орчим нэр төрлийн шагнал байдаг байна.

БНСУ нь төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн цалингийн сүлжээтэй бус цагдаагийн алба хаагчдын бие даасан цалингийн сүлжээтэй ба Монгол Улстай харьцуулбал ажилласан жил тутам цалин нь нэмэгддэг онцлогтой.

Зураг 2. БНСУ-ын Цагдаагийн алба хаагчдын цалингийн өсөлт, бууралт



Тайлбар: БНСУ-ын цагдаагийн алба хаагчдын цалин 2012 оноос хойш сүүлийн 10 жилийн хугацаанд 6 удаа буурч, 4 удаа нэмэгдсэн байна. Түүнчлэн төрийн албан хаагчдын харилцаа сайжирч байгаа шалтгааныг төрийн албан хаагчдын цалин, нэмэгдлийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой хэмээн үзэж болно гэх дүгнэлтийг холбогдох судалгааны байгууллагаас хийжээ. Тодруулбал 2022 онд цагдаагийн алба хаагчдын цалин болон бусад нэмэгдлийн хувь хэмжээ 1.4 хувиар өссөн нь дагаад үр дүнгийн бусад үзүүлэлтийг ч нэмэгдүүлсэн гэж дүгнэжээ.¹¹¹

Олон улсын туршлага, гадаадын цагдаагийн байгууллагыг харвал 1) Алба хаагчдыг сургаж, хөгжүүлэхэд онцгой анхаарч байна. 2) Мөнгөн бус урамшууллын хэлбэрийг үе шаттай олгож байна. 3) Бие даасан цалингийн сүлжээтэй бөгөөд ажилласан жилийг хол интервалаар бус жил бүрээр тооцож цалинг нь нэмэгдүүлэх, цол болгонд тохирсон нэмэгдлийн хувьтай байна.

Иймд дээрх жишигт нийцүүлж өөрчлөлт хийнэ гэж үзвэл “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн Газрын 2014 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан Цагдаагийн алба хаагчийн төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг олгох журамд заасан ажилласан жилийг багасгах, Цагдаагийн алба хаагчдад албаны ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журамд тусгасан хувь хэмжээг нэмэгдүүлэх, Цагдаагийн албан тушаалын цолны нэмэгдлийн хувь хэмжээг бага, дунд, дээд гэсэн 3 түвшинд бус цол болгонд ялгамжтай өөр өөрөөр тогтоох, Цагдаагийн алба хаагчдад мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгохдоо ажлын туршлага буюу ажилласан жилийн шалгуурыг 3, 5, 8, 12, 15, 18 ба түүнээс дээш гэх зэргээр хугацааны менежмент хийх зэрэг өөрчлөлтүүдийг хийх боломжтой.


¹¹¹ Цахим эх сурвалж: www.Omuwon.com

2.4. Судалгааны үр дүн


Уг илтгэлийн хүрээнд 120 алба хаагчийг судалгаанд хамруулсан ба судалгаанд хамрагдсан алба хаагчдын насны бүлгийг дор харуулав. Насны бүлгийг гаргахдаа олон улсын¹¹² насны бүлгийг ашигласан болно.

Зураг 1. Судалгаанд хамрагдсан алба хаагчдыг нас, хүйсийн бүлгээр авч үзвэл

Насны бүлэг



Хүйсийн харьцаа



Судалгаанд хамрагдсан алба хаагчид бүгд дээд боловсролтой¹¹³ бөгөөд 94.8 хувь нь бакалавр, 5.2 хувь нь магистрын түвшний боловсролтой байна.

Цагдаагийн байгууллагаас 2021 онд¹¹⁴ хийсэн судалгаагаар алба хаагчдын хөндсөн гурван чухал асуудал байгаагийн **нэгт ажлын ачаалал, хоёрт цалингийн асуудал, гуравт удирдлагын манлайлал, алба хаагчдын харилцаа, хандлага** гэсэн бүлэг асуудлууд багтсан байна. Харин энэхүү илтгэлийн судалгаанаас харвал 18-25, 26-30, 31-35 насны алба хаагчдын дунджаар 34% нь, 36-40 насны алба хаагчдын 14.5 хувь нь цалингийн асуудлыг буюу мөнгө, санхүүтэй холбоотой асуудлыг хөндсөн байна. Мөн алба хаагчдын нас явах тусам санхүүгийн асуудал шийдэгдэж, бусад асуудал нь чухал байр суурь эзэлдэг байна.

Судалгаанд хамрагдсан цагдаагийн алба хаагчдын 2019, 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээг харьцуулж харвал алба хаагчдын 65.4 хувь нь сайн, 23.5 хувь нь хангалттай, 11.1 маш сайн үнэлгээтэй байна.

Цагдаагийн байгууллагад алба хаагч “А” буюу маш сайн үнэлэгдвэл дийлэнх тохиолдолд ямар ажил, арга хэмжээ авч байгааг илэрхийлэх зорилготой асуултад судалгаанд хамрагдсан алба хаагчдын 40 хувь нь мөнгөн хэлбэрийн шагнал,

¹¹² Google, Facebook зэрэг платформ, байгууллагын ашигладаг насны бүлгийг ашигласан болно.

¹¹³ Цагдаагийн алба нь “ахлагч” болон “офицер” гэсэн бүрэлдэхүүнээс бүрдэх бөгөөд ахлагч бүрэлдэхүүнд цэргийн алба хаасан, дээд боловсролгүй иргэд орох тохиолдол байдаг.

¹¹⁴ Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл, мэдээллийн төвөөс 2021 оны 07 дугаар сард 1471 алба хаагчийг хамруулсан “Цагдаагийн байгууллагын бодлого, шийдвэр, мэдээллийн хүртээмжтэй байдлыг тодорхойлох судалгаа”-г хийж гүйцэтгэсэн.

урамшуулал олгодог, 30 хувь нь ямар нэг тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй гэсэн байна. Үүнээс харвал “Маш сайн” үнэлэгдсэн алба хаагчдыг урамшуулахгүй байна гэдэг нь тэдний сонирхол, хэрэгцээг сонсохгүй байгаагаас ч дор үзүүлэлт юм. Тодруулбал 3 алба хаагч тутмын 1 нь “Хангалттай сайн” үнэлэгдсэн тохиолдолд тодорхой төрлийн урамшуулал авдаггүй гэж байгаа нь сайн үр дүн биш юм.

Цагдаагийн алба хаагчид “А” буюу маш сайн үнэлэгдсэн тохиолдолд удирдлагын зүгээс мөнгөн шагнал олгох, сургалтад хамруулах, албан тушаалын нөөцөд бүртгэх зэргээс гадна бусад тохиолдолд төрийн болон салбарын шагналаас гадна байгууллагын зүгээс “**Баярын бичиг**”, “**Албаны төлөө 1, 2, 3**” зэрэг шагнал өгөх тохиолдол цөөнгүй байдаг тухай алба хаагчид бичиж тэмдэглэсэн байна.

Хангалттай бус үнэлгээ авсан бол ямар хариу ажил, арга хэмжээ авдаг тухай тодруулахад алба хаагчдын 26.5 хувь нь шагналд тодорхойлдоггүй, 30 хувь нь сануулдаг, 16.2 хувь нь тодорхой арга хэмжээ авдаггүй гэсэн хариултыг өгчээ.

Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийг төлөвлөгөөг боловсруулах, түүний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх, явцын болон эцсийн үнэлгээ хийх, үнэлгээний мөрөөр авч хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ зэрэг гүйцэтгэлийн удирдлагын бүхий л явцад тухайн албан хаагчийг оролцуулах, оролцоог хангах асуудал маш чухал юм. Тухайлбал гүйцэтгэлийн үнэлгээ хийх явцад үнэлгээний тухай, хэрхэн биелэлтийг үнэлсэн тухай зэрэг тодорхой мэдээллийг төрийн албан хаагчид өгдөг байх практик маш чухал асуудал байдаг.

Судалгаанд хамрагдсан алба хаагчдын 47 хувь нь удирдлага гүйцэтгэлийн үнэлгээний тухай тайлбарлаж, харилцан ярилцаж хэлдэг гэсэн нь хангалттай биш үзүүлэлт юм. Иймд энэ чиглэлд анхаарч гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, түүний үнэлгээг хийх явцад харилцан ярилцдаг, тодорхой мэдээ, мэдээллээр цагдаагийн алба хаагчдыг хангадаг байх нь чухал байна.

“Судалгаанд хамрагдсан алба хаагчдын 76 хувь нь ажлын гүйцэтгэл, ажилтны мэдлэг, ур чадварт үндэслэн шагнаж, урамшуулдаг байх гэсэнтэй санал нэг байна.”

Нийт 1471 алба хаагч хамрагдсан судалгаанаас харвал алба хаагчдад нэн шаардлагатай хэрэгцээ бол ажил, ар гэрийн тэнцвэртэй байдлыг хангах, дарга, удирдлагаас цөөн тооны хүнд ачаалал үүрүүлэх бус хамт олноороо ажлын ачааллыг даван туулах, ажлын менежмент хийж ээлжийн амралтаа биеэр эдлэх боломжийг нэмэгдүүлэх, дээд түвшний удирдлагууд алба хаагчдынхаа эрх зүйн байдал, эрх ашгийг хамгаалах, сурч, хөгжих эрмэлзлийг нь дэмждэг байх явдал байна.

Төрийн тусгай албан хаагчид буюу цагдаагийн алба хаагчдыг ажлын гүйцэтгэлтэй нь харьцуулан шагнаж, урамшуулахын тулд юу хийх шаардлагатай вэ? гэх асуултыг алба хаагчдаас асууж, эрэмбэлүүлэхэд дараах үр дүн гарсан.

Хүснэгт 3. Цагдаагийн алба хаагчдыг ажлын гүйцэтгэлтэй нь харьцуулан шагнаж, урамшуулахын тулд хийх шаардлагатай ажил, арга хэмжээг эрэмбэлсэн байдал

Д/Д	Үзүүлэлт	Дугаарлалт				
		1	2	3	4	5
1	Төрийн албан хаагчдын урамшууллын хэмжээг нэмэх (1)	50	14	11	24	18
2	Ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулан урамшууллыг ялгаатай олгох (4)	11	34	28	30	14
3	Бүтээлч, идэвх санаачилгыг урамшуулдаг байх (3)	8	34	48	19	8
4	Алба хаагчдаа шударга, бодитой үнэлэх (2)	35	23	22	24	13

5	Алба хаагчдаа урамшуулахдаа алба хаагчдын хүсэлтийг харгалзан үзэж, хэрэгцээнд нь тулгуурлах (5)	13	12	8	20	64
---	--	----	----	---	----	----

Тайлбар: Дээрх хүснэгтээс харвал цагдаагийн алба хаагчид нь дээрх 5 асуудлыг ялгаатай байдлаар буюу 1) Төрийн албан хаагчдын урамшууллын хэмжээг нэмэх, 2) Алба хаагчдаа шударга, бодитой үнэлэх, 3) Бүтээлч идэвх санаачилгыг урамшуулдаг байх, 4) Ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулан урамшууллыг ялгаатай олгох, 5) Алба хаагчдаа урамшуулахдаа алба хаагчдын хүсэлтийг харгалзан үзэж, хэрэгцээнд нь тулгуурлах гэж эрэмбэлсэн байна. Түүнчлэн энэхүү үр дүнгээс үзэхэд бүтээлч идэвх санаачилгыг урамшуулдаг байх, ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулан урамшууллыг ялгаатай олгох гэдэг нь нэг түвшний асуудлууд гэдэг нь харагдаж байна.

Цагдаагийн алба хаагчийг ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулан шагнаж, урамшуулах нь хэр ач холбогдолтойг харьцуулахад үнэлгээ нь маш сайн, сайн үнэлэгдсэн алба хаагчдын хувьд төрийн албан хаагчдын урамшууллын хэмжээг нэмэх нь маш их чухал гэж үзсэн.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнгээс харвал ажлын гүйцэтгэл сайжрах тусам урамшуулах боломж нэмэгдэнэ, урамшуулал оновчтой байх тусам ажлын гүйцэтгэл ч тодорхой түвшинд сайжирдаг байна. Гэхдээ урамшууллын хэлбэрүүдээс түлхүү мөнгөн шагнал олгодог урамшууллын цөөн хэлбэр байгаа нь дутагдалтай тул үүнийг нэмэгдүүлэх, алба хаагчдын хүсэл, эрэлт, хэрэгцээнд тулгуурлан бусад хэлбэрийн буюу материаллаг бус урамшууллыг ч практик ашиглах хэрэгцээ шаардлага байна.

Тодруулбал урамшууллын бусад олон хэлбэрийг ашиглахгүй байгаагаас шалтгаалан бусад алба хаагчийн хүлээлтэд хүрэхгүй, гүйцэтгэл хүссэн хэмжээнд сайжрахгүй байх магадлалтай байна.

Өнөөдөр практикт урамшууллын бусад хэлбэрийг ашиглавал алба хаагчдын бусад хэрэгцээ хангагдан гүйцэтгэл ч урт хугацаанд, тогтмол сайжрах боломжтой. Үүний нэг нотолгоо нь ажилласан жилээс шалтгаалан хэрэгцээ хангагдаж байгаа үр дүн гарсан.

Монгол Улсын Иргэн цагдаагийн албанд орохдоо: “Монгол Улсын иргэн би цагдаагийн албанд ажиллахдаа Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, албан хаагчийн ёс зүй, сахилга, албаны нууцыг чанд сахин, чин шударгаар ажиллаж, шаардлага гарвал амь биеэ үл хайрлан зүтгэхээ батлан тангараглая. Би энэ тангарагаасаа няцваас хуулийн хариуцлага хүлээнэ.” гэж тангараг өргөдөг. “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-иар төрийн албан хаагч хувийн ашиг сонирхлоос болж нийтийн эрх ашгийг хохироохгүй байх зохицуулалттай.

Тодруулбал алба хаагчийн тэргүүн чухал асуудал бол ажил үүрэг хэдий ч бид алба хаагчдыг урамшуулж, идэвхжүүлэхдээ хэрэгцээ, сонирхолд нь үндэслэдэг байх ёстойг судалгааны тодорхой үр дүн харуулж байна.

Мөн алба хаагчдад нэн шаардлагатай хэрэгцээ бол ажил, ар гэрийн тэнцвэртэй байдлыг хангах, дарга, удирдлагаас хамт олноороо, багаараа ажлын ачааллыг даван туулах, ажлын менежмент хийж ээлжийн амралтаа биеэр эдлэх боломжийг нэмэгдүүлэх, дээд түвшний удирдлагууд алба хаагчдынхаа эрх зүйн байдал, эрх ашгийг хамгаалах, сурч, хөгжих эрмэлзлийг нь дэмждэг байх явдал байгааг онцлох нь зүйтэй.

Ашигласан материал

- Алтанцэцэг, Т., Насанбаяр, Ө. (2019). Удирдлагын сэтгэл зүй. Улаанбаатар.
- Ариунаа, Б. (2016). Төрийн албан хаагчдын ажлын сэтгэл ханамж ба бүтээмжийн харилцан хамаарал. Улаанбаатар.
 - Баатартогтох, Ц. (2012). Нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй. Улаанбаатар.
 - Баярмаа, Д. (2012). Маркетинг онол, хэрэглээ. Улаанбаатар.
 - Даваадулам, Ц. (2010). Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг. Улаанбаатар.
 - Дэлгэржаргал, Ц. (2014). Төрийн албан хаагчдын сэдэл ба шинэчлэгч зан үйлийн харилцан нөлөөлөл. Төрийн захиргаа сэтгүүл. Улаанбаатар.
 - Монгол Улсын Засгийн газар. (2021 оны 11 02). Монгол Улсын Засгийн газар. Ухаалаг засаглал: <http://igovernment.mn/docs/190-ээс> Гаргасан.
 - Монгол Улсын Засгийн газрын 218-р тогтоол. (2020). Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам. Улаанбаатар.
 - Одгэрэл, Б. (2015). Төрийн албан хаагчийн ажлын үр дүнд урамшууллын үзүүлж буй нөлөөлөл. Улаанбаатар.
 - Оедековен, О., Алзахгүй, В., Лавренз, Ж., Роббинс, Д. (2014). Манлайллын үндэс. Улаанбаатар.
 - Отгонбаяр, Н. (2020). Төрийн захиргааны орчин үеийн онол, үзэл баримтлалууд. Улаанбаатар хот: Улс төрийн боловсролын академи.
 - Төрийн албаны зөвлөл. (2008). Монгол Улсын Төрийн албаны төлөвшил. Улаанбаатар.
 - Төрийн албаны зөвлөл. (2008). Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийг удирдахуй. Улаанбаатар.
 - Төрийн албаны зөвлөл. (2012). Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам. Улаанбаатар.
 - Төрийн албаны тухай хууль. (2017). Улаанбаатар.
 - Увш, П., Хэрлэн, Б. (2017). Байгууллагын зан үйл. Улаанбаатар.
 - Удирдлагын академи. (2017). Менежмент. Улаанбаатар.
 - Удирдлагын академи. (2017). Төрийн захиргааны байгууллага дахь гүйцэтгэлийн удирдлагын хэрэгжилт. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
 - Хэрлэн, Б. (2008). Удирдах эв дүй . Улаанбаатар.
 - Цагдаагийн албаны тухай хууль. (2017). Улаанбаатар.
 - Цагдаагийн ерөнхий газар. (2021 оны 11 15). Цагдаагийн ерөнхий газар. Үндсэн сайт: <https://police.gov.mn/p/752-ээс> Гаргасан
 - Цэнд, Н., Батхүрэл, Г., Шуурав, Я., Пүрэвдагва, Х., Цэцэгмаа, Ц. (2013). Менежмент сурах бичиг. Улаанбаатар.

АЛБАНЫ НОХОЙ АШИГЛАХ СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АНХААРАХ АСУУДАЛ

Д.Батдаваа
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн багш, цагдаагийн хошууч

Товч агуулга. Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын албаны нохойн сургалт, албаны нохой ашиглалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, Монгол Улсад албаны нохой ашиглах сургалтыг хөгжүүлэх талаар санал-зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг: Төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, албаны нохой, сургалт.

Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлд төрийн тусгай албан хаагчийг тодорхойлсон. “Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх дараах албан тушаал хамаарна.”¹¹⁵ гэж заажээ.

Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндсэн хуулийн 66 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн нийгэм, эдийн засгийн бодлого, түүний батлан хамгаалах чадвар, аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах үндсэн чиглэлийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг; Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн зөвшөөрөлтэйгөөр төрийн хөтөлбөр батлах, түүнчлэн хэрэгжилтийг хангах;”¹¹⁶ гэж заасан байна. Тус улсын Төрийн албаны тухай хуулийн нэгдүгээр бүлэг 3 дугаар зүйлийн 3 дэх хэсэгт “хууль сахиулах үйл ажиллагааны тухай Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжид заасан шинж чанартай хууль сахиулах үйл ажиллагаа эрхэлдэг төрийн албан хаагчид”¹¹⁷ гэж заажээ.

Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд төрийн албан хаагчийн ангиллыг авч үзжээ. “Захиргааны төрийн албан хаагчийн төрийн албан тушаалын зэрэглэлийг тогтооно. Улс төрийн төрийн албан хаагчдад төрийн албан тушаалын ангилал тогтоогдоогүй”¹¹⁸ гэж үзсэн.

Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн тусгай байгууллагуудын тухай хуульд тодорхой заасан. Төрийн тусгай албадын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Төрийн тусгай байгууллагын ажилтнууд (цаашид - ажилтан) - үндэсний аюулгүй байдал, гадаад тагнуулын чиглэлээр эрх бүхий байгууллага, Бүгд Найрамдах Улсын Төрийн аюулгүй байдлын албанд ажиллаж байсан, тусгай цол авсан Бүгд Найрамдах Казахстан Улсын иргэд. Казахстан;”¹¹⁹ гэж тодорхойлсон байна.

¹¹⁵ Төрийн мэдээллийн эмхэтгэл №01., 2017.,

¹¹⁶ Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндсэн хууль 1995 оны 8 дугаар сарын 30-нд Бүгд найрамдах улсын бүх нийтийн санал асуулгаар баталсан.

¹¹⁷ Бүгд Найрамдах Казахстан улсын төрийн албаны тухай

Бүгд Найрамдах Казахстан Улсын 2015 оны 11-р сарын 23-ны өдрийн № 416-V RKZ хууль.

¹¹⁸ Бүгд Найрамдах Казахстан улсын төрийн албаны тухай

Бүгд Найрамдах Казахстан Улсын 2015 оны 11-р сарын 23-ны өдрийн № 416-V RKZ хууль.

¹¹⁹ Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн тусгай байгууллагуудын тухай хууль

Бүгд Найрамдах Казахстан Улсын 2012 оны 2-р сарын 13-ны өдрийн № 552-IV хууль.

Мөн хуулийн 3 дугаар зүйлийг 1 дэх хэсэгт “Төрийн тусгай байгууллага - Бүгд Найрамдах Казахстан улсын үндэсний аюулгүй байдалд заналхийлэх аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндэсний аюулгүй байдлын албаны салшгүй хэсэг болох Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгчид шууд захирагдаж, хариуцдаг тагнуул, сөрөг тагнуулын үйл ажиллагаа. Казахстаны, түүнчлэн хамгаалагдсан хүмүүс, объектын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хууль эрх зүй, зохион байгуулалт, үйл ажиллагаа, техникийн цогц арга хэмжээг хэрэгжүүлдэг төрийн байгууллагууд.”¹²⁰ гэж хуульчилсан.

Оросын Холбооны Улсын Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт төрийн албан тушаалын ангиллын талаар авч үзсэн.

“1) дарга нар - төрийн байгууллага, тэдгээрийн бүтцийн хэлтэс (цаашид мөн хэлтэс гэх) -ын дарга, орлогч дарга нарын албан тушаал, холбооны гүйцэтгэх байгууллагын нутаг дэвсгэрийн байгууллагын дарга, орлогч дарга нарын албан тушаал, тэдгээрийн бүтцийн хэлтсийн дарга, дарга нарын албан тушаал. төрийн байгууллагын төлөөлөгчийн газар, тэдгээрийн бүтцийн хэлтсийн орлогч дарга нар хамаарна.

2) туслах (зөвлөх) - төрийн албан тушаал хашиж буй хүмүүс, төрийн байгууллагын дарга, холбооны гүйцэтгэх байгууллагын нутаг дэвсгэрийн байгууллагын дарга, төрийн байгууллагын төлөөлөгчийн газрын дарга нарт бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор байгуулагдсан албан тушаал, тодорхой хугацаанд солигддог. Эдгээр хүмүүс, эсвэл удирдагчдын бүрэн эрхийн хугацаагаар хязгаарлагдсан;

3) мэргэжилтэн - төрийн байгууллагаас тогтоосон үүрэг, чиг үүргийн гүйцэтгэлийг мэргэжлийн түвшинд хангах зорилгоор байгуулагдсан, бүрэн эрхийнхээ хугацааг хязгаарлахгүйгээр сольсон албан тушаал;

4) туслах мэргэжилтнүүд - төрийн байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулалт, мэдээлэл, баримт бичиг, санхүү, эдийн засаг, эдийн засаг болон бусад хэлбэрээр хангах зорилгоор байгуулагдсан, бүрэн эрхийнхээ хугацааг хязгаарлахгүйгээр сольсон албан тушаалууд.”¹²¹ гэж зааж өгсөн.

Оросын Холбооны Улсын төрийн тусгай албанд “хуурай замын цэрэг, агаарын болон тэнгисийн цэргийн хүчин, түүнчлэн хилийн агентлагуудыг бүрдүүлэх тусгай хөтөлбөрийн дагуу бэлтгэгдсэн. , тусгай тактик, арга хэрэгслийг ашиглан тусгай ажиллагаа явуулахад зориулагдсан тусгай алба, цагдаа, цагдаа, дотоод цэрэг, үндэсний харуулын цэрэг”¹²² гэж тодорхойлсон.

Канад Улсын тусгай албыг дараах байдлаар тодорхойлсон байна. “Канадын Тусгай ажиллагааны хүчний командал (CANSOFCOM) нь канадчуудыг дотоод болон гадаадад аюул заналхийллээс хамгаалахын тулд тусгай ажиллагааны хүчийг маш богино хугацаанд байршуулах чадвартай, өндөржүүлсэн бэлэн байдалтай байгууллага юм. CANSOFCOM Канадын засгийн газрыг шуурхай, өндөржүүлсэн бэлэн байдлын тусгай ажиллагааны хүчнээр хангадаг.”¹²³

Америкийн Нэгдсэн Улсын тусгай алба нь “USSOCOM нь шууд ажиллагаа, тусгай тагнуул, терроризмын эсрэг, гадаадын дотоод хамгаалалт, уламжлалт бус дайн, сэтгэл зүйн дайн, иргэний хэрэг, хар тамхины эсрэг ажиллагаа зэрэг далд үйл

¹²⁰Бүгд Найрамдах Казахстан Улсын төрийн тусгай байгууллагуудын тухай хууль
Бүгд Найрамдах Казахстан Улсын 2012 оны 2-р сарын 13-ны өдрийн № 552-IV хууль.

¹²¹ Оросын Холбооны Улс холбооны хууль Төрийн албаны тухай хууль Хүлээн зөвшөөрсөн Төрийн Дум 2004 оны долдугаар сарын 7 Зөвшөөрсөн Холбооны зөвлөл 2004 оны долдугаар сарын 15

¹²² Малайя война (Организация и тактика боевых действий малых подразделений)» [1998]

¹²³ <https://www.canada.ca/en/special-operations-forces-command.html>

ажиллагаанд оролцдог. Салбар бүр өөрийн гэсэн үйл ажиллагааг явуулах чадвартай Тусгай ажиллагааны тусгай командтай байдаг боловч тусгай ажиллагааны янз бүрийн хүчин хамтран ажиллах шаардлагатай үед USSOCOM нь тодорхой салбарын ХК-ийн оронд үйл ажиллагааны хамтарсан бүрэлдэхүүн хэсэг болдог.”¹²⁴ гэж үзсэн.

Төрийн тусгай алба гэдэг ойлголтыг товчхон тодорхойлбол “Улс орны дотоод, гадаад аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллага.”

Тэгвэл Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндэсний аюулгүй байдал” гэж /цаашид “үндэсний аюулгүй байдал” гэнэ/ Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ.”¹²⁵ гэж тодорхойлсон нь олон улсын чиг баримжаатай нийцэж байна.

Үндсэн хэсэг

Монгол Улсад албаны нохойг анх “1934 онд хил хамгаалах ажилд албаны нохойг авч ашиглаж эхэлснээр энэ чиглэлийн ажлын”¹²⁶ үйл ажиллагаа эхэлсэн гэж хэлж болох юм.

Тэгвэл 1942 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн УЦСГ-ын гүйцэтгэх албаны хэлтсийн 3 дугаар тасагт нохойг боловсруулах ашиглах хөтлөгчийн орон тоо 2-ыг бий болгож”¹²⁷ гэмт хэрэгтэй тэмцэх ажилд ашиглаж эхэлжээ.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 14 ны өдрийн А/24 дүгээр тушаалаар Цагдаа, дотоодын цэргийн нэгдсэн төвийн Албаны нохой сургалтын хэлтсийг шинэчилэн байгуулж, дараах чиглэлээр албаны нохойг сургаж байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд Герман овчарка, Дундад Ази, Ротвейлер, Кавказ овчарка, Малиуна, Лаборадор, Дорнод Европын овчарка үүлдрийн үржлийн эм нохдыг сонголт хийн хээлтүүлэгт оруулж, нийт 45 тооны гөлөг хүлээн авч, эрүүл эсэн мэнд бойжуулан эрэл мөрдлөг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэсэрч дэлбэрэх бодис эрж хайх, харуул хамгаалалтын чиглэлээр сургалтад хамруулан төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс, дотоодын цэргийн анги салбаруудад хүлээлгэн өгөөд байна.¹²⁸

Цагдаагийн байгууллагад албаны нохойг дараах чиглэлээр ашиглаж байна.

Үүнд:

- Харуул хамгаалалт
- Самнан нэгжлэг
- Эрэн хайх
- Үнэрийн
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис
- Сум, галт хэрэгсэл тэсэрч дэлбэрэх бодис
- Гэрээт харуул хамгаалалтын
- Мөрдөн хөөх
- Гэмт этгээдийг баривчлах
- Эргүүлийн үйл ажиллагаанд

¹²⁴ "USSOCOM Posture Statement" (PDF). USSOCOM. 2007. Archived from [the original](#) (PDF) on 27 February 2008. Retrieved

¹²⁵ Төрийн мэдээллийн эмхэтгэл: №3., 2001.,

¹²⁶ А.Думбарай “Монгол төрийн цагдаагийн уламжлал” УБ., 2000 1-р дэвтэр 198 тал

¹²⁷ Д.Батдаваа “Цагдаагийн албаны нохой, түүний онцлог асуудал” ., 2009 УБ., 11 дах.,

¹²⁸ <https://surgalt.police.gov.mn/p/3778>

Тохиолдол: “Завхан аймаг дахь Цагдаагийн газрын албаны эрэлч нохой Альфа нь нийт 25 гэмт хэргийг газар дээр нь очиж илрүүлжээ.”¹²⁹

Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Эрэлч нохойн сургалтын төвийг байгуулах саналыг анх 1992 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн Улсын Гаалийн Ерөнхий Газрын даргын 170 дугаар тушаалаар баталж, албаны эрэлч нохойн сургалтыг анхлан зохион байгуулсан.

Эрэлч нохойн сургалтын төв нь ангийн гаралтай түүхий эд, мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодис, сум, галт хэрэгсэл тэсэрч дэлбэрэх бодис зэрэг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан бараа бүтээгдэхүүн олж илрүүлэх зорилгоор Гаалийн албаны эрэлч нохойг тусгай хөтөлбөрийн дагуу шат дараалсан сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.

Гаалийн нохойн сургалтын тоон мэдээнээс авч үзвэл. 2014 онд 9402 ширхэг сум болон 5 ширхэг хийн гар бууг хураан авч улсын орлого болгосон. 2015 онд ПМ маркийн хийн гар буу 4 ширхэг болон нийт 10200 ширхэг калибр бууны сум, 200 ширхэг Винтов маркийн бууны сум. 2016 онд Буянт-Ухаа дахь гаалийн газрын Эрэлч нохой хариуцсан ГУБ мөс /ice/ төрлийн мансууруулах бодисыг улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан үйлдлийг таслан зогсоосон. Зорчигчийн ачаанд албаны эрэлч нохойг ашиглан гаалийн хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэхэд гаши болон мөс /ice/ тус бүр 33 дугаар грамм илэрсэн. Микро автобуснаас мөс /ice/ 0,55гр болон түүнийг татаж хэрэглэхэд ашиглагддаг гаанс, бортого зэргийг албаны эрэлч нохойгоор илрүүлэн гэмт үйлдлийг таслан зогсоосон. 2017 онд Буянт-Ухаа дахь гаалийн газрын Эрэлч нохой хариуцсан ГУБ тус гаалийн газрын зөрчилтэй тэмцэх алба, эрүүгийн цагдаагийн газартай хамтран 2 удаагийн мөс /ice/ мансууруулах бодисыг улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан үйлдлийг таслан зогсоож, хойшлуулшгүй ажиллагаа явуулсан. 2017 оны 9 дүгээр 03-ны өдөр Буянт-Ухаа дахь гаалийн газрын Эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч өөрийн Зик дуудлагатай эрэлч нохойн хамт ур чадвар гарган Швейцар улсаас ирсэн Монгол улсын иргэн 6 гр кетамик болон 30 гр каннабисийн төрлийн ургамлыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан үйлдлийг газар дээр нь таслан зогсоож холбогдох хууль хяналтын байгууллагуудад хүлээлгэн өгсөн.

Монгол Улсын Хилийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/130 дугаар тушаалаар баталсан “Албаны нохойг бэлтгэх, ашиглах, хамгаалах журам”, Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2017 оны А/215 дугаар тушаалаар батлагдсан “Албаны нохойг бэлтгэх, ашиглах, хамгаалах заавар”-ыг хэрэгжүүлж, хилийн анги, тусгай салбаруудад хилийн эрлийн нохойг улсын хил хамгаалалтад ашиглаж байна.

Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2018 оны А/52 дугаар тушаалаар баталсан “Улсын хил хамгаалалтад нохой чарга ашиглах журам”-ыг хэрэгжүүлж, нохой чаргыг улсын хил хамгаалалтад ашиглаж байна.

- Нохой чарга
- Эрлийн нохой
- Үнэрч нохой
- Хамгаалалтын нохой
- Мөрдөн хөөх
- Хил зөрчигчийг баривчлах

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/127 дугаар тушаалаар “Эрэлч нохойн алба”-ыг байгуулж, 2018 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр нээлтээ хийж, үйл ажиллагаагаа эхлэн ажиллаж байна.

¹²⁹ <https://montsame.mn/mn/read/215385>

- Нурангиас эрэн хайх, аврах
- Уснаас эрэн хайх, аврах
- Тэсэрч дэлбэрэх бодис, ангийн гаралтай эд зүйл илрүүлэх
- Харуул хамгаалалт

Зэвсэгт хүчний 084 дүгээр анги 2013 онд 6 нохойг ахлагчийн орон тоонд оруулан цалинжуулж үйл ажиллагаандаа ашиглаж байна

- Тэсэрч дэлбэрэх бодис эрэн хайх

Тагнуулын ерөнхий газар 2010 оноос албаны нохойг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

- Тэсэрч дэлбэрэх бодис эрэн хайх

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага албаны нохой сургалтыг 2018 оны 8 дугаар сарын 16-ны өдрөөс сургалтыг эхлүүлсэн байна.

- Хамгаалалт
- Хориотой эд зүйл илрүүлэх

Тохиолдол: Аккули дүүргийн төвд албаны нохой ашиглан нутгийн оршин суугчийн гэрээс 50 мянган тенге алдагдсан хэргийг илрүүлж, мөнгө хулгайлсан этгээдийг Бетти хэмээх эрэлч нохой олжээ.¹³⁰

Бүгд Найрамдах Беларусь Улсын “Нохой сургалтын төв” нь хилийн албаны сургалтын алба бөгөөд нохой хөтлөгчийг сургах, давтан сургах, мэргэшүүлэх, эрэн хайх зэрэг үйлчилгээний албаны нохойг сургах зорилготой юм. Үнэрийн мөрөөр хүн хайх, харуул, тусгай (мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, зэвсэг, сум, тэсэрч дэлбэрэх бодис хайх), харуул (объектыг хамгаалах), түүнчлэн үйлчилгээний үүлдрийн нохойг өсгөн үржүүлэх, үйл ажиллагааг явуулдаг.¹³¹

Тохиолдол: 2020 оны 4 дүгээр сарын 6-нд Гомелийн ойролцоох Уза тосгоны оршин суугчдыг цочирдуулсан гэмт хэрэг гарчээ. Хохирогчийн цогцос хүн таних аргагүй шархадсан байжээ. Гэмт хэргийн мөрөөр мөрдөгчид сэжигтнийг саатуулжээ. Мэргэжилтнүүд хэргийн газарт үзлэг хийж, цогцосноос холгүйхэн цусан толботой цамц, хүрэм, хутга байгааг анзаарчээ. Албаны нохой алуурчны хөдөлгөөний боломжит чиглэлийг зааж, сэжигтэн 36 настай эрэгтэйг Эрүүгийн цагдаагийн албаныхан шуурхай илрүүлжээ.¹³²

Америкийн Нэгдсэн Улс, Канад Улсын тусгай албадын албаны нохойн сургалт, ашиглалтын үйл ажиллагааг К-9 холбоо хариуцан мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч үйл ажиллагааг зохион байгуулдаг.

К-9-ууд хамтрагчдынхаа төлөө амиа тавьж, гэмт хэрэгтнүүдийг мөшгөх, хүмүүсийг эрж хайх, аварч, хар тамхи, зэвсэг, чухал нотлох баримтуудыг үнэр илрүүлэх. Албаны нохой цаг агаарын ямар ч нөхцөлд цаг харгалзахгүй үүрэг гүйцэтгэж – шөнө, өдөр, амралтын өдрүүдэд ч ажилладаг. К-9 бол хууль сахиулах багийн үнэлж баршгүй гишүүд юм.

Албаны нохойнууд нь хөтлөгчийн хамт хэтэрхий аюултай нөхцөл байдалд орж ажилладаг. Хууль сахиулах байгууллагын офицеруудын ажлыг аюулгүй болгож, офицеруудад үр дүнтэй ажиллахад нь тусалдаг, учир нь К-9-ийн хурц үнэрлэх мэдрэмж нь сэжигтэн, нотлох баримтыг хүнээс хамаагүй хурдан илрүүлдэг.

Тэд офицерууд болон тэдний гэр бүлийнхэнд итгэдэг эелдэг зөөлөн амьтад юм. Ноход алба хааж байхдаа гэрийн тэжээвэр амьтан болж гэртээ офицерын хамт амьдардаг бөгөөд гэр бүлийн нэг хэсэг болдог. Гэсэн хэдий ч тушаал өгсөн

¹³⁰ https://pavlodartv.kz/kz/news/jedel_jeli/ittin-komegimen-kylmys-ashyldy “18:59, 21 тамыз 2019”

¹³¹ <https://tops.gpk.gov.by/smorgon/kinologicheskij-tsentr/>

¹³² <https://belaruspartisan.by/life/531054/>

тохиолдолд эдгээр К-9-ууд гэмт хэрэгтнүүдийг хөөж, баривчлах хүртэл барьж чадна.¹³³

Тохиолдол: АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Цагаан ордонд Исламын улс бүлэглэлийн толгойлогч агсныг буулгаж авсан тусгай багынхантай уулзаж, ажиллагааны үеэр шархадсан цэргийн албаны нохойд одон гардуулав.

Трамп Цагаан ордонд тусгай хүчний нохойд медаль гэрчилгээг хамт гардуулсан байна.

Конан өнгөрсөн сард ISIS-ын толгойлогчийн хашаанд нууцаар дайрах үеэр Абу Бакр аль-Багдадиг хонгилоор хөөж явсан гавьяатай. Багдади Конан түүнийг гарцгүй хонгилоор хөөж явах үед амиа золиослогч хантаазыг дэлбэлсний дараа уг нохой нь Дельта багийн гишүүдээс бэртсэн цорын ганц гишүүн байв.¹³⁴

Дүгнэлт

Дэлхийн зарим улсад төрийн тусгай албадыг тодорхойлсон байдлыг харьцуулан судалж үзэхэд, үндэсний гадаад болон дотоод аюулгүй байдлыг тухайн улсынхаа эрх зүйн хэмжээнд заасан чиг үүргийн хүрээнд дангаарчилан болон хамтран зохион байгуулж явуулдаг байгууллагуудыг нийтлэг байдлаар тодорхойлжээ.

Тэгвэл төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд дайн байлдаан болон гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, үнэр судлалын чиглэлээр албаны нохойг эрт үеэс ашиглаж ирсэн байна.

Монгол Улсад албаны нохой сургалтын нэгдсэн төвийг байгуулан ажиллаж, гадаадад алба хаагчдыг сургалтад хамруулахын зэрэгцээ дотоодод албанд хөтлөх нохой болон боловсон хүчнээ бэлтгэж, хил хамгаалах, цагдаагийн байгууллагын албаны үйл ажиллагаанд ашиглаж ирсэн уламжлалтай байна.

Өнөөдрийн байдлаар төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд тус тусдаа сургалтыг явуулж, нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөгүй сургалтын үйл ажиллагаа явагдаж иржээ.

Ашигласан материал

- А.Думбарай. “Монгол төрийн цагдаагийн уламжлал”. УБ., 2000. 1 дүгээр дэвтэр
- Д.Батдаваа. “Цагдаагийн албаны нохой, түүний онцлог асуудал”. УБ., 2009
- Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндсэн хууль 1995
- Бүгд Найрамдах Казахстан Улсын Төрийн албаны тухай
- Бүгд Найрамдах Казахстан Улсын Төрийн тусгай байгууллагуудын тухай хууль
- Оросын Холбооны Улсын Төрийн албаны тухай хууль 2004
- Малая война (Организация и тактика боевых действий малых подразделений)» [1998]
- "USSOCOM Posture Statement" (PDF). USSOCOM. 2007. Archived from the original (PDF) on 27 February 2008. Retrieved
- Бүгд Найрамдах Казахстан Улсын Зэвсэгт хүчний цэргийн цагдаагийн нохойн байцаах албыг зохион байгуулах дүрэм

¹³³ <https://www.northlandk9.org/>

¹³⁴ <https://www.military.com/daily-news/2019/11/25/trump-awards-conan-hero-special-forces-dog-medal-white-house.html>

ЗОРИУЛАЛТЫН АЧИГЧ, ЧИРЭГЧ АВТО МАШИНААР ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЗӨӨЖ ШИЛЖҮҮЛДЭГ КОМПАНИУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

*М.Бат-Эрдэнэ
ДХИС-ийн магистрант,
цагдаагийн ахмад*

Товч агуулга. Нийслэлийн авто замын хөдөлгөөний түгжрэл бол төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, иргэдийн ахуй амьдрал болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх хүчин зүйл болж байна.

Нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргаас цөөнгүй ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирсэн ч иргэдийн эсэргүүцэл, шүүмжлэлтэй хамгийн их тулгарч байгаа ажил бол замын хөдөлгөөнд саад болж буй автотээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх үйл ажиллагаа юм.

Энэхүү өгүүлэлд нийслэлийн авто замын түгжрэлийн өнөөгийн байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйл болон замын хөдөлгөөнд саад учруулж байгаа тээврийн хэрэгслийг зориулалтын ачигч, чирэгч авто машинаар зөөж шилжүүлэх үйлчилгээ үзүүлж буй компаний үйл ажиллагааны талаар товч авч үзсэн.

Түлхүүр үг. Авто замын түгжрэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих зөрчил, зориулалтын ачигч, чирэгч авто машин, компани.

Удиртгал

Иргэд авто замын түгжрэлийг хотын хүн амын болон төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, зах, худалдааны төвийн хэт төвлөрөл, хангалтгүй уулзвар замууд, жолооч нарын хөдөлгөөнд оролцох соёлгүй зан байдал хамааралтай гэж үздэг.

Улаанбаатар хотын авто замын ерөнхий сүлжээ нь 349,000 хүн амтай, 10,044 автомашинтай буюу хүн амын ердөө 2.9 хувь нь автомашинтай байхаар 1975 оны ерөнхий төлөвлөгөөний дагуу баригдсан бөгөөд хотын хүн амын даац дээд тал нь 400,000-500,000 байхаар тооцоолсон байдаг. Гэтэл Улаанбаатар хот дэлхийн 415 дахь том хотын олон улсын жагсаалтад оржээ.

Нийслэлийн хэмжээнд 2016 оны байдлаар 458262 автомашин байсан бол 2021 оны байдлаар 662,644 болж даруй 202382¹³⁵ нэгжээр өссөн байна. Энэ нь нийслэлийн замын түгжрэл хамгийн их нөлөө үзүүлж байгаа нэг хүчин зүйл болж байна.

Үндсэн хэсэг

1000 хүнд ноогдох автомашины тоо 30-аас дээш болоход замын нэвтрүүлэн өнгөрүүлэх чадварыг хангах асуудалд бэрхшээл үүсэх, 130-аас дээш бол тухайн хотын автомашинд хязгаар тавих, 200-250 хүрвэл нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгсэлд давуу эрх өгч зөвхөн түүгээр үйлчлүүлэх асуудал тавигддаг байна.

Энэхүү өгүүлэлд дараах 2 үндсэн асуудлыг авч үзлээ. Үүнд:

1.Нийслэлийн авто замын түгжрэл, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, түгжрэлийг бууруулах арга зам;

¹³⁵ <https://www.1212.mn>

2.Замын хөдөлгөөнд саад учруулж буй тээврийн хэрэгслийг зориулалтын ачигч, чирэгч авто машинаар зөөж шилжүүлэх үйлчилгээ үзүүлж буй компаний үйл ажиллагаа.

Нэг.Нийслэлийн авто замын түгжрэл, нөлөөлж буй хүчин зүйл

Авто замын түгжрэлийн асуудал ярьж байгаа дэлхийн томоохон хотуудын хувьд 1000 хүнд ногдох суудлын автомашин нь 120-оос дээш байгаа бөгөөд Улаанбаатар хотын хэмжээнд энэ үзүүлэлт 239 байгаа нь тулгамдсан асуудал болжээ.

Нийслэлд бүртгэлтэй автотээврийн хэрэгслүүдийг хөдөлгүүрийн төрлөөр ангилбал,

Хүснэгт №1		
№	Тээврийн хэрэгслийн хөдөлгүүр	Тоо ширхэг
1.	Бензин хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл	407,712
2.	Дизель хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл	129,858
3.	Цахилгаан хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл	306
4.	Хийн хөдөлгүүр бүхий тээврийн хэрэгсэл	13,641

Нийслэлийн авто замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн 128,983 буюу 21.4% нь Toyota Prius маркийн автомашин байна.

Авто замын зохицуулалтын бодлого хариуцсан бүхэл бүтэн яам, газар байдаг боловч авч хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр, ажил арга хэмжээ нь хүссэн үр дүнд хүрэхгүй байгаа нь бодлого оновчтой бус байгаатай холбоотой байна.

Нөгөө талаараа замын бодлого боловсруулдаг яамны төсөв түгжрэлийн асуудлыг нэг мөр болгоход хүрэлцэхгүй байна. Тиймээс төсөв хөрөнгөөс хамаарч зам өргөсгөж, гэрлэн дохиог өнөөг хүртэл энд тэндгүй байрлуулсаар ирсэн нь түгжрэл бий болгоход зохих нөлөө үзүүлжээ. Өөрөөр хэлбэл, түгжрэлийн “буруутан” гэрлэн дохио 250 метр тутамд байгаа нь түгжрэлийг зохиомлоор үүсгэх нэг хүчин зүйл болж байна. Тухайлбал, нийслэл хотын төвийн баруун дөрвөн замаас УБИС хүртэлх замд 5-6 гэрлэн дохиотой, тэр болгон дээр хөдөлгөөнд зогсонги байдал руу орж түгжрэл гацаа үүсгэж байна.¹³⁶

Улаанбаатар хотод өдөрт дунджаар 200 мянга орчим автомашин хөдөлгөөнд оролцдог тухай дээр дурдсан. Үүнээс өглөө ажил сургууль цэцэрлэг цуглах, буюу 07:30-09:00, өдөр 11:50-13:00 цаг орой тарах буюу 17:00-19:30 цагийн хооронд хөдөлгөөний ачаалал хамгийн оргилдоо хүрч байна.

Энэ бол түгжрэлийн хамгийн гол шалтгаан болох хот төлөвлөлттэй холбоотой ба засаг захиргааны байгууллага, сургууль цэцэрлэг гэх мэт хамгийн олон хүний оролцоотой үйл ажиллагаа явуулдаг объектууд хотын төвд байрладагтай шууд холбоотой.

Зөвхөн Их тойруугийн дотор гэхэд л өнөөдрийн байдлаар төрийн 286 байгууллагад 28993 алба хаагч ажиллаж байгаа гэсэн судалгаа байна. Тэдгээрийн 11402 нь нийтийн тээврээр, 4698 нь явганаар, 12893 нь хувийн автомашинаар хамгийн багадаа 3 км хол нь 10 орчим км замыг автомашинаараа туулж ажлын байрандаа ирдэг ба автомашинаа өдрийн турш зогсоолд тавьдаг. Энэ байдал нь нэгд замын ачааллыг нэмэгдүүлдэг хоёрт авто зогсоолын хүртээмжийг шууд бууруулдаг сөрөг талыг бий болж байна.

Их, дээд сургуулийн тухайд 92098 оюутан өглөө оройн цагаар сургууль, гэрийн хооронд явдаг ба тэдгээрийн 68049 буюу 69% нь нийтийн тээврээр, 16908

¹³⁶ <http://eagle.mn>

буюу 17% нь явганаар, 13209 буюу 14% нь хувийн автомашинаар замын хөдөлгөөнд ордог юм байна. Үүнийг графикаар үзүүлбэл:

График №1



Худалдаа, үйлчилгээний томоохон төвүүдийн байрлал тэдгээрийн орчин дахь замын хөдөлгөөний зохион байгуулалт оновчгүй, зогсоолын талбайн менежмент, зохицуулалт хангалтгүй, хүрэлцээгүй байдал нь түгжрэлд нөлөөлөх гол хүчин зүйл болж байна.

Замын ачааллыг бууруулахаар авсан нэг арга хэмжээ бол дугаарын хязгаарлалт юм. Энэ шийдвэр нь хэдийгээр маш зөв гаргалгаа байсан боловч маш олон тооны иргэд хууль бус дугаар хэрэглэх, боломж бүхий иргэд 2 автомашинтай болж эхэлсэн нь үр дүнг бууруулсан гэж мэргэжлийн хүмүүс үзсэн байна.

Замын хөдөлгөөний түгжрэлийн өөр нэг шалтгаан бол зогсоолын гачигдал. Зогсоолын боломжит хувилбаруудыг судалж тогтоон ашиглахгүй байгаа болон зогсоолын менежмент хангалтгүйгээс албан газар байгууллагууд өөрийн өөрийн орон зайг хамгаалан зөвхөн өөрсдийн эрх ашгийг бодон бие даасан зогсоолын орон зайг нийтийн эрх ашгийг үл хамааран бий болгодог байдал ихээхэн нөлөөлж байна.

Энэ нь нэг талдаа зогсоолын тухай биеэ даасан хууль байхгүйтэй шууд холбоотой юм. Үүнээс гадна төр засгийн болон гадаадын зочид төлөөлөгчдийн хамгаалалтын ажил, зам засвар цэвэрлэгээний ажил, замын хажуугийн барилга бүтээн байгуулалтын хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаалсан түгжрэлүүд томоохон байр суурийг эзэлж байна.

Нийслэлийн авто замын ачааллыг нэмэгдүүлж, түгжрэлийг үүсгэхд юу нөлөөлсөн талаар иргэдээс судалгаа¹³⁷ авахад дараах хариултыг өгсөн байна. Тухайлбал,

Нэгдүгээрт, гурван хүүхэд тутмын нэг нь харьяа сургуульдаа явдаггүй. Харин тэднийг хүргэж өгөхийн тулд хотын төв рүү явах иргэдийн 26 хувь нь хувийн унаагаар хүргэж өгдөг байна. Энэ нь түгжрэл үүсэхэд голлон нөлөөлдөг гэжээ.

Хоёрдугаарт, томоохон зах худалдааны төвүүдээс үүдэлтэй түгжрэл байна. Учир нь, нийслэлийн том гэх бүхий л худалдааны төвүүд хотын төвд байрладаг байна. Судалгааны дүнгээр хотын төв рүү орж буй иргэдийн 40 хувь нь худалдаа, наймаа хийх, дэлгүүр хэсэх гэж явдаг.

Гуравдугаарт, 10 өрх тутмын нэг нь такси үйлчилгээнд явдаг гэсэн байна. Тэгвэл нийслэлд 414 мянган өрх бий гэвэл 41400 машин нийслэлийн түгжрэлд томоохон нөлөө үзүүлж байна гэдгийг иргэд онцолсон байна.

Харин “түгжрэлийг бууруулахын тулд ямар арга хэмжээ авбал үр дүнтэй вэ?” гэдгийг иргэдээс асуухад дараах таван саналыг хамгийн их хэлжээ. Үүнд:

¹³⁷ <http://itoim.mn/article/X4kAG/31949>




- Иргэдийн 61-76 хувь нь гэрийн ойролцоо цэцэрлэг, сургууль шинээр барьж, хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх;
- Нарантуул, Хүчитшонхор, Бөмбөгөр, 100 айл зэрэг томоохон худалдааны төв, захуудыг дэд төвүүдэд тархаан байрлуулах;
- Нийтийн тээврийн парк шинэчлэл хийх, метро их багтаамжит масс транзит барьж нэвтрүүлэх;
- Авто замын сүлжээг нэмэгдүүлэх;
- Ухаалаг гэрлэн дохионы системийг нэвтрүүлж оргил цаг болон, ачаалалтай уулзваруудын хөдөлгөөнийг оновчтой зохицуулалтыг хийх зэрэг ажлуудыг хийвэл түгжрэл бууруулсан гэж үзнэ¹³⁸ гэжээ.

Бүдүүвч зураг №1

ИРГЭДИЙН ИХ ТОЙРУУГИЙН БҮС РҮҮ НЭВТРЭН АВДАГ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД



- УБ хотын 18-65 нийт иргэдийн 32% нь буюу 1/3 хэсэг нь их тойруу руу нэвтрэн төрийн үйлчилгээ авахгүй байна.
- Эдгээр иргэдийн насны бүлгээр нь авч үзвэл 18-20 настай иргэдийн 49%, 21-25 настай иргэдийн 40% нь их тойруу руу нэвтрэн төрийн үйлчилгээ авахгүй байна.
- Бусад насны бүлгийн хувьд 23%-33% нь их тойруу руу нэвтрэн төрийн үйлчилгээ авдаггүй байна. Үүнээс үзэхэд одоогоор нас залуу иргэд их тойруугаас төрийн үйлчилгээ авах байдал нь бусадтай харьцуулахад бага байна.



Үйлчилгээ	Эзлэх %
Бусад үйлчилгээ	4%
Дүүргийн ЗДТГ-ын үйлчилгээ	4%
Нийгмийн даатгалын үйлчилгээ	3%
Нэг цэгийн үйлчилгээ	2%
Газрын албаны үйлчилгээ	2%
Татварын үйлчилгээ	2%
Хотын захиргаанаас үйлчилгээ авдаг	2%
Цагдаагийн байгууллагын үйлчилгээ	2%
Төрийн яамны үйлчилгээ	1%
Хорооны үйлчилгээ	1%
Нийгмийн халамжийн үйлчилгээ	1%
Шүүх, прокурорын үйлчилгээ	1%

- УБ хотын иргэдийн 23% нь буюу 4 хүн тутмын 1 нь эмнэлгийн үйлчилгээ авахаар их тойруугийн бүс рүү нэвтэрдэг байна.
- Мөн 6% нь улсын бүртгэлийн үйлчилгээ авахаар, 6% нь сургуулийн үйлчилгээ авахаар их тойруугийн бүс рүү нэвтэрдэг байна.

11

Судалгаанд оролцсон иргэдийн 82 хувь нь 100 айлыг хотоос гаргах, 73-75 хувь нь Нарантуул захын өргөтгөлийг, Өгөөмөр захыг хотоос гаргаж задлахыг дэмжжээ. Нарантуул орчмын бүсийг хотоос гаргавал түгжрэлийг бууруулахад бодитой үр дүн гарна¹³⁹ гэсэн байна.

Өнөөдөр нийслэлийн автозамын Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Авто замын газар, Нийслэлийн Замын цагдаагийн газар, Ерөнхий төлөвлөгөөний газар, Мэдээллийн технологийн газар, Боловсролын газар, Гудамж төсөл, Зам тээврийн яам зэрэг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл хамтран Авто замын ачааллыг зохицуулах арга хэмжээг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах ажлын хэсгийг байгуулаад ажиллаж эхэлжээ. Тухайлбал:

- Сургуулийн автобус явуулж эхэлсэн
- Нийтийн тээврийг нэгдүгээр эгнээгээр зорчуулах
- Шинээр зам барих
- Зам өргөтгөн шинэчлэх
- Байгалийн чулуун хучилттай зам шинээр барих

¹³⁸ Авто замын түгжрэлийг бууруулах шийдлийн судалгаа. УБ.2021

¹³⁹ <http://itoim.mn/article/X4kAG/31949>

- Авто машиныг тэгш, сондгой дугаараар хөдөлгөөнд оролцуулах зэрэг ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлжээ.

Түүнчлэн, Засгийн газартай хамтран машины хэрэглээг бууруулах бодлого баримталсны үр дүнд ухаалаг тээврийн хэрэгслийн систем нэвтрүүлэх гэж байна. Нийтийн тээвэр ухаалаг системд шилжсэнээр иргэд машины хэрэглээнээсээ татгалзаж, автобусыг сонгон үйлчлүүлж, замын ачааллыг бууруулахад тодорхой хэмжээгээр нөлөөлнө хэмээн тооцоолжээ. Нийслэлийн Мэдээлэл технологийн газар, Замын хөдөлгөөний удирдлагын төв хамтраад “Түгжрэл” нэртэй аппликэйшн зохион бүтээхээр ажиллаж байгаа бөгөөд ус апп-ын тусламжтайгаар жолооч нар замын хөдөлгөөний тухай мэдээлийг гар утсандаа авч очих газартаа хамгийн богино хугацаанд хүрэх юм.

Хоёр.Тээврийн хэрэгслийг зориулалтын ачигч, чирэгч авто машинаар зөөж шилжүүлэх үйлчилгээ үзүүлж буй компаний үйл ажиллагаа

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн А/101 дүгээр тушаалаар баталсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”¹⁴⁰-ын 9 дүгээр зүйлд зааснаар цагдаагийн алба хаагч нь Цагдаагийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.4 дэх хэсэг, 33, 34 дүгээр зүйл¹⁴¹, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт¹⁴² заасан үндэслэл, журмын дагуу тээврийн хэрэгслийг түр саатуулах, зөөж шилжүүлэх шийдвэрийг “бичгээр” буюу “цахимаар” гаргана.

Нийслэлийн хэмжээнд тээврийн хэрэгслийг түр саатуулах, зөөж шилжүүлэх үйл ажиллагааг гэрээний хүрээнд хэрэгжүүлж байгаа 14 аж ахуйн нэгжийн 100 ачигч-чирэгч автомашин ажиллаж байна.

Замын хөдөлгөөний дүрэмд заасан түр буюу удаан зогсох журам зөрчиж, бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулсан тээврийн хэрэгслийг зориулалтын ачигч-чирэгч автомашин ашиглан зөөж шилжүүлснээр замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг бууруулахад тодорхой хувиар нөлөөлдөг. Түүнчлэн гэмт хэрэг, зөрчилд холбогдуулан шалгах шаардлагатай тээврийн хэрэгслийг цагдаагийн эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн дагуу түр саатуулах байранд саатуулан ажиллаж байна.

Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 14.8¹⁴³-д зааснаар дараахь тохиолдолд түр зогсохыг хориглоно. Үүнд:

а/ уулзвар, гарц дээр болон уулзварт 20 м, гарцад 10 м-ээс ойр зайд (тусгаарлах зурвас буюу тэнхлэгийн үргэлжилсэн шугамтай Т-хэлбэрийн уулзвар, гарцын хөдөлгөөн огтлолцохгүй хэсэгт зогсохоос бусад тохиолдолд);

б/ явган хүний гарц, унадаг дугуйн замын огтлолцол дээр болон тэдгээрийн өмнө 5 м-ээс ойр зайд;

в/ чиглэлийн тээврийн хэрэгслийн буудал, таксийн зогсоол дээр (22 цагаас 06 цагийн хооронд хүн буулгах, суулгахын тулд түр зогсохоос бусад тохиолдолд);

г/ чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ болон унадаг дугуйн эгнээнд;

д/ төмөр замын гарам дээр болон түүнд 20 м-ээс ойр зайд;

е/ гүүрэн дээр болон доор;

ж/ хонгил дотор;

з/ замын тэмдэг, гэрлэн дохиог бусад жолоочоос халхлах газарт;

¹⁴⁰ <https://legalinfo.mn/mn/detail/14469>

¹⁴¹ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

¹⁴² Төрийн мэдээлэл. 2015. №28. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль

¹⁴³ <https://legalinfo.mn/mn/detail/13641>. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 239 дугаар тогтоолоор батлагдсан.

и/ бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах газарт;
 к/ тээврийн хэрэгсэл зогсоход түүнээс үргэлжилсэн шугаман тэмдэглэл (зорчих хэсгийн захыг тэмдэглэснээс бусад) буюу зорчих хэсгийн эсрэг талын зах, эсхүл тэр талд зогсож байгаа тээврийн хэрэгсэл хүртэл 3 м-ээс бага зайтай газарт;
 л/ 5.29 тэмдэг бүхий ослын зогсолтын зурвас дээр;

м/ үзэгдэлт замын дагуу аль нэг чигт 100 м-ийн дотор хязгаарлагдмал нөхцөлд зорчих хэсэг дээр¹⁴⁴ түр зогсохыг хориглодог байна.

Нийслэлийн нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах үйл ажиллагааг 2020 оны 9 дүгээр сараас эхлэн цахим хэлбэрт шилжүүлж, дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтэд өдөр тутмын хяналтыг тавих, иргэдэд хүндрэл чирэгдэлгүй үйлчлэх нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдаг.

Хүснэгт №4

№	Цахим хэлбэр шилжүүлэхээс өмнөх байдал	Цахим хэлбэр шилжүүлсэний дараах байдал
1.	Зааж шилжүүлэх талаарх шийдвэрийг цагдаагийн алба хаагч гараар бичиж өгдөг байсан;	Зөөж шилжүүлэх шийдвэрийг 7 хоногийн хуваарийн дагуу ээлжээр цагдаагийн алба хаагч цахимаар гаргадаг болсон.
2.	Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлсэн, түр саатуулсан талаарх мэдээлэл бүрэн бүртгэгддэггүй байсан	Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлсэн талаарх мэдээллийн цахим сантай болж, мэдээлэл бүрэн бүртгэгдэж, иргэд шуурхай мэдээлэл авах боломж бүрдсэн.
3.	Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлсэн талаар иргэдэд мэдээлэл хүргэдэггүй бөгөөд 18001200 лавлах утсанд мэдээллийг бүртгэдэг байсан;	Зөөж шилжүүлсэн тээврийн хэрэгслийн жолоочид хэлбэрээр мэдээлэл хүргэдэг болсон. <i>/Автомашины салхины шилэн дээрх утасны дугаар луу/</i>
4.	Тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлсэн орлогоос татвар төлдөггүй байсан;	НӨАТ болон байгууллагын орлогын албан татвар төлөгддөг болсон
5.	Тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд холбогдох дүрэм, журмыг бүрэн хэрэгжүүлдэггүй, иргэдийг чирэгдүүлдэг байсан.	Аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт тавьж эхэлснээр хууль тогтоомжийг хэрэгжүүлэх байдалд ахиц гарч, иргэдэд нээлттэй болсон

Нийслэлийн хэмжээнд замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн жолооч нараас дараах нийтлэг зөрчил ихээр гаргадаг байна. Тухайлбал:

- “Чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ” тэмдэг, тэмдэглэл бүхий зорчих хэсгийн “нэгдүгээр” эгнээнд тээврийн хэрэгслээ зогсоож, нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулдаг;
- Замын хөдөлгөөний дүрэмд заасан түр буюу удаан зогсох журмыг зөрчиж, зорчих хэсэг дээр тээврийн хэрэгслээ удаан хугацаагаар орхиж, бусад тээврийн хэрэгсэл, явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулдаг;
- Явган хүний зам гарц дээр буюу тэмдэг, тэмдэглээ зөвшөөрөгдөөгүй явган хүний зам дээр тээврийн хэрэгслээ байрлуулж, явган зорчигчийг зам тээврий осолд өртөх эрсдэл үүсгэдэг;

¹⁴⁴ <https://legalinfo.mn/mn/detail/13641>.

- Байгууллагын гарц, хаалгыг хааж, түүнчлэн зогсоолд байрлуулахдаа бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хаах газарт удаан хугацаагаар тээврийн хэрэгслээ зогсоож, цагдаагийн байгууллагын гомдол, мэдээлэл хүлээн авах тусгай дугаарын утсанд зохиомол ачаалал үүсгэдэг зэрэг болно.

Цахим систем нэвтэрснээс хойш 2020.03.20-ны өдрөөс 2021.02.27-ны өдөр хүртэл хугацаанд Ачигч автомашинуудын нэгдсэн холбоо болон Тээврийн цагдаагийн албанд 77520 хүсэлт ирүүлснийг шийдвэрлэсэн байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Цахим систем нэвтэрснээс хойш тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх хэрэгцээ шаардлага, үүнээс зөөж шилжүүлсэн тээврийн хэрэгсэл

Хүснэгт №5

№	Асуумж	Тоо	Тайлбар
1.	Тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх талаар ирүүлсэн хүсэлт	77520	Ачигч автомашинуудын нэгдсэн холбоо болон Тээврийн цагдаагийн албанд ирүүлсэн
2.	Түр саатуулах байранд хүргэгдсэн	20341	Хүсэлтийг хүлээн авч цахимаар шийдвэр гаргасан
3.	Түр саатуулахаас татгалзаж шийдвэрлэсэн	3940	Хүсэлтийг зөвшөөрөхгүй, цуцалсан
4.	Жолооч нь ирсэнээр хүлээлгэж өгсөн	19965	Төлбөрөөс чөлөөлөгдсөн
5.	Цагдаагийн алба хаагчийн шийдвэрээр хууль сахиулах зорилгоор түр саатуулсан	33274	Согтуугаар болон эрхийн үнэмлэхгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодсон гэх мэт

Улаанбаатар хотод тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх үйл ажиллагаа явуулдаг 14 аж ахуйн нэгжтэй холбоотой 290 өргөдөл, гомдол ирүүлсэнээс бүгдийг шийдвэрлэсэн байна. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын 15 буюу 5.1% нь зөрчилтэй байсан бөгөөд 27 буюу 9.3%-д төлбөрийг буцаан орсон байна. Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг 14 аж ахуйн нэгж тус бүрээр нь нарийвчлан авч үзвэл:

Тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх, түр саатуулах үйл ажиллагаатай холбоотой иргэдийн өргөдөл гомдол, санал мэдээлэл шийдвэрлэлт¹⁴⁵

Хүснэгт
№6

№	Аж ахуйн нэгж	Ирсэн өргөдөл гомдол	Шийдвэрлэсэн өргөдөл гомдол	Зөрчилтэй	Төлбөр буцаан олгосон
1.	“Юу Эн Эм Жи Эл” ХХК /ТС-1/ БЗД	6	6	0	0
2.	“Их тээвэр” ХХК /ТС-4/ БЗД	13	13	1	1
3.	“Авто хүч” ХХК /ТС-3/ СХД	0	0	0	0
4.	“Авто гоулд транс” ХХК /ТС-6/ СХД	7	7	1	0
5.	“Бодь транс” ХХК /ТС-8/ БГД	18	18	0	3

¹⁴⁵ Нийслэлийн авто замын хөгжлийн газрын танилцуулга. УБ.2021

6.	“Баян хаяабуса” ХХК /ТС-11/ БГД	21	21	2	0
7.	“Сидней констракшн монголиа” ХХК /ТС-10/ ХУД	10	10	2	0
8.	“Дабль эйт” ХХК /ТС-12/ ХУД	5	5	0	0
9.	“Тэнгэрлэг наяд” ХХК /ТС-14/ ХУД	14	14	3	2
10.	“Булган жацо” ХХК /ТС-15/ ЧД	41	41	2	4
11.	“Батзэв” ХХК /ТС-2/ ЧД	65	65	3	6
12.	“Би Икс Юу Ти” ХХК /ТС-5/ СБД	25	25	1	2
13.	“Успех” ХХК /ТС-9/ СБД	58	58	0	6
14.	“Энергэтикланд” ХХК /ТС-13/ СБД	7	7	0	3
Нийт		290	290	15	27
Ирүүлсэн санал хүсэлт		56	56		

Тээврийн хэрэгслийг зориулалтын ачигч, чирэгч авто машинаар зөөж шилжүүлэх үйлчилгээ үзүүлж буй компаниуд зөрчилтэй тээврийн хэрэгслийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр зөөж шилжүүлэхээс гадна эвдэрсэн, мөргөлдсөн, өөрөө явах боломжгүй, удаан хугацаагаар асаагүй, авто машин ачих, чирэх, цас, ус, шавар, хайрганд суусан машиныг хот дотор болон хот хооронд 24 цагын турш хямд үнээр үнэ тохирч ачих, чирэх, татах үйлчилгээг түргэн шуурхай үзүүлдэг байна.

Тээврийн хэрэгслийг зориулалтын ачигч, чирэгч авто машинаар зөөж шилжүүлэх үйлчилгээ үзүүлж буй компаниудын төлөөллөөс бүрдсэн “Ачигч автомашинуудын нэгдсэн холбоо” нь 2015 оноос өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд төр, хувийн хэвшилтэй хамтарч ажилладаг байна.

Монгол Улсын Хууль Зүй, Дотоод Хэргийн Сайдын 2019.06.07 өдрийн А/101 тоот тушаалын 9.7. “Цагдаагийн алба хаагч нь Цагдаагийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.4 дэх хэсэг, 33, 34 дүгээр зүйл, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу тээврийн хэрэгслийг түр саатуулах, зөөж шилжүүлэх шийдвэрийг бичгээр буюу цахимаар гаргана”. гэж заасны дагуу “Ачигч автомашинуудын нэгдсэн холбоо” нь www.auto-ub.com цахим сайт болон Мобайль аппликейшнийг өөрийн хөрөнгө болох 180 сая төгрөгөөр хөгжүүлж Тээврийн цагдаагийн албатай 2020.02.02 өдөр байгуулсан 20/02 тоот хамтарч ажиллах гэрээ байгуулсан байна.

Уг гэрээний үндсэн дээр Улаанбаатар хотод Замын хөдөлгөөний дүрмийн 14.8 дэх заалт түр буюу удаан зогсохыг хориглосон газраас тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх зөвшөөрлийг өмнө нь Тээврийн цагдаагийн албаны 400 орчим цагдаагийн алба хаагч дээр төвлөрч ажилладаг байсныг цагдаагийн байгууллагын 2 алба хаагч дээр төвлөрүүлж өгснөөр цагдаагийн байгууллага болон Нийслэлийн татварын алба, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв /1800-1200 утасны дугаар/, Нийслэлийн авто замын хөгжлийн газар, Нийслэлийн мэдээллийн технологийн газар, Үндэсний дата төв гэх зэрэг төрийн байгууллагуудын цахим системтэй уялдаж нэгдсэн мэдээллийн сан үүссэн нь авилгалаас ангид байх, иргэдэд ил, тод нээлттэй болгосон бөгөөд Үндэсний дата төвийн ХҮР системтэй холбогдсоноор хуурамч улсын дугаар, эрэн сурвалжлагдаж байгаа тээврийн хэрэгслийг илрүүлэх ажил эрс сайжирсан байна.

Дээрх программ хангамжийн хамгийн том шийдвэрлэгдсэн асуудал нь иргэд, жолооч нарын гар утсанд зөөж шилжүүлсний дараа аль тээврийн хэрэгсэл түр саатуулах хашаа /байр/-нд байгаа талаарх мессеж цаг алдалгүй илгээдэг болсон нь иргэдэд хүндрэл, чирэгдэл учруулдаг байсныг бүрэн шийдвэрлэсэн бөгөөд Нийслэлийн мэдээллийн технологийн газрын www.smartcar.mn цахим системтэй холбогдож иргэдэд журамлагдсан тээврийн хэрэгслийн талаарх мэдээлэл нээлттэй болжээ.

Түүнчлэн, тусгай зориулалтын ачигч, чирэгч автомашинуудыг баазын дугаартай болгож нэгдсэн программд жолооч, техникийн ажилтан болон ачигч, чирэгч автомашинуудыг нэгдсэн мэдээллийн сантай болгосон нь зохих үр дүнгээ өгч эхэлжээ.

“Ачигч автомашинуудын нэгдсэн холбоо” Тээврийн цагдаагийн алба, Нийслэлийн авто замын хөгжлийн газартай хамтран хувийн хэвшлийн 14 аж ахуй нэгж, байгууллагад сар тутамд Замын хөдөлгөөний дүрэм болон, ёс зүйн сургалтыг оруулсанаар ажилтнуудаас гаргаж буй харилцааны ба ёс зүйн зөрчил буурах хандлагатай байна.

Нэгдүгээр эгнээнд байрлуулсан иргэдийн автомашины ачилтын төлбөрийг 100 мянган төгрөг болговол нийт жолооч нарын 73 хувь нь хаа хамаагүй газар машинаа байрлуулж түгжрэл үүсгэхгүй¹⁴⁶ гэх тооцоог энэхүү авто замын түгжрэлийг бууруулах шийдлийн судалгаанд дурджээ.

График №2¹⁴⁷



Одоо мөрдөгдөж буй журмаар зөвхөн иргэн, хувийн хэвшлийн хооронд харилцаа үүсээд байгаа юм. Гэтэл үүнд төрийн байгууллагын зохицуулалт дан ганц зөвхөн журмаар зохицуулагдана гэдэг нь ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.

Ачилтын компанийн ажилтан “Чанга яригчаар автомашины улсын дугаарыг дуудсаны дараа зөөн шилжүүлэхийн тулд бэхэлгээ татлага хийхээс авхуулаад процетурын ажил явагдана. Энэ хугацаанд жолооч гарч ирсэн тохиолдолд автомашиныг үнэ төлбөргүй буцаан олгоно. Харин зөөн шилжүүлж байхад жолооч

¹⁴⁶ Авто замын түгжрэлийг бууруулах шийдлийн судалгаа. УБ.2021

¹⁴⁷ <http://itoim.mn/article/X4kAG/31949>

ирвэл буцаан өгөхгүйгээр журмын хашаанд очиж байж асуудлыг шийдвэрлэнэ. Гэтэл иргэд автомашиныг нь ачаад гэрлэн дохио, уулзвар аль эсхүл түгжрэлд зогсч байхад хойноос нь гүйгээд ирдэг. Жолооч нар дүрэм зөрчихгүй байвал машин ачих, ачилтын компани байх шаардлагагүй. Замын хөдөлгөөний дүрмийг зөрчих тохиолдол багасахгүй байгаа учраас ачилтын компанийн үйл ажиллагаа ч зогсохгүй байгаа”¹⁴⁸ гэж хэлсэн байдаг.

Ачилтын компанийн ажилчид ачих машины дөрвөн талаас бичлэг хийж баримтжуулаад орчныг нь харуулсан зураг бичлэгийг Тээврийн цагдаагийн алба эсвэл Замын хөдөлгөөний удирдлагын төв рүү илгээхэд бичлэгийг нь шалгаад ачих эсэхийг нь шийднэ. Ачилтын компанийн илгээсэн автомашины зөрчлийг цагдаагийн алба хаагч хараад замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн эсэхийг тогтооно. Зөрчсөн бол зөвшөөрлийг нь цахимаар өгнө. Зөвшөөрөл өгөх үед ямар компанийн аль ачигч автомашинаас хүсэлт ирж байгаа нь харагдахгүй. Зөвхөн тухайн ачуулах гэж байгаа автомашины мэдээлэл л ирнэ. Харин зөвшөөрөл өгөх юм уу татгалзсаны дараа аль компанийн ямар автомашин гэдгийг харах боломжтой юм байна.

Өнөөдөр НИТХ, Засаг дарга болон Нийслэлийн авто замын газраас ажлын хэсэг гарган автомашин ачилтын журамд оруулах өөрчлөлтүүдийг боловсруулж байна. Ажлын хэсгээс гаргаж буй зарим саналуудыг түүвэрлэн авч үзвэл нэгдүгээр эгнээ болон автомашин зогсоохыг хориглосон байршлуудад автомашинаа байрлуулсан тохиолдолд олон нийтийн байцаагч ажиллана. Ачигч машин ирэхээс өмнө олон нийтийн байцаагч тухайн автомашины жолооч руу мэдэгдэн Зөрчлийн тухай хуулиар торгууль тавина. Тухайн торгууль тавьж буй мөнгө нь төрд төвлөрнө. Харин тэр хугацаанд жолооч амжиж автомашинаа аваагүй тохиолдолд ачилтын компани ачих ёстой гэсэн өөрчлөлтийн саналыг ажлын хэсгээс гаргаж байгаа юм байна.

Дүгнэлт

Улаанбаатар хот өнөөдөр хурдацтай хөгжиж, өргөжин тэлэхийн хэрээр хотжилтыг дагасан асуудлууд нэмэгдэж, шийдвэрлэх бололцоо нь улам бүр бэрхшээлтэй болж байна. Агаар, хөрс, орчны бохирдол зэргээс гадна замын түгжрэл нь нийслэлийн өмнө тулгамдаж буй хамгийн гол асуудлын нэг болжээ.

Түгжрэлийг бууруулах чиглэлээр нутгийн захиргааны байгууллагаас цөөнгүй ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлсэний нэг нь хориглосон газар зогсож, зөрчил гаргасан тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх ажил байсан боловч иргэдийн шүүмжлэлтэй тулгарч байна.

Машин ачилтийн компанийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт машин ачихтай холбоотой харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байгаа нь тогтоогдов.

Санал

Нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулах, машин ачилтын компанийн үйл ажиллагааг сайжруулах үүднээс дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1.Технологийн дэвшил түгжрэл бууруулахад дэмжлэг үзүүлэх;

Технологийн дэвшлийг ашиглан замын түгжрэлийн мэдээллийг зорчигчдод тогтмол хүргэхийн зэрэгцээ нийслэлийн хөдөлгөөнд орж байгаа бүх тээврийн хэрэгсэлд GPS болон FM радио байгааг ашиглан нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлбэл түгжрэл буурах боломжтой.

2.Нийтийн тээврийн үйлчилгээг чанаржуулах

Нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээг чанаржуулан боловсронгуй болгосноор хувийн автомашинаар зорчих хөдөлгөөнийг буурна.

¹⁴⁸<https://www.moto.mn/news/163179644072392>

3.Хувийн таксиний үйлчилгээг журамлах;

Хувийн таксины үйлчилгээг эрх зүйн журамлаж, нэгдсэн тогтолцоо бий болгож, дуудлагын журамд оруулснаар үйлчлүүлэгч хайж хотын төвөөр сэлгүүцэх нь багасна.

4.Унадаг дугуйгаар зорчих орчин нөхцлийг бүрдүүлэх;

Унадаг дугуй болон явганаар авто замын хөдөлгөөнд оролцох нөхцлийг бүрдүүлсэнээр эрүүл мэнд болон эдийн засгийн үр өгөөжтэй алхам болно.

5.Машин ачилтын компанийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах;

Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх, түр саатуулах журам болон Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх ажил, үйлчилгээг гүйцэтгүүлэх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах замаар өнөөдрийн зөрчилдөөнт асуудлыг арилгах, машин ачилтын компаний ажилтны ажлын арга зүйг өөрчлөх талаар зохицуулалт нэмж тусгах шаардлагатай байна.

6.Авто замын хөдөлгөөнд саад учруулсан тээврийн хэрэгслийг зөөн шилжүүлэхдээ жолоочийн утас руу ачих болсон үндэслэл болон хаана хүргэх талаар мэдээлэл явуулж, 15 минут өнгөрсөний дараа эзэмшигч ирэхгүй бол ачих зохицуулалтыг тусгах;

7.Машин ачилтын компанийн ажилтны харилцаан дээр анхаарч, байгууллагын дотоод журамд ажилтны ёс зүйн харилцааг зохицуулсан заалтыг нэмж тусгах зэрэг болно.

Ашигласан материал

Монгол Улсын хууль тогтоомж:

1. Цагдаагийн албаны тухай хууль
2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
3. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 239 дугаар тогтоол

Судалгаа, тайлан мэдээ:

1. Авто замын түгжрэлийг бууруулах шийдлийн судалгаа. УБ.2021
2. Нийслэлийн авто замын хөгжлийн газрын танилцуулга. УБ.2021

Сонин, сэтгүүл:

1. Төрийн мэдээлэл. 2017. №8.
2. Төрийн мэдээлэл. 2015. №28.

Цахим эх сурвалж:

1. <https://www.1212.mn>
2. <http://eagle.mn>
3. <http://itoim.mn>
4. <https://legalinfo.mn>
5. <https://www.moto.mn>

ЗӨРЧИЛ ГАРГАСАН СОГТУУРСАН ЭТГЭЭДИЙГ ЭРҮҮЛЖҮҮЛЭХ НЬ ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ БОЛОХ НЬ

*Н.Сайнбаяр
ДХИС-ийн докторант, цагдаагийн хошууч*

Товч агуулга. Цагдаагийн байгууллагаас зөрчил гаргасан, архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн этгээдийг эрүүлжүүлэх байранд хүргэж байгаа нь хууль зөрчиж буй үйл ажиллагаа эсэх талаар судалж тодорхой дүгнэлт боловсруулж, санал дэвшүүлсэн.

Түлхүүр үг. Зөрчил, хүний эрх, эрүүлжүүлэх.

Үндсэн хэсэг

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гэж 18 эрхийг тунхагласан байдаг. Уг зүйлийн 13 дахь хэсэгт “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална” гэж заасан. Өөрөөр хэлбэл, хуульд заасан үндэслэл тогтоогдоогүй байхад, эрх хязгаарлах журмыг баримтлахгүйгээр дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно гэсэн Үндсэн хуулийн зарчим зохицуулалт юм.

Иргэний халдашгүй чөлөөтэй байх эрх-ийн хамгийн чухал гол баталгаа бол эрх бүхий байгууллага, албан тушаалтны зүгээс хулийн үндэслэл нотолгоогүйгээр баривчлахгүй, хорихгүй, эрх чөлөөг нь хязгаарлахгүй, нэгжихгүй байх явдал юм¹⁴⁹.

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл хэргийн тэргүүн эгнээнд цагдаагийн байгууллага ажилладаг бөгөөд цагдаагийн байгууллаганы үйл ажиллагаа хүний эрхэт суурилсан эсэхээс хамаарч Монгол Улсад хүний эрхийн хэрэгжилтийн байдал бас давхар хамаарна.

Цагдаагийн байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа шаардлагатай тохиолдолд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлдэг. Энэ ч утгаараа цагдаагийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээлэл ихээр бүртгэгддэг. Аливаа үйл ажиллагааны дэс дараалал, хэрэгжих тохиолдлыг тодорхой байлгах тусам учрах эрсдлийг багасгаж, цаашлаад хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөх явдлаас сэргийлэх ач холбогдолтой.

Цагдаагийн байгууллагын зарим үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөж буй эсэхэд хуульч, судлаач хүний хувьд тогтмол судалгаа хийж хүний эрхийн зөрчил үүсгэж буй багагүй хэм хэмжээг тодорхойлсон билээ.

Практикт хэвшмэл шинжтэй үйл ажиллагаа нь хүнийг эрх зөрчиж байгаа эсэхэд төдийлөн анхаарал хандуулахгүйгээр, ингэх л ёстой, угаасаа ингэж ажилладаг гэх байдлаар хандаж хүний эрхийг зөрчих эрсдэлтэй. Ялангуяа шинэ залуу алба хаагчдын хувьд урьд ажиллаж байгаа алба хаагчдын хийж гүйцэтгэж байгаа үйл ажиллагааг дадал болгон гүйцэтгэж, үүнийгээ хууль, эрх зүйд хэрхэн нийцэж байгаад

¹⁴⁹ Б.Мишигдорж. Эрүүлжүүлэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах нь. Хууль сахиулах салбарын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. 2014 он. 71 дэх тал.

төдийлөн ач холбогдол өгөхгүй байгаагаас хууль зөрчсөн үйлдэл уламжлагдан амь бөхтэй оршоор байна.

Үүний тод жишээ нь зөрчил гаргасан согтуурсан этгээдийг эрүүлжүүлэх үйл ажиллагаа юм. Энэ бол ямар ч хуульд заагаагүй, үндэслэлгүй үйл ажиллагаа бөгөөд цагдаагийн алба хаагчдыг гэмт хэрэг үйлдэх эрдслийг бий болгож байгаа нь энэхүү сэдвийг сонгох болсон үндслэл болно.

Зарим алба хаагчид гайхаж магадгүй, яагаад зөрчил гаргасан согтуурсан этгээдийг эрүүлжүүлэх нь хууль зөрчсөн үйлдэл болдог байна гэж.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх ажиллагааг хуулиар зохицуулна” гэж заасны дагуу УИХ-аас 2003 оны 11 сарын 07-ны өдөр “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай” хуулийг баталжээ.

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Өөрийн үйлдлийг удирдан хянах чадваргүй болтлоо согтсоны улмаас хаана байгаагаа болон очих газраа мэдэхгүй болсон, гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасан, энэ байдлаас болж өөрөө осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй болсныг үндэслэл болгон цагдаагийн алба хаагч тухайн этгээдийг хамгаалах, тусламж үзүүлэх зорилгоор эрүүлжүүлэх байранд хүлээлгэн өгнө” гэсэн тодорхой заалттай. Энэ заалтад заасанчлан зөвхөн өөрийн үйлдлийг хянах болон биеэ авч явах чадваргүй, ухаангүй унасан, энэ байдлаасаа болж гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй хүнийг л эрүүлжүүлэх байранд хүргэх хуулийн зохицуулалттай байна.

Гэтэл цагдаагийн байгууллагад ихэвчлэн ирж буй дуудлага мэдээлэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй байхаас гадна, зөрчил үйлдсэн этгээдүүд нь архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн байх нь түгээмэл бөгөөд тухайн этгээдүүдийг дуудлагаар очсон алба хаагчид тэмдэглэл үйлдэж, эрүүлжүүлэх байранд хүргэн өгч хэвшжээ. Энэ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 02 сарын 02-ны өдрийн А/44 дугаартай тушаалаар баталсан Албадан эрүүлжүүлэх журам код-629-тэй шууд холбоотой. Уг журмын 629.7.3 дахь хэсэгт “Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зөрчил гаргасан этгээдийн зөрчлийг нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай, илэрмэгц газар дээр нь шийдвэрлэх боломжгүй тохиолдолд согтолт /алкогол/-ын хэмжээ харгалзахгүй эрүүлжүүлэх байранд хүлээн авна гэж заасан.

Өөрөөр хэлбэл, хуулийн зохицуулалтаас давсан журмын хэм хэмжээ цагдаагийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшмэл байдлаар өдийг хүрчээ. Нөгөө талаас иргэнийг албадан эрүүлжүүлэхтэй холбоотой аливаа харилцааг хуулиар зохицуулна гэж заасан байхад байгууллагын даргаас баталсан журмын дагуу ажиллаж байгаа нь алба хаагчдыг гэмт хэрэг, зөрчил үйлдэх эрсдлийг бий болгосоор байна.

Зарим алба хаагчид тухайн зөрчил гаргасан согтуу хүнийг эрүүлжүүлэх байранд хүргэх боломжгүй гээд орхиод явахаар бүр хүнд хор уршиг бүхий үйл явдал болвол яах вэ гэж асуулт тавьдаг. Гэтэл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 1.2 дэх хэсэгт “цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч зөрчил үйлдсэн согтуурсан, мансуурсан холбогдогчийг 24 цаг хүртэл хугацаагаар” саатуулж болох талаар зааж өгсөн бөгөөд энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу зөрчил үйлдсэн этгээдийг түр саатуулах арга хэмжээ авна. Үүнтэй холбоотойгоор мөн ЦЕГ-ын даргын 2020 оны 07 сарын 07-ны өдрийн А/169 дугаартай Түр саатуулах журам код-225 байдаг ба энэ нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурортой

хамтран батална” гэсэнтэй зөрчилддөг. Өөрөөр хэлбэл, түр саатуулах журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд болон УЕП-той хамтарсан тушаалаар баталгаажуулна гэсэн хуулийн зохицуулалттай байхад ЦЕГ-ын дарга энэ харилцааг зохицуулсан журам батлаж, цагдаагийн байгууллага үйл ажиллагаанд баримтлаж байгаа нь хууль бус гэж үзэх үндэслэлтэй.

Цагдаагийн албан хаагч хэдийгээр хойшлуулшгүйгээр зөрчил гаргасан этгээдийг эрүүлжүүлэх байранд хүргэж, нийгмийн эрх ашгийн төлөө үүргээ гүйцэтгэж байна гэж ойлгож болох ч Үндсэн хуулийн зарчмын үүднээс ямар ч зөрчил үйлдсэн хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах үйлдлийг зөвтгөх боломжгүй юм.

2020 онд цагдаагийн байгууллага 93863 хүнийг эрүүлжүүлснээс 71683 хүнийг зөрчил гаргасан үндэслэлээр эрүүлжүүлжээ¹⁵⁰. Энэ бүгдээс үзэхэд, цагдаагийн албан хаагчид, ялангуяа зөрчлийн дуудлага мэдээлэл дээр ажиллаж байгаа алба хаагчид хууль хэрэглэх чадвар дутмагаас хүний эрх, эрх чөлөөнд үндэслэл, журмаас гадуур халдсан гэж үзэж үндэслэлтэй байна.

Энэ нь цаашлаад Эрүүгийн хуулийн 13.9 дүгээр зүйл /Хууль бусаар баривчлах, саатуулах/-д заасан гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэл ч болох талтай. Уг зүйлийн 1 дэх хэсэгт- эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний эрх чөлөөнд халдсан, баривчилсан, саатуулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр тодорхой заасан. Диспозицид тусгагдсан “хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний эрх чөлөөнд халдсан” гэдэг нь Согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 5.1 дэх хэсэгт заасан үндэслэл тогтоогдоогүй байхад зөрчил гаргасан гэх үндэслэлээр архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, биеэ авч явах чадвартай этгээдийг эрүүлжүүлэх байранд хүргэснээр, Үндсэн хуульд заасан халдашгүй байх болон чөлөөтэй зорчих эрхэнд халдаж буй байдал юм.

Өдөр тутамдаа хэвийн юм шиг явж байгаа боловч алсдаа цагдаагийн алба хаагчид дээрх үйлдэлдээ эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэл болоод бусад хор уршиг учрах эрсдлийг бий болгож байна.

Дүгнэлт

Цагдаагийн алба гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хуульд заасан шаардлагад нийцүүлэн гүйцэтгэж байгаа хэдий ч зарим салбар үйл ажиллагаанд хуулийг тэр тусмаа хүний эрх, эрх чөлөөг хангах зарчмыг баримтлах зайлшгүй шаардлагатай байна.

Мөн цагдаагийн байгууллагын албан хаагчдын үйл ажиллагаа, тэр дундаа хүний эрхийг хязгаарлах шинжтэй арга хэмжээг практикт тогтсон хэвшмэл байдлаар гүйцэтгэж байгаа нь өөрсдийн үйлдлийн учир холбогдлыг хайхрахгүй байдлыг бий болгож улмаар гэмт хэрэг, зөрчилд орох эрсдлийг бий болгож байна.

Зөрчил гаргасан согтуурсан этгээдийг эрүүлжүүлэх байранд хүргэж байгаа нь Үндсэн хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийг зөрчиж буй үйл ажиллагаа бөгөөд цаашдаа хууль зүйн үндэслэлтэй хэм хэмжээг бий болгож мөрдүүлэх шаардлагатай байна.

¹⁵⁰ ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны “2020 оны гэмт хэргийн статистик мэдээлэл” эмхэтгэл УБ.,2021 он.

Санал

Зөрчил гаргасан согтуурсан этгээдийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу саатуулах арга хэмжээг авч хэвших. Энэ чиглэлээр мэргэжлийн байгууллагаар сургалт зохион байгуулах.

ЦЕГ-ын даргын баталсан 225, 629 дугаар журмуудыг хүчингүй болгож Согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль. 2000 он.
3. Согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль. 2003 он.
4. Эрүүгийн хууль. 2015 он.
3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. 2017он.
4. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 07 сарын 07-ны өдрийн А/169 дугаартай тушаалаар баталсан Түр саатуулах журам код-225.
5. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 02 сарын 02-ны өдрийн А/44 дугаартай тушаалаар баталсан Албадан эрүүлжүүлэх журам код-629.
6. ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны “2020 оны гэмт хэргийн статистик мэдээлэл” эмхтгэл УБ.,2021 он.
7. Б.Мишигдорж. Эрүүлжүүлэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах нь илтгэл// Хууль сахиулах салбарын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. 2014 он. 71 дэх тал.